

Монгол Улс
Боловсрол, Шинжлэх Ухааны Яам

Монгол Улс
Япон-Монгол сургалтын эмнэлгийн
менежмент, тусламж үйлчилгээг хөгжүүлэн
төгөлдөржүүлэх төсөл


Үйл ажиллагааны эцсийн тайлан
(2 дах үе)

2022 оны 10 дугаар сар

Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага
(ЖАИКА)

Төрийн өмчит Токүшимагийн Их сургууль
Төрийн өмчит Эхимэгийн Их сургууль
“Koei Research & Consulting” ХК

НМ
JR
22-077



Төсөл хэрэгжсэн байршлын зураг

Зураг

“Монгол дахь үйл ажиллагаа”



2019 оны 6-р сарын 16-ны өдөр Япон Улсын Засгийн газраас Гадаад харилцааны сайд Коно, Монгол Улсын Засгийн газраас Ерөнхий сайд У.Хүрэлсүх нар оролцсон МЯЭ-ийн үйл ажиллагааг эхлэхэд чиглэсэн нээлтийн арга хэмжээ зохион байгуулагдсан.



МЯЭ-т амбулаторийн тусламж үйлчилгээг эхлүүлэх бэлтгэлийн хүрээнд олон удаа симуляци хийсэн. Зураг: 2019 оны 5-р сард Японы мэргэжилтэн тус улсад томилогдон ажиллах үеэр заавар зөвлөгөө өгч буй байдал.



2019 оны 10-р сарын 1-ний өдөр амбулаторийн тусламж үйлчилгээг эхлүүлсэн. Зураг: тусламж үйлчилгээг эхлүүлэх нээлтийн ёслолын байдал.



2020 оны 6-р сарын 4-ний өдөр 4 дэх удаагийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. Шинэ төрлийн Коронавирусын халдварын цар тахлын улмаас цахимаар зохион байгуулсан. Зураг: Монгол талын оролцогч нар.



2020 оны 7-р сараас 8-р сард МЯЭ-ийн захиргааны ажилтан нарт эмнэлгийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг бэхжүүлэх талаарх сургалтыг зохион байгуулсан.



2020 оны 9-р сарын 7-ний өдөр МЯЭ-ийн дотрын ХЭТ, ЭЭТ-ийн үйл ажиллагааг эхлүүлж, хэвтэн эмчлүүлэгч хүлээн авч эхэлсэн. Зураг: Цахим тойролтоор бэлтгэлийг шалгаж буй байдал.



2021 оны 10-р сарын 1-ний өдөр 5 дахь удаагийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. Шинэ төрлийн Коронавирусийн халдварын цар тахлын улмаас цахим болон танхим буюу хаибрид хэлбэрээр зохион байгуулсан. Зураг: Япон талын оролцогч нар.



2022 оны 4-р сарын 26-ны өдөр Үйлчлүүлэгч дэмжих алба болон Сувилахуйн алба, ХЭТ-ийн ахлах сувилагч нартай Өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэхэд чиглэсэн хамтарсан хурал зохион байгуулж буй байдал.



Долоо хоног бүр тогтмол зохион байгуулдаг ХСХА-ны ICT тойролт хийж буй байдал. Зураг: 2022 оны 6-р сард Япон зөвлөх багш нар заавар зөвлөгөө өгч буй байдал.



2022 оны 6-р сард Эмнэлгийн мэдээллийн систем(ИТ)-ийн зөвлөх багш Радиологийн тасагт ажиллаж буй байдал.



2022 оны 6-р сард Ангиографийн тоног төхөөрөмжийг ашиглах сургалтын байдал. МЯЭ болон УГТЭ-ийн эмч нар оролцон эмнэлэг хоорондын уялдаа холбоог хэрэгжүүлж байна.



2022 оны 6-р сарын 28-ны өдөр Халдварын сэргийлэлт, хяналтын сургалтыг зохион байгуулсан. Улсын хэмжээнд байгууллага бүрээс 150 гаруй хүмүүс оролцсон. Зураг: МЯЭ-ийн ерөнхий захирлын зүгээс илтгэл тавьж буй байдал.



2022 оны 7-р сард эмнэлзүйн шинжилгээ, эмнэлзүйн инженер, радиологийн шинжилгээний зөвлөх багш нар Монгол дахь сургалтаар дүгнэлт хийж хуралдаж буй байдал.



2022 оны 9-р сард ТИС-ийн эмнэлзүйн тасаг бүрийн багш нарын ЯТ-ийн семинарын байдал. Семинарыг цахим болон танхим буюу хаибрид хэлбэрээр зохион байгуулсан.



2022 оны 9-р сарын 14-ний өдөр 6 дахь удаагийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. Зураг: АШУҮИС-ийн захирлын зүгээс илтгэл тавьж буй байдал.



6 дахь удаагийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурлаар төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн тайлан болон төслийн үйл ажиллагаа дуусах буйг Монгол, Япон тал шалгасан. Зураг: Оролцогч нар.

“Япон дахь сургалт”



10 дахь удаагийн сургалт (2019/11/18-11/22)-нд хагалгааны үйл ажиллагаанд холбоо хамаарал бүхий тасаг нэгжийн 8 ажилтан оролцсон. Зураг: Хагалгааны симуляциар ТИСЭ-ийн зөвлөх багштай санал солилцож буй байдал.



ТИСЭ-ийн Хагалгааны сургалтаар хагалгааны өмнөх бэлтгэл, хагалгааны тасгийн 1 өдрийн үйл ажиллагааг ажиглаж, МЯЭ-ийн хагалгааг эхлүүлэх бэлтгэл төлөвлөгөөг боловсруулсан.
(10 дахь удаагийн сургалт: 2019/11/18-11/22)



ТИСЭ-т угаалга, халдваргүйжүүлэг, ариутгалын үйл явц, хог хаягдлыг ангилах, хаях зэргийг ажиглаж МЯЭ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. (10 дахь удаагийн сургалт: 2019/11/18-11/22)



11 дэх удаагийн сургалт (2019/11/25-11/29)-нд ҮДА 3, ЭЭТ 2 ажилтан оролцож ТИСЭ-т ажиглалт хийж, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Зураг: Олон мэргэжлийн багийн хэлэлцүүлэгт оролцон ажиглалт хийж буй байдал.



ҮДА-ны сургалтаар тус төвийн ач холбогдол, үүргин талаарх лекц, санал солицох хурлыг зохион байгуулж МЯЭ-ийн ҮДА-ны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан. (11 дэх удаагийн сургалт: 2019/11/25-11/29)



ЭЭТ-ийн сургалтаар өвчтөнийг хүлээн авахын өмнөх бэлтгэл, орчин бүрдүүлэлт, сувилахуйн үйл ажиллагаа, шаардлагатай холбогдох бичиг баримт, мануал зэргийг ажиглан, МЯЭ-ийн ЭЭТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлд хамаарах төлөвлөг боловсруулсан. (11 дэх удаагийн сургалт: 2019/11/25-11/29)



2022 оны 8-р сарын 27-ний өдөр 12 дахь удаагийн сургалтыг 9 ажилтныг оролцуулан зохион байгуулсан. Зураг:ТИСЭ-ийн Ур чадварын лабораторид зочлон, дадлага хийж буй байдал.



ЭИСЭ-ийн Шим тэжээлийн албанд зочлож буй байдал. Тасаг нэгж бүрийн халдварын сэргийлэлт, хяналт, үйл ажиллагааны менежмент зэргийг суралцаж, идэвхтэй санал солилцсон. (12 дахь удаагийн сургалт: 2022/08/17-08/24)

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Англи хэлээр	Монгол хэлээр
ADB	Asian Development Bank	Азийн Хөгжлийн Банк
CHD	Center for Health Development	Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв
C/P	Counter Part	Хамтрагч тал
CT	Computerized Tomography	Компьютер томограф
DHCP	Dynamic Host Configuration Protocol	Динамик Хостын Тохиргооны Протокол
ERP	Enterprise Resource Planning	Байгууллагын Нөөц Төлөвлөлт
HIS	Hospital Information System	Эмнэлгийн Мэдээллийн Систем
ICU	Intensive Care Unit	Эрчимт Эмчилгээний Тасаг
IT	Information Technology	Мэдээллийн Технологи (Эмнэлгийн мэдээллийн хяналтын систем)
ISO	International Organization for Standardization	Олон улсын стандартчиллын байгууллага
JCC	Joint Coordination Committee	Хамтарсан Зохицуулах Хороо
JICA	Japan International Cooperation Agency	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага
KRC	Koei Research and Consulting Ltd.	Коэи Рисерч Консалтинг ХК
LIS	Laboratory Information System	Лабораторийн мэдээллийн систем
ME	Medical Engineering	Медикал инженерчлэл
MEDS	Ministry of Education and Science	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
MNT	Mongolian Tugrik	Монгол төгрөг (мөнгөн тэмдэгт)
MNUMS	Mongolian National University of Medical Sciences	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
MOH	Ministry of Health	Эрүүл Мэндийн Яам
MRI	Magnetic Resonance Imaging System	Соронзон Резонанст Томограф
NCDs	Non-Communicable Diseases	Халдварт бус өвчин
OJT	On the Job Training	Ажлын байран дээрх сургалт (дадлага, сургуулилт)
PACS	Picture Archiving and Communication System	Эмнэлгийн дүрс зургийн хяналтын систем
PC	Personnel Computer	Компьютер
PDM	Project Design Matrix	Төслийн Төлөвлөлтийн Матриц
R/D	Record of Discussions	Хэлэлцэж ярилцсан хурлын тэмдэглэл
RIS	Radiology Information System	Дүрс оношилгооны мэдээллийн систем
SPD	Supply Processing and Distribution	Нийлүүлэлт, хангамж, түгээлт/алба

Монгол Улс
Япон-Монгол сургалтын эмнэлгийн менежмент, тусламж үйлчилгээг
хөгжүүлэн төгөлдөржүүлэх төсөл
Үйл ажиллагааны эцсийн тайлан (2 дах үе)

Гарчиг

Төсөл хэрэгжсэн байршлын зураг

Гэрэл зураг

Товчилсон үгсийн жагсаалт

1.	Төслийн үндсэн мэдээлэл	1
1.1	Хэрэгжсэн улс	1
1.2	Төслийн нэр.....	1
1.3	Төсөл хэрэгжсэн хугацаа	1
1.4	Төсөл хэрэгжүүлэх үндэслэл.....	1
1.5	Төслийн тэргүүлэх зорилт, төслийн зорилт, үр дүн	2
1.5	Хэрэгжсэн бүс нутаг	6
1.6	Холбогдох яам, байгууллагууд.....	6
2.	Төслийн үйл ажиллагааны бодит гүйцэтгэл	7
2.1	Үйл ажиллагааны бодит гүйцэтгэл.....	7
2.1.1	Япон талын оролцоо, гүйцэтгэл	7
2.1.2	Монгол талын оролцоо, хамтын ажиллагаа	14
2.1.3	Үйл ажиллагаа (төлөвлөлт болон гүйцэтгэл).....	19
2.2	Төслийн хүрсэн үр дүн	55
2.2.1	Үр дүн ба шалгуур үзүүлэлт	55
2.2.2	Төслийн зорилт ба шалгуур үзүүлэлт.....	58
2.2.3	Нэгдсэн үнэлгээ	59
3.	ТТМ-д өөрчлөлт оруулсан явц.....	61
4.	Бусад	63
4.1	Байгал орчин, нийгмийн нөлөөллийг анхаарах нь	63
4.2	Жендер, энх тайвныг тогтоох болон ядуурлыг бууруулах зэргийг анхаарах нь.....	63
5.	Төслийн үнэлгээ	65
5.1	DAC үнэлгээний стандартад суурилсан үнэлгээний дүн	65
5.2	Хэрэгжүүлэлт болон үр дүнд нөлөөлсөн чухал хүчин зүйлүүд	74
5.3	Төслийн эрсдлийн менежментийн үнэлгээ ба үр дүн	75
5.4	Сургамж ба зөвлөмж	77
5.5	Гүйцэтгэл.....	83

6.	Тэргүүлэх зорилтыг биелүүлэхийн тулд	85
6.1	Тэргүүлэх зорилтыг биелүүлэх боломж	85
6.2	Тэргүүлэх зорилтод хүрэхийн тулд монгол талын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт	87
6.3	Монгол талд хүргэх зөвлөмж.....	87
6.4	Төсөл өндөрлөхөөс хэрэгжилтийн дараах үнэлгээ хүртэлх мониторингийн төлөвлөлт	89

Зураг

Зураг 1	ЯМЭ-ийн бүтэц.....	15
Зураг 2	АШУҮИС-ийн бүтэц.....	17
Зураг 3	ЯМЭ-ийн HIS-ийн нийт бүрэлдэхүүн хэсгийн концепцийн диаграмм.....	31
Зураг 4	Тэргүүлэх зорилтод хүрэх төсөөллийн зураглал.....	85

Хүснэгт

Хүснэгт 1	Төслийн тэргүүлэх зорилт, зорилт, үр дүн зэрэг (зассан хувилбар).....	2
Хүснэгт 2	Төслийн үйл ажиллагаа	4
Хүснэгт 3	Япон мэргэжилтний бүрэлдэхүүн (нэг дэх үе: 2017.02-2019.04).....	7
Хүснэгт 4	Япон мэргэжилтний бүрэлдэхүүн (хоёр дах үе: 2019.05-2022.10).....	10
Хүснэгт 5	Олгосон тоног төхөөрөмжийн жагсаалт.....	13
Хүснэгт 6	АШУҮИС-ийн хэрэгжүүлдэг сургалтын ерөнхий танилцуулга	21
Хүснэгт 7	Санхүүгийн цахим сургалт	23
Хүснэгт 8	2020 оны төсөв (Төлөвлөсөн дүн, батлагдсан дүн, засварласан дүн).....	24
Хүснэгт 9	2021 оны төсөв (Төлөвлөсөн дүн, батлагдсан дүн, засварласан дүн).....	24
Хүснэгт 10	2022 оны төсвийн төлөвлөгөө	25
Хүснэгт 11	Япон дах 11 дэх удаагийн сургалтын ерөнхий танилцуулга (Өвчтөн дэмжих төв)	27
Хүснэгт 12	Axis Karte дахь HIS модуль.....	31
Хүснэгт 13	SPD сургалтын талаарх ерөнхий мэдээлэл.....	34
Хүснэгт 14	Япон дах 10 дах удаагийн сургалтын ерөнхий танилцуулга (хагалгааны тасаг).....	38
Хүснэгт 15	Эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээний талаарх сургалтын ерөнхий танилцуулга	39
Хүснэгт 16	Симуляцийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн	41
Хүснэгт 17	СТ-н нэмэлт аппликэшн сургалт (монгол туслан гүйцэтгэгчээр хийлгүүлсэн)-ын ерөнхий танилцуулга	47
Хүснэгт 18	MRI-н нэмэлт аппликэшн сургалт (монгол туслан гүйцэтгэгчээр хийлгүүлсэн)-ын ерөнхий танилцуулга	47
Хүснэгт 19	Ангиографийн аппликэшн сургалт (монгол туслан гүйцэтгэгчээр	

хийлгүүлсэн)-ын ерөнхий танилцуулга	48
Хүснэгт 20 Япон дах 11 дэх удаагийн сургалтын ерөнхий танилцуулга (ЭЭТ)	51
Хүснэгт 21 Үр дүнд хүрсэн байдал	56
Хүснэгт 22 Үр дүнгийн биелэлтийн байдал	58
Хүснэгт 23 ТТМ-д оруулах өөрчлөлт	61

Хавсралт материал

Хавсралт 1 Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл	AN-1
Хавсралт 1-1 Мэргэжилтэн томилон ажиллуулсан гүйцэтгэл	AN-1
Хавсралт 1-2 Хамтрагч тал	AN-3
Хавсралт 1-3 Японд зохион байгуулсан сургалтын гүйцэтгэл	AN-5
Хавсралт 1-4 Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө (өөрчилсөн хувилбар)	AN-6
Хавсралт 1-5 Үйл ажиллагааны зураглал	AN-7
Хавсралт 1-6 Эмнэлзүйн гүйцэтгэлийн харьцуулсан хүснэгт (жишээ)	AN-8
Хавсралт 1-7 Болзошгүй эгзэгтэй тохиолдол, тохиолдлын формат	AN-18
Хавсралт 2 Боловсруулсан материалын жагсаалт	AN-20
Хавсралт 3 Төслийн нсан тэй тохиолдо	AN-22

1. Төслийн үндсэн мэдээлэл

1.1 Хэрэгжсэн улс

Монгол Улс

1.2 Төслийн нэр

Япон-Монгол сургалтын эмнэлгийн менежмент, тусламж үйлчилгээг хөгжүүлэн төгөлдөржүүлэх төсөл

1.3 Төсөл хэрэгжсэн хугацаа

- Үндсэн гэрээ: 2017 оны 2-р сараас 2022 оны 1-р сар (нийт 60 сар)
- Өөрчлөлт оруулсан гэрээ: 2017 оны 2-р сараас 2022 оны 10-р сар (нийт 69 сар)
 - Нэгдүгээр шат: 2017 оны 2-р сараас 2019 оны 4-р сар
 - Хоёрдугаар шат: 2019 оны 5-р сараас 2022 оны 10-р сар

Шинэ төрлийн корона вируст халдварын улмаас 2020 оны 3-р сараас 2021 оны 2-р сар хүртэлх хугацаанд хилээр нэвтрэх хориг тависны нөлөөгөөр хугацааг сунгасан (2021 оны 10-р сарын 1-ний өдрийн 5 дах удаагийн Хамтарсан зохицуулах хорооны хурлаар санал нэгдсэн)

1.4 Төсөл хэрэгжүүлэх үндэслэл

Монгол Улсын (цаашид “монгол” гэх) нярайн эндэгдэл (мянган амьд төрөлтөд) 2005 онд 34,9% байснаас 2015 онд 19% болж, жирэмсэн эхийн нас баралт (100 мянган төрөлтөд) 95-аас 44 болж, тус бүр буурах¹ зэргээр нийт улсын хэмжээнд эрүүл мэндийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд сайжирч байна, Гэвч, хөдөө орон нутагт ажиллах эмч нараас авахуулаад эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын чанар доогуур, мөн орон нутгийн эмнэлгийн байгууллагын тоног төхөөрөмж, хэрэгслийн хангалтгүй байдал зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан орон нутгийн анхан шатны болон хоёрдогч шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь эрүүл мэндийн салбарын тулгамдаж буй асуудал болоод байна. Монгол Улсын ЗГ нь эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын ур чадавхыг бэхжүүлэхээс эхлүүлэн олон янзын бодлогын хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо болон сургалтын хөтөлбөр гэх мэтчилэн сургалтын тогтолцоо, сургалтын орчин хангалттай бүрдээгүй байна.

Эдгээр тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд, Япон-Монгол сургалтын эмнэлгийг² (цаашид ЯМСЭ гэнэ) барьж байгуулах (104 ортой)-ын тулд буцалтгүй тусламжийн хамтын ажиллагаа (2014-2019 он)-г хэрэгжүүлсэн. ЯМСЭ нь АУС, ЭТҮ-ний технологийн салбарууд (сувилахуйн, эх баригчийн, эмнэлзүйн лабораторийн тэнхим зэргийг

¹ Дээрх тоо, баримтуудыг “World Bank, World Development Indicators (WDI), June 2016”-с ишлэв.

² 2016.09.23-нд гарын үсэг зурсан R/D (Record of Discussion)-д ЯМСЭ, дараа нь БСШУС-ын Сайдын тушаал (2020.07.01 А/307 тоот) –д “АШУҮИС-ийн ЯМЭ” болсон.

багтаасан) бүхий монголд ганц байгаа төрийн өмчит анагаах ухааны их сургууль болох Монгол Улсын АШУҮИС (Mongolian National University of Medical Sciences, цаашид “MNUMS” гэнэ)-ийн удирдлага дор үйл ажиллагаа явуулж байна. ЯМЭ нь ирээдүйд эрүүл мэндийн ажилтнуудын төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын бааз суурь байхын зэрэгцээ сүүлийн үед нэмэгдэх хандлагатай байгаа халдварт бус өвчин (Non-Communicable Diseases, цаашид ХБӨ гэх) болох тархины судасны өвчнүүд, хорт хавдар зэргийг оношилж, эмчлэх өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг түшиц болохынхоо хувьд монголын эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад хувь нэмрээ оруулна гэж найдвар хүлээж байгаа юм.

Гэвч, ЯМЭ-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч байгууллага болох АШУҮИС нь 25 ортой харъяа нэгдсэн эмнэлэг (цаашид АШУҮИС-ийн Нэгдсэн эмнэлэг гэх)-ийг л ажиллуулж байснаас өөр туршлагагүй, сургалтын эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагүй байв. Иймд, ЯМЭ нь сургалтын эмнэлгийн үүрэг гүйцэтгэхийн тулд юуны өмнө нэгдсэн эмнэлгийнхээ хувьд өндөр түвшинд үйл ажиллагаа явуулдаг, сайн чанарын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байсан юм.

1.5 Төслийн тэргүүлэх зорилт, төслийн зорилт, үр дүн

Тус төслийн тэргүүлэх зорилт, зорилт, үр дүн болон шалгуур үзүүлэлт зэргийг дор дурдав.

Хүснэгт 1 Төслийн тэргүүлэх зорилт, зорилт, үр дүн зэрэг (зассан хувилбар)

Зорилт ба үр дүн	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтэд хүрэх арга зам
【Тэргүүлэх зорилт】 ЯМЭ нь нэгдсэн эмнэлэг, сургалтын эмнэлгийнхээ хувьд өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах	1. ЯМЭ нь ISO9001 (чанарын менежментийн тогтолцоо)-г нэвтрүүлэх 2. ЯМЭ дээр төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах	1. Эмнэлгийн тайлан
【Төслийн зорилт】 ЯМЭ нь технологийн түвшин, чанарын хувьд өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхүйц удирдлага, зохион байгуулалтыг бий болгох	1. Төслийн сүүлийн жилд эмнэлгийн орны эргэлт 80%-иас дээш байх	1. Төслийн үйл ажиллагааны эцсийн тайлан 2. Мониторингийн хуудас 3. Эмнэлгийн тайлан
	2. ЭТҮ-ний талаарх өвчтний сэтгэл ханамж 80%-иас дээш байх	1. Төслийн үйл ажиллагааны эцсийн тайлан 2. Мониторингийн хуудас 3. Эмнэлгийн тайлан 4. Өвчтний сэтгэл ханамжийн судалгаа
【Үр дүн】 Үр дүн 1: ЯМЭ нь зүй зохистой менежментийг	1. Төсөл дуусахад ЯМЭ-ийн Захиргааны хороо байгуулагдаж, хорооны дүрэм, журмын дагуу хорооны үйл ажиллагааг явуулдаг байх	1. Эмнэлгийн тэмдэглэл 2. Хорооны дүрэм, журам, хурлын тэмдэглэл

Зорилт ба үр дүн	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтэд хүрэх арга зам
хэрэгжүүлдэг байх	2. Үйл ажиллагааны чиглэл (бизнес төлөвлөгөө) боловсруулж, чиглэл болон эмнэлзүйн гүйцэтгэл зэрэг нотолгоонд суурилсан төсвийн төлөвлөлт, хангамж, нийлүүлэлтийн төлөвлөгөө зэрэг хэрэгждэг байх	1. ЯМЭ-ийн үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө 2. Сарын төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүгийн дүн шинжилгээний тайлан зэрэг бүх төсвийн бичиг баримт 3. SPD тайлан 4. Аудитын тайлангийн дагуу авах арга хэмжээний төлөвлөгөө
Үр дүн 2: ЯМЭ-т өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	1. Төсөл дуусахад эрэмбийн хувьд тэргүүлэх эмнэлзүйн тасгуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний бодит гүйцэтгэлд тулгуурлан клиникал патвэй (clinical pathway)-н загвар/жишгийг боловсруулж, багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд ашиглах	1. Төслийн эцсийн тайлан 2. Мониторингийн хуудас 3. Эмнэлгийн тайлан 4. Дүрэм, журам, удирдамж 5. Эмч нарын зөвлөгөөний тэмдэглэл
	2. Төсөл дуусахад ЯМЭ-ийн бүх нэгжид эмнэлгийн тусламж үйлчилгээний ослоос сэргийлэх болон эмнэлгийн дотоод халдварын эсрэг арга хэмжээтэй холбоотой дүрэм, журам болон удирдамжийг дагаж мөрддөг байх	1. Төслийн эцсийн тайлан 2. Мониторингийн хуудас 3. Эмнэлгийн тайлан 4. Тохиолдол мэдээлэх хуудас 5. ICT (Infection Control Team) тойролтын тайлан
Үр дүн 3: Дэвшилтэт эмнэлгийн тусламж үйлчилгээг ЯМЭ-т нэвтрүүлэх	1. Төсөл дуусах үед дор хаяж 3 салбар (СТ, MRI, дуран гэх мэт)-т японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан шинэ оношилгоо, эмчилгээний технологи нэвтэрсэн байх	1. Төслийн эцсийн тайлан 2. Мониторингийн хуудас 3. Эмнэлгийн тайлан
	2. Төсөл дуусах жилд дор хаяж 3 удаа ЯМЭ-ийн дотоодод воркшоп зохион байгуулах	1. Төслийн эцсийн тайлан 2. Мониторингийн хуудас 3. Эмнэлгийн тайлан
Үр дүн 4: Өндөр түвшний яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх удирдлага, зохион байгуулалтыг ЯМЭ-т бүрдүүлэх	1. Төсөл дуусахад голлох эмнэлгийн тусламж үйлчилгээг 24 цагаар үзүүлэх удирдлага, зохион байгуулалт бүрдсэн байх	1. Төслийн эцсийн тайлан 2. Мониторингийн хуудас 3. Эмнэлгийн тайлан
	2. Төсөл дуусахад ЯМЭ-ийн яаралтай тусламж үйлчилгээний туршлага, мэдлэгээс АШУҮИС-ийн тухайлах сургалтын хөтөлбөрт тусгах	1. Сургалтын хөтөлбөр боловсруулах зураглал 2. Хурлын тэмдэглэл

Эх сурвалж: ТТМ (Төслийн төлөвлөлтийн матриц, 2021 оны 10-р сар)

Хүснэгт 2 Төслийн үйл ажиллагаа

Үр дүн 1: ЯМЭ нь зүй зохистой менежментийг хэрэгжүүлдэг байх

【1-1 : Үр бүтээмжтэй бүтэц, зохион байгуулалтыг бий болгох】

- 1-1-1 : Бүх тасаг, сувилахуйн алба, эмнээүйд дэмжлэг үзүүлэх алба, захиргаа, үйлчилгээний алба, био-анагаахын инженеринг, эрүүл мэндийн дэмжлэгийн алба болон холбогдох менежментийн хороод зэрэгт хэрэглэж мөрдөх үйл ажиллагааны болон дотоод дүрэм, журам боловсруулах
- 1-1-2 : Эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллийн алба, нэгжийг байгуулж, IT буюу мэдээллийн технологийг ашиглан эмнэлгийн менежментийн стратеги төлөвлөгөөг боловсруулах
- 1-1-3 : Эмнэлгийн ажилтан, ажиллагсад /эмч, сувилагч болон эмнэлгийн бусад ажилтан, ажиллагсад/, захиргааны ажилтнууд, бусад дэмжлэг үзүүлэх алба, үйлчилгээний ажилтан, ажиллагсдыг хүний нөөцөөр авах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан, батлах
- 1-1-4 : Эрүүл мэндийн ажилтнуудын төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх

【1-2 : Эмнэлгийн эрүүл менежмент】

- 1-2-1 : Ашиглалтын өмнөх бэлтгэл хангах цогц төлөвлөгөө /эмнэлзүйн хэрэгжилтийн төлөвлөгөө, ор ашиглалтын төлөвлөгөө, бараа, материал ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө гэх мэт/ -г боловсруулах
- 1-2-2 : Эмнэлгийн ажилтан, ажиллагсад, захиргааны ажилтнууд, дэмжлэг үзүүлэх бусад үйлчилгээний ажилтнуудыг японд зохион байгуулах менежментийн сургалтад хамруулах
- 1-2-3 : Японд зохион байгуулах сургалтын үеэр олж авсан мэдлэг, туршлагад суурилан эмнэлгийн менежментийн төлөвлөгөө /төсөв, орлого, зарлагын менежмент, хүний нөөцийн менежмент г.м/-г боловсруулах
- 1-2-4 : Эрүүл мэндийн дэмжлэгийн алба, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженеринг зэрэг шинээр байгуулагдах алба, нэгжийн тухайд стандартын дагуу үйл ажиллагаа явуулахуйц технологийн дэмжлэг үзүүлэх
- 1-2-5 : Эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээллийн нэгжийн боловсруулсан стратеги төлөвлөгөөнд үндэслэсэн IT системийг бодитоор нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- 1-2-6 : Эм тариа, эмнэлгийн багаж, хэрэгсэл, элэгдэж хорогддог бараа, материалыг ханган нийлүүлэх хамгийн зохист тогтолцоог бүрдүүлэх

Үр дүн 2: ЯМЭ-т өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх

【2-1 : Эмнэлгийн тусламж үйлчилгээг багаар үзүүлэх тогтолцоог нэвтрүүлэх】

- 2-1-1 : Өвчтөний менежмент /багаар үзүүлэх тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний стандартчлал, аюулгүй байдал г.м/-ийн сэдвээр японд сургалт зохион байгуулж холбогдох ажил, мэргэжлийн хүмүүсийг хамруулах
- 2-1-2 : Японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагад суурилан багаар үзүүлэх тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх удирдамж, нэвтрүүлэх төлөвлөгөө, эмнэлгийн ажилтан, ажиллагсдын ур чадварыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулах (өөрчлөлт оруулахаас өмнө)
Японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагад суурилан багаар үзүүлэх тусламж үйлчилгээг бодитоор хэрэгжүүлэх арга, хэрэгсэл, харилцааны системийг бүрдүүлж, эмнэлгийн ажилтан, ажиллагсдын ур чадварыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулах (өөрчлөлт оруулсны дараа)³
- 2-1-3 : Эмнэлгийн дотоодод эмнэлгийн ажилтан, ажиллагсдыг багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний сургалтад хамруулах
- 2-1-4 : АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг дээр хэд хэдэн загвар эмнэлзүйн тасагт удирдамжийн дагуу багаар үзүүлэх тусламж үйлчилгээг туршилтаар нэвтрүүлэх (өөрчлөлт оруулахаас өмнө)
АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэгт хэд хэдэн загвар эмнэлзүйн тасагт практик арга хэрэгсэл,

харилцааны системийг ашиглан багаар үзүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг туршилтаар нэвтрүүлэх (өөрчлөлт оруулсны дараа)

2-1-5 : Туршилтийн үр дүнд үндэслэн удирдамжийг сайжруулан өөрчилж ЯМЭ-ийн үйл ажиллагааг бүрэн эхлүүлсний дараа багаар үзүүлэх тусламж үйлчилгээг шат дараатайгаар нийт тасгуудад нэвтрүүлэх

【2-2 : Эмнэлгийн тусламж үйлчилгээний стандарчлал】

2-2-1 : 2-1-1-д дурдсан японд зохион байгуулах сургалтын дүнд олж авсан мэдлэг, туршлагад суурилан клиникал патвэй (clinical pathway)-г нэвтрүүлж, ажилтан, ажиллагсдын ур чадварыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулах

2-2-2 : АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлгийн зарим загвар эмнэлзүйн тасагт өвчтөнд зориулсан болон эмнэлгийн ажилтан, ажиллагсдад зориулсан клиникал патвэй (clinical pathway)-г туршилтаар нэвтрүүлэх

2-2-3 : Туршилтийн үр дүнд үндэслэн клиникал патвэй (clinical pathway)-г ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээний стандарчиллыг ЯМЭ-ийн үйл ажиллагааг бүрэн эхлүүлсний дараа шат дараатайгаар нийт тасгуудад нэвтрүүлэх (өөрчлөлт оруулахаас өмнө)
Туршилтийн үр дүнд үндэслэн ЯМЭ-т тохирохуйц клиникал патвэй (clinical pathway)-г боловсруулж, тэргүүлэх ач холбогдолтой эмнэлзүйн тасагт ашиглах (өөрчлөлт оруулсны дараа)

【2-3 : Эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдал (эрсдэл)-ын менежмент】

2-3-1 : АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний осол, зөрчил болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг судалж, дүн шинжилгээ хийн, эмнэлгийн тусламж үйлчилгээний осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх дүрэм, журмыг боловсруулах

2-3-2 : Боловсруулсан дүрэм, журамд үндэслэн ЯМЭ-ийг ашиглалтад оруулахаас өмнө нийт ажилтан, ажиллагсдад эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлын менежментийн лекц, сургалтуудыг зохион байгуулах

2-3-3 : ЯМЭ-ийг бүрэн ашиглалтад оруулсны дараа эмнэлгийн тусламж үйлчилгээний ослоос урьдчилан сэргийлэх хороо нь тогтмол хугацаанд мониторинг хийх

【2-4 : Эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ】

2-4-1 : Эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хороо байгуулж, авах арга хэмжээний талаарх удирдамж, дүрэм зэргийг боловсруулах

2-4-2 : Эмнэлгийн дотоод халдвар үүсгэгч бактерийг тодорхойлох, статистик дүн шинжилгээ гэх мэт, эмнэлгийн дотоод халдварын тандалт судалгааны удирдлага, зохион байгуулалтыг бий болгох

2-4-3 : Эмнэлэг ашиглалтад орохоос өмнө боловсруулсан удирдамж, дүрэм зэрэгт суурилсан эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх сургалтыг нийт эмнэлгийн ажилтнуудад зохион байгуулах

2-4-4 : Хороод голлох үүрэг гүйцэтгэж удирдамж, дүрэм журам зэргийн биелэлтэд тогтмол мониторинг хийх

Үр дүн 3: Дэвшилтэт эмнэлгийн тусламж үйлчилгээг ЯМЭ-т нэвтрүүлэх

3-1 : Оношилгоо, эмчилгээтэй холбоотой эмнэлгийн тусламж үйлчилгээний технологи /эмнэлзүйн шууд үйлдлээс бусад/-ийн талаар японд сургалтын зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулах

3-2 : Дээрх сургалтын төлөвлөгөөний дагуу холбогдох эмнэлгийн ажилтан, ажиллагсдыг японд зохион байгуулах сургалтад хамруулах, сургалтын дагуу ажиллах. Мөн, СТ, MRI ашиглах аппликэшн сургалтыг монголын дотоодын туслан гүйцэтгэгчээр хийлгүүлэх. Ковид-19-тэй холбоотой арга хэмжээний тухайд лаборатори болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба зэрэг холбогдох бүх ажилтнуудад оношилгоо, эмчилгээний талаарх сургалтыг зохион байгуулах

3-3 : Технологи түгээх, хуваалцах үйл ажиллагааг үр хүртээмжтэй байлгахын тулд сургалтын тайлан болон хэсэг, нэгж хоорондын хамтарсан сургалт зэргийг зохион байгуулах

Үр дүн 4: Өндөр түвшний яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх удирдлага, зохион байгуулалтыг ЯМЭ-т бүрдүүлэх

- 4-1 : Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах ажилтан, ажиллагсдыг хүний нөөцийг зохион байгуулах, санхүүгийн менежмент зэрэг асуудлыг багтаасан менежментийн сургалтад хамруулах
- 4-2 : Японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагад суурилан шинжилгээ хийх, оношлох, эмчлэх үйл ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэхүйц яаралтай тусламжийн төвийн хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын талаарх үйл ажиллагааны дүрэм, журмыг боловсруулах
- 4-3 : ЯМЭ-ийн яаралтай тусламжийн хүрээнд бий болсон мэдлэг, туршлагыг АШУҮИС-ийн сургалтад тусгах
- 4-4 : Эмч нарын зөвлөгөөн зэргийг зохион байгуулах замаар ЯМЭ-ийн яаралтай тусламж үйлчилгээний хүрээнд бий болсон мэдлэг, туршлагыг монголын эмнэлгийн салбарын ажилтнуудад өргөн түгээх

Эх сурвалж: ТТМ (2018 оны 9-р сар болон 2021 оны 10-р сар)

1.5 Хэрэгжсэн бүс нутаг

Нийслэл Улаанбаатар хот

1.6 Холбогдох яам, байгууллагууд

Гол хамаарах Төрийн захиргааны байгууллага: Боловсрол, шинжлэх ухааны яам
(цаашид БШУЯ гэх)³

Хэрэгжүүлэгч байгууллага: АШУҮИС

³ Хуучнаар “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (Ministry of Education, Culture, Science and Sport : MECSS)

2. Төслийн үйл ажиллагааны бодит гүйцэтгэл

2.1 Үйл ажиллагааны бодит гүйцэтгэл

2.1.1 Япон талын оролцоо, гүйцэтгэл

(1) Япон талаас оруулсан хөрөнгө оруулалт

- Нэг дэх үе: 268.800.000 иен (бодит гүйцэтгэл)
- Хоёр дах үе: 489.100.000 иен (зарлагын төсөөлөл)
- Нийт: 757.900.000 иен (нийт дүнгийн төсөөлөл)

(2) Мэргэжилтний оролцоо, үйл ажиллагаа

Уг төслийг Төрийн өмчит Токүшимагийн их сургууль, Төрийн өмчит Эхимэгийн их сургууль болон Koei Research Consulting ХК гэсэн 3 талын хамтарсан зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэн ажиллав. Мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнийг дор дурдав. 2022 оны 7-р сарын эцсийн байдлаар ажилласан нийт мэргэжилтний хөдөлмөрийн зарцуулалтыг мөн дор дурдав. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1-1-д харуулав.

- Нэг дэх үе: Монголд 29.55 хүн/сар Японд 27.65 хүн/сар нийт 57.20 хүн/сар
- Хоёр дах үе: Монголд 59.94 хүн/сар Японд 73.91 хүн/сар нийт 128.85 хүн/сар
- Нийт: Монголд 84.49 хүн/сар Японд 101.56 хүн/сар нийт 186.05 хүн/сар

Хүснэгт 3 Япон мэргэжилтний бүрэлдэхүүн (нэг дэх үе: 2017.02-2019.04)

Овог, нэр	Хариуцсан ажил	Харъяалал	Зэрэг
Ирахара Минору	Удирдагч/Эмнэлгийн менежмент(1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	2
Або Хироши	Дэд удирдагч/Эмнэлгийн менежмент(2)/Сургалтын менежмент(1)	Koei Research Consulting ХК	3
Нишиока Ясүхико	Эмнэлгийн менежмент(Сувилахуй, Өвчтөний менежмент, Яаралтай тусламж, Хангамж, түгээлтийн систем(SPD) хариуцсан)(1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	3
Мацүзаки Тошия	Эмнэлгийн менежмент(Сувилахуй, Өвчтөний менежмент, Яаралтай тусламж, Хангамж, түгээлтийн систем(SPD) хариуцсан)(2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Като Шинсүкэ	Эмнэлгийн менежмент(Сувилахуй, Өвчтөний менежмент, Яаралтай тусламж, Хангамж, түгээлтийн систем(SPD) хариуцсан)(3)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Хигаки Такаши	Эмнэлгийн менежмент(ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ, Эмнэлгийн мэдээллийн систем(IT) хариуцсан)(1)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	3
Такада Хидэми	Эмнэлгийн менежмент (ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ, Эмнэлгийн мэдээллийн систем (IT) хариуцсан) (2)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4

Овог, нэр	Хариуцсан ажил	Харъяалал	Зэрэг
Ока Ясүнори	Эмнэлгийн менежмент (ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ, Эмнэлгийн мэдээллийн систем (IT) хариуцсан) (3)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Такагаи Томоко	Сувилахуй, Өвчтөний менежмент (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	3
Күмэ Хироко	Сувилахуй, Өвчтөний менежмент (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Кондо Сачико	Сувилахуй, Өвчтөний менежмент (3)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Накано Акэми	Сувилахуй, Өвчтөний менежмент (4)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Сүзүки Сацүко	Сувилахуй, Өвчтөний менежмент (5)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Каназава Акиё	Сувилахуй, Өвчтөний менежмент (6)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Фүжикава Риэ	Сувилахуй, Өвчтөний менежмент (7)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Нишимаги Шино	Үйл ажиллагааны зохицуулалт (2)/Сургалтын менежмент (3)	Koei Research Consulting ХК	4
Сүгино Ясүхиро	Үйл ажиллагааны зохицуулалт (3)/Сургалтын менежмент (4)	Koei Research Consulting ХК	5
Хаяши Асако	Үйл ажиллагааны зохицуулалт (4)/Сургалтын менежмент (5)	Koei Research Consulting ХК	4
Нишимүра Масажи	Яаралтай тусламж (1) (~2018 он 12-р сар)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	3
Оото Жүн	Яаралтай тусламж (1) (2019 он 1-р сар~)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Итагаки Таига	Яаралтай тусламж (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Таүчи Хисамичи	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (1)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	3
Аоно Хиротака	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (2)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Сакиита Сатоми	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (3)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Кимүра Хироши	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (4)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Кимүра Эизэн	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (1)	Төрийн өмчит Эхимэгийн ИС (Японы Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн)	3
Морита Макото	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (2)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Сано Даиго	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (3)	Koei Research Consulting ХК	5
Кидо Тэрүхито	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (4)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4

Овог, нэр	Хариуцсан ажил	Харъяалал	Зэрэг
Акияма Ясүо	Хангамж, түгээлтийн систем (SPD) (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС (Коожинкаи хамтын сан)	3
Кавано Шигэрү	Хангамж, түгээлтийн систем (SPD) (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Мүрасава Фүмиэ	Сургалтын менежмент (6)/Харилцааны ур чадвар	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Китора Акира	Эмнэлгийн санхүү (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Окада Сүгүрү	Эмнэлгийн санхүү (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Какизоэ Хироюки	Эмнэлгийн санхүү (3)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Кодама Мива	Эмнэлгийн бичиг хэргийн менежмент (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Сүзүки Аканэ	Эмнэлгийн бичиг хэргийн менежмент (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Кавано Шин-Ичи	Эмнэлгийн бичиг хэргийн менежмент (3)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Харада Масафүми	Радиологийн тасгийн сургалт (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Ивамото Сэижи	Радиологийн тасгийн сургалт (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Отоми Ёо-Ичи	Радиологийн тасгийн сургалт (3)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Такаги Ясүши	Тархи мэдрэлийн тасгийн сургалт (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Мизобүши Ёшифүми	Тархи мэдрэлийн тасгийн сургалт (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Канаяма Хиро-Оми	Дотрын тасгийн сургалт (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Ямамото Нобүаки	Дотрын тасгийн сургалт (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Наито Такэши	Нүдний тасгийн сургалт	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Хамада Даисүкэ	Сэргээн засах тасгийн сургалт (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Нишишёо Тошихико	Сэргээн засах тасгийн сургалт (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Накао Такаюки	Эмнэлзүйн шинжилгээний албаны сургалт	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Оониши Ёшиаки	Эмнэлзүйн инженерийн албаны сургалт	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

Хүснэгт 4 Япон мэргэжилтний бүрэлдэхүүн (хоёр дах үе: 2019.05-2022.10)

Овог, нэр	Хариуцсан ажил	Харъяалал	Зэрэг
Ирахара Минору	Удирдагч/Эмнэлгийн менежмент (1) (~2022 он 3-р сар)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	2
	Эмнэлгийн менежмент (Сувилахуй, Өвчтөний менежмент, Яаралтай тусламж, Хангамж, түгээлтийн систем (SPD) хариуцсан) (1) (2022 он 4-р сар~)		3
Акаиэ Масаши	Удирдагч/Эмнэлгийн менежмент (1) (2022 он 4-р сар~)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	2
Або Хироши	Дэд удирдагч/Эмнэлгийн менежмент (2)/Сургалтын менежмент (1)	Koei Research Consulting ХК	3
Наито Такэши	Эмнэлгийн менежмент (Сувилахуй, Өвчтөний менежмент, Яаралтай тусламж, Хангамж, түгээлтийн систем (SPD) хариуцсан)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	3
Хигаки Такаши	Эмнэлгийн менежмент (ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ, Эмнэлгийн мэдээллийн систем (IT) хариуцсан) (1)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	3
Такада Хидэми	Эмнэлгийн менежмент (ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ, Эмнэлгийн мэдээллийн систем (IT) хариуцсан) (2)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Ока Ясүнори	Эмнэлгийн менежмент (ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ, Эмнэлгийн мэдээллийн систем (IT) хариуцсан) (3)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Такагаи Томоко	Сувилахуй, Өвчтөний менежмент (1)	Төрийн өмчит Токүшимагийн ИС (2022 он 4-р сар~ Токүшимагийн Бүрнри ИС)	3
Күмэ Хироко	Сувилахуй, Өвчтөний менежмент (2)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Фүжикава Риэ	Сувилахуй, Өвчтөний менежмент (3)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Оото Жүн	Яаралтай тусламж	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Таүчи Хисамичи	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (1)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	3
Аоно Хиротака	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (2)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Кимүра Хироши	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (3)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Миямото Хитоши	ЭТҮХХ-ийн эсрэг арга хэмжээ (4)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Кимүра Эизэн	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (1)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	3
Кидо Тэрүхито	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (2)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Сакита Сатоми	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (3)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4

Овог, нэр	Хариуцсан ажил	Харъяалал	Зэрэг
Таги Масато	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (4)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Сано Даиго	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (5) (~2020 он 8-р сар)	Koei Research Consulting ХК	4
Каисэ Сү Мюн	Эмнэлгийн мэдээллийн систем (IT) (5) (2020 он 9-р сар~)	Koei Research Consulting ХК	5
Акияма Ясүо	Хангамж, түгээлтийн систем (SPD)	Төрийн өмчит Токүшимагийн ИС(Коожинкаи хамтын сан)	3
Тангокү Акира	Эмнэлзүйн тасаг (Мэс засал)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Канаяма Хиро-Оми	Эмнэлзүйн тасаг (Урологи)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Такаги Ясүши	Эмнэлзүйн тасаг (Тархи мэдрэлийн мэс засал)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Иноүэ Кацүжи	Эмнэлзүйн тасаг (Зүрх судас)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Харада Масафүми	Эмнэлзүйн тасаг (Радиологи)	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Кидо Тэрүхито	Эмнэлзүйн тасаг(Радиологи)(2)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Камэ-И Ёшиаки	Эмнэлзүйн тасаг (Элэг, цөс, нойр булчирхай, хөхний булчирхайн мэс засал)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Күцүна Тацүхико	Эмнэлзүйн тасаг (Ортопед мэс засал)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Нишихара Тасүкү	Эмнэлзүйн тасаг (Мэдээгүйжүүлэг)	Төрийн өмчит Эхимэгийн ИС	4
Накао Такаюки	Эмнэлзүйн шинжилгээ	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Оониши Ёшиаки	Эмнэлзүйн инженерчлэл	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Кавата Наонобү	Радиологийн шинжилгээ	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Китора Акира	Эмнэлгийн санхүү	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Хашимото Нобүюки	Санхүүгийн менежмент	Koei Research Consulting ХК	4
Сүзүки Аканэ	Эмнэлгийн захиргаа	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Мүрасава Фүмиэ	Сургалтын менежмент (4)/Харилцааны ур чадвар	Төрийн өмчит Токүшимагийн ИС	4
Нишимаги Шино	Үйл ажиллагааны зохицуулалт (1)/Сургалтын менежмент(2)	Koei Research Consulting ХК	4
Сүгино Ёшихарү	Үйл ажиллагааны зохицуулалт (2)/Сургалтын менежмент(3)(~2021 он 7-р сар)	Koei Research Consulting ХК	4
Оониши Каито	Үйл ажиллагааны зохицуулалт (2)/Сургалтын менежмент(3)(2021 он 8-р сар~)	Koei Research Consulting ХК	4

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

(3) Японд зохион байгуулсан сургалт

Төслийн нэг дэх үед 9 удаа, хоёр дах үед ковид-19-н улмаас улс хооронд зорчиход хориг хязгаартай болсон тул 3 удаа, нийт 12 удаа зохион байгуулав. Сургалтын хүрээнд нэг дэх үед 66 хүн, хоёр дах үед 22 хүн, нийт 88 хүн сургалтад хамруулав. Сургалт тус бүрийн нарийвчилсан төлөвлөгөө (гүйцэтгэл) болон сургалтад оролцогчдын нэрсийн жагсаалтыг Хавсралт 1-3 “Японд зохион байгуулсан сургалтын гүйцэтгэл” болгон хавсаргав.

【Нэг дэх үе (2017.02-2019.04)】

- ① 2017 оны 6-р сарын 25 (Ня)-наас 7-р сарын 8 (Бя)-ны хооронд 14 хоног япон дах анхны сургалт (Японы эмнэлгийн тогтолцооны талаарх ерөнхий ойлголт)-ыг Токүшимагийн ИС болон Эхимэгийн Их сургууль дээр зохион байгуулав. Монголын АШУҮИС-иас 16 хүн оролцсон.
- ② 2017 оны 10-р сарын 22 (Ня)-ноос 11-р сарын 2 (Пү)-ны хооронд 12 хоног, хоёр дах сургалт (Эмнэлгийн менежмент)-ыг Токүшимагийн ИС-д зохион байгуулав. Монголын АШУҮИС-иас 9 хүн оролцсон.
- ③ 2017 оны 11-р сарын 12 (Ня)-ноос 11-р сарын 25 (Бя)-ны хооронд 14 хоног 3 дах сургалт (Сувилахуйн менежмент)-ыг Токүшимагийн ИС-д зохион байгуулав. Монголын АШУҮИС-иас 6 хүн оролцсон.
- ④ 2018 оны 2-р сарын 21 (Лха)-нээс 3-р сарын 2 (Ба)-ны хооронд 10 хоног, 4 дэх сургалт “Эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээ”-г Японы Орчны халдвар судлалын холбооны Ерөнхий хурал, Эрдэм шинжилгээний хурал (Таканава Принц зочид буудалд зохин байгуулагдсан) болон Эхимэгийн ИС-д зохион байгуулав. Монголын АШУҮИС-иас 4 хүн оролцсон.
- ⑤ 5 дах сургалтыг (Эмнэлгийн мэдээллийн систем) зохион байгуулав. Сургалтыг “IT баг”, “Эмч нарын баг”-т хуваан зохион байгуулж, эхний баг PACS-г буцалтгүй тусламжаар нийлүүлсэн PSP ХК, Эхимэгийн ИС болон дүрс оношилгооны тоног төхөөрөмжийг буцалтгүй тусламжаар нийлүүлсэн Шимазү ХК дээр 2018 оны 2-р сарын 21 (Лха)-нээс 3-р сарын 2 (Ба)-ны хооронд 10 хоног зохион байгуулж, АШУҮИС-иас 3 хүн оролцсон.
- ⑥ 2018 оны 2-р сарын 25 (Ня)-наас 3-р сарын 3 (Бя)-ны хооронд 7 хоног, 6 дах удаагийн сургалт (Эмнэлгийн менежмент (Эмнэлзүйн лабораторийн шинжилгээний технологи, Эмнэлзүйн инженеринг))-ыг Токүшимагийн ИС-д зохион байгуулав. АШУҮИС-иас 6 хүн оролцсон.
- ⑦ 2018 оны 7-р сарын 22 (Ня)-ноос 7-р сарын 29 (Ня)-ний хооронд 8 хоног, 7 дах удаагийн сургалт (Эмнэлгийн менежмент (симуляци төлөвлөлт))-ыг Токүшимагийн ИС дээр зохион байгуулав. АШУҮИС-иас 9 хүн оролцсон.
- ⑧ 2018 оны 9-р сарын 2 (Ня)-ноос 9-р сарын 8 (Ня)-ны хооронд 7 хоног, 8 дах удаагийн сургалт (Эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээ)-ыг Эхимэгийн ИС дээр зохион байгуулав. АШУҮИС-иас 6 хүн оролцсон.

- ⑨ 2018 оны 9-р сарын 26 (Ня)-наас 9-р сарын 29 (Бя)-ний хооронд 4 хоног, АШУҮИС-ийн холбогдох 3 хүнд ЖАИКА-гийн төв оффис болон Токүшима-гийн ИС-д танилцах сургалтыг зохион байгуулав.

【Хоёр дах үе (2019.05-2022.10)】

- ⑩ 2019 оны 11-р сарын 18 (Ня)-наас 11-р сарын 22 (Ба)-ны хооронд 5 хоног 10 дах удаагийн сургалт (Багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ (хагалгааны нэгж))-ыг Токүшимагийн ИС дээр зохион байгуулав. ЯМЭ-ээс 8 ажилтан оролцов.
- ⑪ 2019 оны 11-р сарын 25 (Да)-наас 11-р сарын 29 (Ба)-нд 5 хоног 11 дэх удаагийн сургалт (Багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ (Өвчтөн дэмжих төв, эрчимт эмчилгээний тасаг))-ыг Токүшимагийн ИС дээр зохион байгуулав. ЯМЭ-ээс 5 ажилтан оролцов.
- ⑫ 2022 оны 8-р сарын 17 (Лха)-ноос 8-р сарын 24 (Лха)-нд 7 хоног 12 дах удаагийн сургалт (Эмнэлгийн менежмент (санхүүгийн менежмент, хангамж, нийлүүлэлт, түгээлтийн менежмент, сувилахуй болон өвчтний менежмент)) болон багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг Токүшимагийн ИС дээр, эмнэлгийн мэдээллийг систем болон эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээг Эхимэгийн ИС дээр зохион байгуулав. ЯМЭ-ээс 9 ажилтан оролцов.

(4) Тоног төхөөрөмж олгосон тухай

Олгосон тоног төхөөрөмжийн жагсаалтыг дор дурдав.

Хүснэгт 5 Олгосон тоног төхөөрөмжийн жагсаалт

Тоног төхөөрөмж	Тоо	Хаана
Fijitsu Lifebook A557	2	Хэрэгжүүлэгч байгууллага
Fijitsu Esprimo P556/E85+MI4W	2	Хэрэгжүүлэгч байгууллага
Xerox Workcenter 7220i	1	Хэрэгжүүлэгч байгууллага
Дүрс оношилгооны үйл ажиллагааны удирдлага, хяналтын систем (ARISation LIMITED)	1	Хэрэгжүүлэгч байгууллага
PACS систем (DICOM viewer "EV Insite" lisenсe)	7	Хэрэгжүүлэгч байгууллага
RIS server	1	Хэрэгжүүлэгч байгууллага
RIS-д ашиглах компьютер	7	Хэрэгжүүлэгч байгууллага
Өндөр хяналтат тасагт ашиглах өвчтний хяналтын монитор PVM-2703 (Nihon Kohden Corporation)	4	Хэрэгжүүлэгч байгууллага


Тайлбар: PACS (эмнэлзүйн дүрс, зураг хянах систем), DICOM (эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээлэл, тоо баримтын харилцаа, холбооны ОУ-н стандарт), RIS (дүрс оношилгооны тасгийн мэдээллийн систем), өндөр хяналтат тасаг

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

2.1.2 Монгол талын оролцоо, хамтын ажиллагаа

(1) Монгол талын хэрэгжүүлэгч зохион байгуулалт

Уг төслийн хэрэгжүүлэхдээ АШУҮИС-ийн харъяанд байх ЯМЭ-ийн алба, тасгийн хариуцлагатай ажилтнууд голчлон хамтран ажиллах тал болсон ба япон мэргэжилтэнтэй хэлэлцэж, зөвлөлдөх болон технологи шилжүүлэх удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлсэн. Зураг 1-т хамтран ажиллах тал болох ЯМЭ-ийн бүтцийн зургийг оруулав. ЯМЭ нь харъяаллын хувьд 2021 оны 2-р сард Эрүүл мэндийн яам (цаашид ЭМЯ гэх)-наас БШУЯ-нд шилжсэн. Мөн, удирдлагаар хангах төрийн захиргааны байгууллага болох “Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам” нь (Ministry of Education, Culture, Science and Sport : MECSS) -наас БШУЯ болон өөрчлөгдснөөр Гадаад харилцаа, хамтын ажиллагаан хэлтэсгүй болсон тул 2022 оны 8-р сарын байдлаар БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Цэдэвсүрэн) нь төслийн захирлын үүргийг гүйцэтгэж, АШУҮИС-д Н.Хүрэлбаатар захирал (төслийн менежер)-ээр ажиллаж байна. 2022 оны 9-р сарын байдлаарх ЯМЭ болон АШУҮИС-ийн бүтцийн зургийг дор оруулав.



Зураг 1 ЯМЭ-ийн бүтэц

Эх сурвалж: АШУУИС боловсруулав



Зураг 2 АШУУИС-ийн бүтэц

(2) Монгол талын оролцоо, хамтын ажиллагаа

Уг төслийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэсэн монгол талын оролцоо, хамтын ажиллагааны талаар дор дурдав.

- Төслийн мэргэжилтнүүдийн ажиллах орчныг бүрдүүлж, төслийн оффис (2019 оны 9-р сар хүртэл АШУҮИС-ийн байранд, өнөө ЯМЭ дотор) болон тавилгаар хангасан
- Төслийн оффисын ашиглалтын зардал
- Хамтарсан зохицуулах хороо (JCC)-ны хурлыг зохион байгуулах, төрөл бүрийн воркшоп зохион байгуулах, симуляци хийх зэрэгт танхим, өрөө тасалгаагаар хангаж, холбогдох зардлыг хариуцсан
- Хамгаалалттай бүсэд нэвтрэх зөвшөөрөл
- Шаардлагатай материалаар хангах
- ЯМЭ-ийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах, хүний нөөцийн зардлыг багтаасан төсвөөр хангах

2.1.3 Үйл ажиллагаа (төлөвлөлт болон гүйцэтгэл)

Төсөл эхлэх үед байгуулсан хэрэгжүүлэх төлөвлөгөө болон хэрэгжилтийн тухайд буцалтгүй тусламжийн хүрээнд барьж байгуулсан эмнэлгийн барилгын ажил удааширч хоцорсны улмаас хоёр дах үе рүү орж байж (2019 оны 5-р сараас хойш) талбар дээрх зөвлөгөө, сургалт хийх боломжтой болсон. Иймд, тус төсөл эхлэх үед төлөвлөж байсан технологи арга зүйн дэмжлэгийн агуулга, хуваарь өөрчлөгдсөн. Мөн, монгол талын төсвийн хангалт ч эмнэлэг ашиглалтад орох хугацаа хойшилсноос үүдэн анх төлөвлөж байсан дүнг бүгдийг авч чадалгүй, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж чадаагүй, шаардлагатай төхөөрөмж, хэрэгслийг ханган нийлүүлж чадаагүй гэх мэт нөхцөл байдал үүссэн. Иймд, байгууламжийг хүлээлгэн өгөх болон монгол талын бэлтгэл хангагдмагц эмнэлгийн үйл ажиллагааг даруйхан эхлүүлэхийн тулд төслийн хүрээнд японд зохион байгуулсан сургалтад үндэслэн дүрэм, журам, гарын авлага боловсруулах, симуляци хийх зэргээр дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлж ажилласан. Үүний дүнд, 2019 оны 10 дугаар сард ЯМЭ нь Амбулаторийн үйлчилгээг үзүүлж эхлэсэн билээ.

Нөгөөтэйгүүр, 2019 оны эцсээр шинэ төрлийн корона вирусын халдвар тархсны улмаас мэргэжилтнүүд монголд ажиллах, монголоос японд сургалтад хамрагдах үйл явц хүндрэлтэй болсон. Үүнээс үүдэн, онлайн систем ашиглан хэлэлцэж, зөвлөх, мониторинг хийх зэргээр технологи шилжүүлж ажилласан. Гэвч, мэргэжилтнийг томилон ажиллуулах үйл ажиллагаа дахин сэргэсэн нь 2021 оны 3-р сар буюу жил гаруй хугацаанд япон мэргэжилтэн монголд ажиллах боломжгүй хугацаа үргэлжилсэн. Үүний дүнд, төслийн хугацааг сунгах асуудлыг тусган төсөл төлөвлөлтийн матриц (Project Design Matrix : PDM, TTM), хэрэгжүүлэх төлөвлөгөөг шинэчлэн өөрчилсөн. Хэрэгжүүлэх төлөвлөгөө болон гүйцэтгэлийг харьцуулсан мэдээллийг Хавсралт 1-4-т дурдав. Мөн, гүйцэтгэсэн үйл ажиллагааны зураглалыг Хавсралт

1-5-д үзүүлэв.

(1) Ажлын төлөвлөгөө (2 дах үе)-г боловсруулах, хэлэлцэх

2019 оны 5-р сарын 20-ноос төслийн хоёр дах үеийн монгол дах үйл ажиллагааг эхлүүлж, ЯМЭ-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд чиглэсэн монгол талын холбогдох байгууллагын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хэрэгжүүлж буй удирдлага, зохион байгуулалт, буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны төслөөс хүлээлгэн өгөх үйл явц зэрэг нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулж, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг нягталж, ажлын төлөвлөгөөний төслийг (хоёр дах үе) боловсруулав. Боловсруулсан ажлын төлөвлөгөөний төслийг Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАИКА) болон монгол талд танилцуулан, санал зэргийг тусгаж эцэслэсэн.

(2) Үр дүн 1-тэй холбоотой үйл ажиллагаа

- 1) (Үйл ажиллагаа 1-1-4) Эрүүл мэндийн ажилтнуудын төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх. Ялангуяа, сургалтын дараах сургалтын тухайд 2020 онд дуусахаар төлөвлөж буй техникийн хамтын ажиллагаа “Анхан болон хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн үр дүнг магадлаж, монголын нөхцөл байдалд нийцэхүйц хэлбэрээр бүрдүүлэхэд анхаарах

ЖАИКА нь, ЭМЯ болон Эрүүл мэндийн хөгжлийг дэмжих төв (Center for Health Development : CHD)-тэй голлон хамтарч ажиллан, “Анхан болон хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг 2015 оны 5-р сараас 2020 оны 12-р сар хүртэлх 5 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн билээ. Энэхүү төслийн хүрээнд, анхан болон хоёр дах шатлалын эмнэлгийн ажилтнуудад зориулсан төгсөлтийн дараах сургалтыг бэхжүүлэхээр зорин, сургалт явуулах эмнэлэгт тавигдах стандарт шаардлага, үнэлэх арга замыг боловсруулах, олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, эмнэлзүйн сургалтыг удирдах эмчийг хөгжүүлэх, мөн түүнчлэн монголд анх удаа бүс нутгийн эмнэлэгт хийх үндсэн мэргэшлийн сургалттай холбоотой дэмжлэг үзүүлж, шинэ төгссөн сувилагч нарыг удирдах хүний хөгжилд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлж ирсэн билээ. Эдгээрийн үр дүнд үндэслэн, төслийн 1-р шатанд хэрэгжүүлсэн үндсэн мэргэшлийн сургалтыг улам өргөжүүлэхээс гадна сувилагч, эх баригч нарын төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулж, цаашид хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлийн монголын төрийн захиргааны байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд 2-р шатанд “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл” (2021 оны 1-р сараас 2025 оны 1-р сар)-ийг хэрэгжүүлж байна.

Манай төслийн хүрээнд, тухай бүр энэхүү төслийн мэргэжилтэнтэй санал солилцож, өөрсдийн төлөвлөгөөтэй уялдуулан холбох тал дээр чухал мэдээлэл болгон ашиглаж ирсэн.

Ялангуяа, ЯМЭ дээр суурилсан төгсөлтийн дараах сургалт, сувилагчийн сургалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, ЯМЭ-ийн ажилтнуудад зориулсан удирдагч багш, сувилагчийн ТОТ, фасилитатор бэлдэх сургалтад үзүүлэх дэмжлэг зэргийг дурдаж болно. Цаашид ч хоёр төсөл үргэлжлүүлэн мэдээлэл солилцож, ЯМЭ-ийн ажилтнуудын төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх, сургалтын эмнэлэг болохынхоо хувьд “сургалт”-ын үүргийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах нь чухал юм.

ЯМЭ нь их сургуулийн эмнэлэг болохынхоо хувьд хүлээх үүрэг, үйл ажиллагаа бол эмнэлзүй, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа бөгөөд эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бүрдүүлэх нь маш чухал хэсэг юм. Монголд төгсөлтийн дараах сургалтыг ЭМЯ болон БШУЯ гэсэн хоёр урсгалтай бөгөөд ирээдүйд эдгээрийг хэрхэн нэгтгэх нь шийдвэрлэвэл зохих асуудал юм. ЭМЯ болон БШУЯ хоёр урсгалыг нэгтгэхэд чиглэн ажиллаж эхлэсэн хэдий ч монголын эмч нарын 90% гаруй нь АШУУИС-иас бэлтгэгдэн гардаг болон АШУУИС-ийн төсөв нь оюутан, резидент эмч нарын сургалтын төлбөрөөс бүрддэг учраас олон талын эрх ашгийг хөнддөг тул тэр бүр ахиц гардаггүй нь бодит нөхцөл байдал юм. Төслийн зүгээс өнөөг хүртэл японы Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх ухааны яам болон Эрүүл мэнд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны үүрэг, оролцооны тухай ЭМЯ, холбогдох бусад төр, засгийн байгууллагын холбогдох хүмүүст удаа дараа танилцуулан, тайлбарлаж нэгтгэх тал дээр тасралтгүй ажиллаж ирсэн билээ. Үүний дүнд, АШУУИС-ийн Удирдах зөвлөлийн даргын албан тушаал БШУЯ-наас ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад шилжиж, ЭМЯ-ны санал АШУУИС-ийн үйл ажиллагааны чиглэлд тусгалаа олдог болсон.

ЭМЯ-ны төгсөлтийн дараах сургалтын тухайд, дээр дурдсанчлан төслийн дараах сургалтын төсөл нь ЭМЯ болон Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. ЯМЭ ч үндсэн мэргэшлийн сургалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд өнгөрсөн оноос 4 үндсэн мэргэшлийн эмчийг хүлээж авч байгаа юм. ЭМЯ-ны зохион байгуулдаг сургалтыг АШУУИС голлон хэрэгжүүлж байна. АШУУИС нь 3 төрлийн сургалтыг хэрэгжүүлдэг.

Хүснэгт 6 АШУУИС-ийн хэрэгжүүлдэг сургалтын ерөнхий танилцуулга

<p><u>Төгсөлтийн өмнөх сургалт:</u> Төгсөлтийн өмнөх сургалтын газар хариуцдаг. АШУУИС-д суралцаж буй оюутнууд болон бусад салбар сургуулийн оюутнууд (сувилахуйн сургууль гэх мэт) нийт 10 мянга гаруй оюутныг сургадаг. Сургалтын чанарыг сайжруулж, эмнэлэгт эмнэлзүйн сургалт хийх нь ач холбогдолтой гэж үздэг. АУС-ийн оюутнууд 6-р дамжаанаасаа АШУУИС-тай гэрээ байгуулж 14 эмнэлэгт 1-2 долоо хоногийн хуваариар суралцдаг.</p>
<p><u>Төгсөлтийн дараах сургалт:</u> Төгсөлтийн дараах сургалтын газар хариуцдаг. Өнөөгийн байдлаар магистр, докторын зэргээр 3000 гаруй оюутан суралцаж байна (6-р дамжаа төгссөний дараа магистрийн дамжаанд ордгоороо японоос ялгаатай). ЭМХТ-ийн үндсэн мэргэшлийн сургалтыг хэрэгжүүлдэггүй, мөн сургагч эмчийн итгэмжлэлийг зөвхөн ЭМХТ хэрэгжүүлдэг.</p>

Мэргэжлийн сургалт: Мэргэжлийн эмч болон сургагч багш (сургагч эмч) нарыг мэргэжил дээшлүүлэх төв хариуцдаг. Өнөөгийн байдлаар 32 мэргэжлийн (ирээдүйд 40 салбар) резидент, сургагч багш (сургагч эмч)-ийн сургалтын хөтөлбөртэй (шаардлагатай бол жил бүр шинэчилдэг). Сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай, ЯМЭ дээр төвтэй сургалтын системийг бүрдүүлэх ажлыг нэн тэргүүнд эрэмблэсэн байгаа.

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

ЯМЭ дээр сургалтын үйл ажиллагааг Захиргаа, хүний нөөцийн хөгжил, сургалтын алба хариуцдаг. Сургалт хариуцсан 2 ажилтантай, дараах ажил үүргийг гүйцэтгэдэг.

- Шинэ ажилтны сургалт (чиглүүлэх сургалт, анхан шатны амилуулах суурь тусламж, халдварын арга хэмжээ, эрсдлийн менежмент гэх мэт)
- АШУҮИС-иас резидент эмчийг хүлээн авч сургах (эмнэлзүйн 21 тасаг, тасаг тус бүрт 1 резидент хүлээн авдаг, 1 жилийн хугацаанд төгсөлтийн дараах сургалтаар 900 оюутан хүлээж авах)
- Үндсэн мэргэшлийн резидент эмч хүлээн авч сургах

Шийдвэрлэвэл зохих асуудал бол АШУҮИС-ийн АУС-тай урдчилан хангалттай ярилцаж хэлэлцэлгүйгээр их сургуулиас резидент эмч нарыг томилдог боловч урьдчилж мэдэгдэх нь ховор, резидент эмчийн тоотой харьцуулахад удирдагч багшийн тоо хангалтгүй зэргийг дурдаж болно. Иймд, цаашид резидент эмчийн чанарыг сайжруулахын тулд 1/ АШУҮИС болон ЯМЭ нь уялдаа харилцаагаа бэхжүүлэх (сургалтын харилцан тогтолцоог бүрдүүлэх) 2/ ЯМЭ дээрх менежмент хариуцан хийх нэгж, үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагааг сайжруулах (өнөөгийн байдлаар зөвхөн хуваарийн зохицуулалтыг хийдэг) 3/ Эмнэлзүйд гаршсан сургагч багшийг бэлдэх зэргийг хийх шаардлагатай.

2) (Үйл ажиллагаа 1-2-3) Японд зохион байгуулах сургалтын үеэр олж авсан мэдлэг, туршлагад суурилан эмнэлгийн менежментийн төлөвлөгөө /төсөв, орлого, зарлагын менежмент, хүний нөөцийн менежмент г.м/-г боловсруулах

2019 оны 5-р сараас өмнө буюу Шинэ төрлийн коронавирус (COVID-19)-ийн цар тахал гарах хүртэл төслийн Монгол дахь үйл ажиллагааны хүрээнд эмнэлгийн нэгдсэн менежментийн талаар зөвлөгөө өгөх, нөхцөл байдлыг магадлах, төсөв болон орлого зарлагын төлөвлөгөөг магадлах болон зөвлөмжийг тухай бүр өгсөн. 2020 оны 3-р сараас хойш Шинэ төрлийн коронавирус (COVID-19)-ийн цар тахлын улмаас хил хязгаарлагдаж 2021 оны 8-р сар хүртэл хурлыг үргэлжлүүлэн цахимаар зохион байгуулсан. 2021 оны 9-р сараас хойш хил нээгдэж, зорчих боломжтой болсон тул Монгол дахь үйл ажиллагаа болон цахим хурлыг үргэлжлүүлэн зохион байгуулж, захиргаа, санхүү, бүртгэл, статистик мөн ханган нийлүүлтийн алба болох 4 алба, захиргаа, санхүү эрхэлсэн дэд захиралтай хуралдаж ирсэн. Тус хурлаар санхүүгийн нөхцөл байдлыг магадалж, үйл ажиллагаанд чиглэсэн зөвлөмжийг өгсөн. Түүнчлэн 2020 оны 1-р сараас төслийн зүгээс санхүү удирдлагыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд төсвийн гүйцэтгэлийн удирдлагын арга болох "Эмнэлзүйн

гүйцэтгэлийн харьцуулалтын хүснэгт”(Хавсралт 1-6)-г нэвтрүүлж, төсвийн төсвийн гүйцэтгэлийн нөхцөл байдлыг тухай бүр магадлах боломжтой болсон. Дараах хүснэгт-7-д заасны дагуу 2020 оны 8-р сараас 9 сарын эхэн хүртэл 4 долоо хоногийн(7 хоногт 1 удаа буюу нийт 4 удаа) алсын зайны сургалтыг мөн зохион байгуулсан.

Хүснэгт 7 Санхүүгийн цахим сургалт

Огноо	Агуулга	Оролцогч	Тоо
2020/08/11	ИС-ийн санхүүгийн эх үүсвэрийн бүтэц, дунд хугацааны зорилт/төлөвлөгөө, жилийн төлөвлөгөө, нягтлан бодох, төлөвлөгөө боловсруулах, төсвийн удирдлага	Төлөвлөлт, мониторингийн алба, Санхүүгийн алба, Хуулийн мэргэжилтэн, Гадаад харилцааны мэргэжилтэн	14
2020/08/18	Гэрээ, захиалга, нийлүүлэлт, төлбөр тооцоо, орлогын хяналт, өглөг, сангийн менежмент	Санхүүгийн алба, SPD, Хуулийн мэргэжилтэн	15
2020/08/25	Нягтлан бодох дүрэм, төсөв, санхүү, ня-бо бүртгэл, сангийн менежмент, гэрээний хариуцлага ба эрх мэдлийг шилжүүлэх, гэрээний төрөл	Санхүүгийн алба, SPD, Хуулийн мэргэжилтэн	10
2020/08/31	Дотоод аудит, дотоод хяналт, үнэлгээ	Төлөвлөлт, мониторингийн алба	4

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

Дээрх сургалтыг оролцуулбал 2022 оны 5-р сар хүртэл нийт 92 удаагийн цахим хурлыг зохион байгуулсан. 2022 оны 6-р сарын 23-ны өдөр SPD-гийн цахим хурлыг зохион байгуулсан ба 6, 7-р сард зохион байгуулсан Монгол дахь сургалтаар дэмжлэг үзүүлж, 8-р сарын Япон дахь сургалтын дараа 9-р сард сүүлийн цахим хурлыг зохион байгуулсан.

Төсөв, орлого зарлагын менежментийн хувьд төслийн багийн зүгээс процессын хяналтыг хүснэгтэд нэгтгэх, төсвийн нэгтгэл болон тасаг нэгжид ажиллах арга барилын талаар заавар зөвлөгөө өгсөн. Түүнчлэн татаасны задаргааг магадалж, зөвлөмж өгсөн. 2019 онд дараах агуулга бүхий төсөв төлөвлөгдсөн.

Нийт төсөв 8 тэрбум төгрөг бөгөөд үүний 3.2 тэрбум төгрөг нь үйл ажиллагааны төсөв, 2.3 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын төсөв, 1.3 тэрбум төгрөг нь даатгалын орлого, 1.2 тэрбум төгрөг нь үйл ажиллагааны орлого юм. Гэвч хөрөнгө оруулалтын төсвийн зөвшөөрөл гараагүй тул дараагийн жилд шилжсэн. Нөгөөтээгүүр 2019 оны 10-р сарын 1-нд даатгалын магадлан итгэмжлэл авсан ба үүнээс хойших даатгалыг нэхэмжлэх боломжтой болсон.

2020 оны төсвийг хүснэгт-8-д заасны дагуу төлөвлөж, баталж, засварласан. Төсөвт орсон засвар нь АШУҮИС-тай холбоотой юм.

2020 оны 3-р сарын 18-ны өдрийн ЗГ-ийн хурлаар ЯМЭ нь ЭМЯ-наас БШУЯ луу шилжсэн. Тиймээс ЯМЭ-ийн үйл ажиллагааны төсөв нь ЭМЯ-ны 2.3 тэрбум төгрөг, БШУЯ-наас 8.0

тэрбум төгрөг тус бүр батлагдсан.

Хүснэгт 8 2020 оны төсөв (Төлөвлөсөн дүн, батлагдсан дүн, засварласан дүн)

(100 сая төгрөг)

	Үйл ажиллагааны төсөв			Хөрөнгө оруулалтын төсөв	Нийт
	Улсын төсөв	Даатгалын орлого	Үйл ажиллагааны орлого		
Төлөвлөсөн дүн	50	90	39	143	322
Батлагдсан дүн	12	33	0	23	68
Засварласан дүн	12	116.5	29	23	180.5

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

Хүснэгт 8-д заасны дагуу төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт орж, 2020 оны төсвийн гүйцэтгэл(үйл ажиллагааны төсөв) нь 14.75 тэрбум төгрөг байсан. Мөн 2020 оны санхүүгийн шалгалт(гадны аудит)-аар хамгийн ноцтой “Татгалзсан”(Disclaimer of Opinion) санал дүгнэлт авсан ба эмнэлгийн ерөнхий захирал, санхүүгийн албаны даргад хариуцлага тооцох нөхцөл байдал бий болсон. 2021 онд тус санал дүгнэлтийн засварт анхаарсан.

2021 оноос ЭМБ нь гүйцэтгэлд суурилсан ЭМДСангийн санхүүжилтийн тогтолцоонд шилжиж(Тус тогтолцоонд шилжсэний дараа Азийн Хөгжлийн Банк тусламж, дэмжлэг үзүүлсэн). ЯМЭ нь БШУЯ-ны улсын төсөвт байгууллагын хувьд татаас авах хэдий ч эмнэлэгт алдагдал гарч болзошгүй улмаас эмнэлгийн үйл ажиллагаа эхлээд удаагүй ЯМЭ-ийн тогтвортой байдал нь тулгамдсан асуудал болсон. 2021 оны төсвийн төлөвлөгөөг хүснэгт 9-д заасны дагуу бөгөөд хөрөнгө оруулалтын төсөв нэмэгдээгүй.

Хүснэгт 9 2021 оны төсөв (Төлөвлөсөн дүн, батлагдсан дүн, засварласан дүн)

(100 сая төгрөг)

	Үйл ажиллагааны төсөв			Хөрөнгө оруулалтын төсөв	Нийт
	Улсын төсөв/Татаас	Даатгалын орлого	Үйл ажиллагааны орлого		
Төлөвлөсөн дүн	93	84	27	20-	204
Батлагдсан дүн	35	236	16	—	287
Засварласан дүн	35	95.7	11.3	—	142

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

2021 оны 1-р сараас ТИС-ийн санхүүгийн удирдлагад ашигладаг “Эмнэлзүйн гүйцэтгэлийн харьцуулалтын хүснэгт”-г нэвтрүүлсэн. Тус хүснэгтээр мэдээллийг хянаснаар бэлэн мөнгөний орлого, үйл ажиллагааны ашиг(даатгалд нэхэмжлэх дүнг тусгана), тухайн оны төлөвлөгөө, орлого болон ашгийн харьцуулалт, өмнөх жилтэй харьцуулах боломжтой болсон. Түүнчлэн ор ашиглалтын хувь, амбулаторийн өвчтөний тоо, хагалгааны тоо зэрэг эмнэлзүйн тасаг бүрийн гүйцэтгэлийг ч харж шалгах боломжтой. Тусламж үйлчилгээний гүйцэтгэлд суурилсан үр ашигтай байдал шаардагдах тогтолцооны хувьд санхүүгийн мэдээлэл болгон

ашиглах боломжтой хүснэгт юм. 2021 оноос хойш энэхүү хүснэгтийг Төлөвлөлт, мониторингийн алба сар бүр тасралтгүй боловсруулж байна.

2021 оны төсвийн гүйцэтгэл(үйл ажиллагааны төсөв) нь 13.95 тэрбум төгрөг байсан. Гэвч 2022 онд шилжүүлэх даатгалын нэхэмжлэлийг хассан дүн юм. Нөгөөтээгүүр 2021 оны санхүүгийн шалгалт(гадны аудит)-аар санал дүгнэлтийн 4 шатлалын хамгийн сайн болох “Хангалттай”(Unqualified Opinion) санал дүгнэлт авч, өмнөх оны засварыг хийсэн.

2022 оны төсвийн татаасны задаргааг хариуцах байгууллага нарийн шалгасан. БШУЯ-наас СЯ-д өгөх тайлбарт ЯМЭ задаргаа, шаардлагатай бичиг баримтыг боловсруулж, тайлбар өгсөн боловч татаасны дүн буурсан. 2023 оноос хойш АШУҮИС-ийн харьяа төсвийн төлөвлөгөөг боловсруулна. Гэвч татаасыг үргэлжлүүлэн авах төлөвтэй байна. Татаасны хувьд ЯМЭ-ийн зорилгод нийцсэн агуулга шаардагдах ба төслийн багийн зүгээс төсвийн төлөвлөгөөнд татаасны зориулалтыг тасаг тус бүрд боловсруулж тусгах эсхүл татаас хуваарилагдах тасаг нэгжийг тодорхойлж боловсруулах талаар олон удаа хуралдаж, зөвлөмж өгсөн. ЯМЭ нь эхний арга хэмжээг хэрэгжүүлсэн.

2022 оны төсөвт улсийн хэмжээнд өөрчлөлт засвар хийсэн бөгөөд хүснэгт 10-т заасны дагуу ЯМЭ-ийн төсөвт өөрчлөлт орсон.

Хүснэгт 10 2022 оны төсвийн төлөвлөгөө

(100 сая төгрөг)

	Үйл ажиллагааны төсөв			Хөрөнгө оруулалтын төсөв	Нийт
	Улсын төсөв/Татаас	Даатгалын орлого	Үйл ажиллагааны орлого		
Төлөвлөсөн дүн	81	148	30	—	259
Батлагдсан дүн	30.8	150	46	—	227
Засварласан дүн	29	138	21		188

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

2021 оны 8-р сараас хойш ЯМЭ нь АШУҮИС-ийн харьяа (БШУЯ-наас шилжсэн) болохыг засгийн газар хэлэлцэж, 2022 оны 2-р сарын 9-ний өдөр засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэсэн. ЯМЭ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хувьд 2021 онд БШУЯ-ны сайд, АШУҮИС-ийн захиралтай ЯМЭ нь “Гүйцэтгэлийн гэрээ”-г байгуулсан. Эмнэлгийн үйл ажиллагаанд хамаарах “Гүйцэтгэлийн гэрээ”-г байгуулсан. Харьяалал шилжсэний дараа 2022 онд “Үр дүнгийн гэрээ” болох жилийн төлөвлөгөөг АШУҮИС-ийн захиралтай ЯМЭ нь байгуулсан. Тус гэрээнд 2021 оны АШУҮИС-ийн хөгжлийн стратегийг тусгаж, ЯМЭ-ийн тасаг, нэгж тус бүр жилийн төлөвлөгөөг боловсруулж, эмнэлгийн нэгдсэн төлөвлөгөөг хүснэгтэд нэгтгэсэн.

Нөгөөтээгүүр 2021 оны сүүлийн хагаст ЯМЭ-ийн ерөнхий захирлын зүгээс эмнэлгийн “Бизнес план”-г боловсруулах чиглэл өгсөн ба төслийн баг дэмжлэг үзүүлсэн. Төслийн баг болон ЯМЭ-ийн удирдлага нь төлөвлөгөөний ерөнхий бүтцийг хэлэлцэн хуралдаж, ЯМЭ ажлын хэсэг(WG)-г байгуулсан боловч ажлын хэсгийн дарга ажлаас гарсны улмаас тус

төлөвлөгөөг боловсруулах ажил зогссон. Иймд 2022 оны 6-р сард эмнэлгийн ерөнхий захирал хариуцсан ажилтан(эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, захиргаа, санхүү эрхэлсэн дэд захирал)-г томилж доороос дээш чиглэсэн ажлын арга барилаар боловсруулахыг үүрэг болгосон. Энэхүү арга барил нь OGSM(Objective, Goals, Strategies, and Measurements)⁴-г хэрэгжүүлж, төслийн багийн зүгээс тус ажлын тайлбар, үйл ажиллагааны талаар мэдээлэл хуваалцсан. OGSM-д суурилсан бизнес планыг боловсруулахад тасаг, нэгжийн дарга нарт зориулсан сургалтыг зохион байгуулж, санал солилцож, 7-р сарын 29-ний өдөр тасаг, нэгжийн дарга нартай хуралдаж, эмнэлгийн тоног төхөөрөмж, хүний нөөцийн зохион байгуулалт зэргийн өнөөгийн нөхцөл байдал, тусламж үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн уялдаа зэрэг мэдээллийг нэгтгэх заавар өгсөн. 9-р сарын одоогийн байдлаар хэд хэдэн материал цугларсан боловч хараахан бүрдээгүй байна. 2023 оноос төлөвлөгөөг төсөвтэй уялдуулан боловсруулахаар төлөвлөж байна.

Хүний нөөцийн менежментийн хувьд 2021 онд ЯМЭ-ээс уламжлалтын хэвтэн эмчлүүлэх тасгийг салгасан ба хүний нөөц болон орны тоо тодорхой хэмжээгээр багассан. 2022 оны 6-р сарын одоогийн байдлаар 104 ортой, батлагдсан нийт орон тоо 520 хүнээс 489 (үндсэн 360, гэрээт эмч, бусад 129)хүн ажиллаж, 31 хүний орон тоо дутагдаж байна(сувилагч 16, техникч 15). Ажлын байрны зарыг тогтмол зарлаж байна(эмнэлгийн мэргэжилтний цахим хуудас гм). Ажлын хяналтыг эмнэлзүйн тасаг, нэгжүүд хуруу уншуулах системээр хийж байна. Захиргааны албад нь албаны дарга шалгаж, нийт мэдээллийн хяналтыг хүний нөөцийн хөгжил, сургалтыг алба хариуцдаг. Тухайн хүний нөөцийн хяналтын систем нь ЭМХТ, даатгалын газар(эмчийн цалин, хөлс)-ынх бөгөөд БШУЯ-ны харьяа үед төрийн албан хаагчдын хүний нөөцийн систем, АШУҮИС-ийн харьяанд шилжсэнээр ERP(Enterprise Resource Planning: Байгууллагын Нөөц Төлөвлөлт)-ын хяналтын системийг ашиглаж байна. Одоогийн байдлаар зориулалт тус бүр өөр дээр олон төрлийн системийг нэгтгэсэн AXIS Karte⁵-гаар хийх боломжийг захиргаа, хүний нөөцийн хөгжил, сургалтын албанд шаардагдаж байна. Тулгамдаж буй асуудал нь нийт орон тоог хангаж, тогтолцоог бэхжүүлэхээс гадна эмнэлгийн мэргэжилтэнд өвчтөнд хэрхэн хандах талаар буюу түүний чанарыг сайжруулах шаардлагатайг захиргаа, санхүү эрхэлсэн дэд захирал зэрэг хариуцсан ажилтанд тайлбарлаж, шаардлагатай сургалтын төлөвлөгөөг боловсруулах талаар зөвлөмж өгсөн.

3) (Үйл ажиллагаа 1-2-4) Эрүүл мэндийн дэмжлэгийн алба, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженеринг зэрэг шинээр байгуулагдах алба, нэгжийн тухайд дүрэм журмын дагуу үйл ажиллагаа явуулахуйц технологийн дэмжлэг үзүүлж, ажлын байран дээр сургалт хийх

⁴ Үйл ажиллагааг Objective (бизнесийн зорилго, алсын хараа), Strategies (зорилгод чиглэсэн стратеги, арга хэмжээ), Goals (стратеги бүрийн үр дүн, зорилтот утга), Measurements (үнэлгээ, зорилго, үр дүнг хянах үзүүлэлт) гэсэн 4 талаас боловсруулах бүтэц.

⁵ ЯМЭ-т нэвтрүүлсэн Cloud base эмнэлгийн мэдээллийн систем. Дэлгэрэнгүй: “Үйл ажиллагаа 1-2-5”

Эрүүл мэндийг дэмжих албаны тухайд монголд анх удаа “Өвчтөн дэмжих төв” байгуулагдаж, 2019 оны 10-р сараас амбулаторийн үйл ажиллагаа эхлэхтэй хамтажиллаж эхлэсэн. Өвчтөн дэмжих төвийн үүрэг, ажиллагааны тухайд нэг дэх үед японд зохион байгуулсан сургалт (1-3 дах болон 7 дах)-д оролцогчид суралцсан боловч ажлаа солин, ажлаас гарах гэх мэтээр төвийн хүний нөөц тогтвор суурьшилгүй, япон маягийн өвчтөн дэмжих үйл ажиллагааны мэдлэг, туршлагыг нэвтрүүлж чадахгүй нөхцөл байдалтай байсан. Ингээд 2019 оны 11-р сард Өвчтөн дэмжих төвийн 3 ажилтныг 11 дэх удаагийн япон дах сургалтад (багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ: өвчтөн дэмжих төв, эрчимт эмчилгээний тасаг) хамруулж японы өвчтөн дэмжих төвийн үүрэг, ажиллагааны талаар танилцуулж, ЯМЭ-ийн Өвчтөн дэмжих төвийн дүр зургийн талаар хэлэлцэж ярилцсан. Энэ сургалтын танилцуулгыг Хүснэгт 11-д дурдав.

Хүснэгт 11 Япон дах 11 дэх удаагийн сургалтын ерөнхий танилцуулга (Өвчтөн дэмжих төв)

Сургалтын нэр	Багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ (өвчтөн дэмжих төв, эрчимт эмчилгээний тасаг)
Хугацаа	2019.11.25-2019.11.29 (5 хоног)
Оролцогчид	Д.Эрдэнэчимэг ӨДТ-ийн дарга Б.Хишигжаргал ӨДТ-ийн сувилагч Ц.Долгорсүрэн ӨДТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
Зорилт	Монголд анх удаа нэвтрүүлж буй “Өвчтөн дэмжих төв”-ийн үүрэг, ач холбогдлыг ойлгох, ЯМЭ-ийн ӨДТ-ийн үйл ажиллагааны дүр зургийн талаар хэлэлцэх, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах
Агуулга	<p>① Орны хяналт</p> <ul style="list-style-type: none"> - орны хяналтын гарын авлага - орны хяналтын үндсэн ойлголт, ашиглалт, ажлын агуулга - ажлын болон амралтын өдөр, оройн цагийн үйл ажиллагааны урсгал <p>② Эмнэлэгт хэвтэх, гарах үеийн дэмжлэг</p> <ul style="list-style-type: none"> - хэрхэн авч үзэх, процедур, ӨДТ-ийн ажилтнуудын үүрэг оролцоо - Жишээ танилцуулах <p>③ Нутаг дэвсгэрийн байгууллагуудтай хамтран ажиллах</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлэгт үзүүлэх, эмнэлгээм гарахад дэмжлэг үзүүлэх - Холбогдох байгууллагуудтай уялдаатай хамтарч ажиллах <p>④ Өвчтөнд зөвлөгөө өгөх</p> <ul style="list-style-type: none"> - Нэгдсэн зөвлөгөө, сувилахуйн зөвлөгөө, гэрээр тусламж үйлчилгээ авах, эрүүл мэнд, халамжийн зөвлөгөө - Мэргэжлийн зөвлөгөө (хавдар, хүнд өвчин, элэгний өвчин гэх мэт) - Тусгай зөвлөгөө (удамшлын зөвлөгөө, second opinion, амбулаторийн хоол, шим тэжээлийн зөвлөгөө гэх мэт)

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

Өнөөгийн байдлаар, ӨДТ нь өвчтөнд зөвлөгөө өгөхөөс гадна амбулаторийн давхруудад тавьсан санал хүсэлтийн хайрцгаар ирсэн санал, гомдлыг хариуцдаг. Санал гомдлын агуулгаас шалтгаалан 5 шатаар үнэлж, чухал агуулгыг эрсдэл, аюулгүй байдлын нэгж зэрэгт

танилцуулж, арга хэмжээ авдаг. 2020 оны 9-р сард дотрын хэвтэн эмчлүүлэх тасаг нээгдэж, тус төв нь эмнэлэгт хэвтэх, эмнэлгээс гарахад дэмжлэг үзүүлэхээс гадна орны хяналтыг ч мөн гүйцэтгэж байна. Коронагийн нөлөөгөөр хилээр зорчиход хориг хязгаартай болж, энэ хооронд онлайнаар үйл ажиллагааг нь магадалж, зөвлөгөө өгч ажилласан. Хязгаар хориг зөөлөрсний дараа ажлын байран дээрх сургалтаар технологийн заавар зөвлөгөө өгч, улмаар тус төвийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс төлөвлөгөө боловсруулж, бусад нэгжүүдтэй уялдаатай хамтран ажиллах явцыг бэхжүүлсэн. Үүний дүнд, өвчтний үндсэн мэдээллийн форматыг нэгтгэж, сувилахуйн албанд хэрэгжүүлдэг ээлж солилцоход оролцож /ӨДТ дотор зохион байгуулдаг/ компьютерээр орны хяналтыг харах боломжтой болгох зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна.

ME (Medical Engineer: эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженеринг) “эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба нь ЯМЭ-т хандивлагдсан, нийлүүлэгдсэн бүх тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, засвар зэргийг хариуцаж ажиллана. Коронагийн цар тахлаас өмнө тоног төхөөрөмж, хэрэгслийг түгээх, баталгаат хугацаа, баталгаат засварын агуулгыг магадлах, техникийн бичиг баримтыг цэгцлэх, хэвийн ажиллагааны үзлэг хийх, эвдэрсэн тохиолдолд мэдээлэх тогтолцоо зэргийн талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан. Мөн, буцалтгүй тусламжийн төслөөс олгосон тоног төхөөрөмжийн тухайд монголд байх диллер компаниас эмч, техникч зэрэгт ашиглахтай холбоотой сургалт хийгдсэн боловч энэ албаны инженерүүдэд чиглэсэн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахтай холбоотой сургалтууд бараг хийгдээгүй, тоног төхөөрөмжийн зохистой менежмент хийх арга барилын талаар ойлголтгүй байсан. Иймд, төслийн зүгээс нийлүүлэгч компанид хандаж сургалт явуулах хүсэлт тавьж, ЯМЭ-ийн тус алба болон нийлүүлэгч диллер компанийн уялдаа, харилцааг бэхжүүлж ажилласан. Мөн, диллер компанитай завсар үйлчилгээний гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлсэн. Улмаар, ME-г оролцуулсан багаар үзүүлэх тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх нь дэлхийн түвшний тусламж үйлчилгээ үзүүлдэг болохыг зорьж буй ЯМЭ-ийн хувьд маш чухал тул японы эмнэлзүйн ME-н үүрэг, оролцооны талаар японд зохион байгуулсан 10 дах удаагийн сургалтад (багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ: хагалгааны тасаг) тус албанаас нэг ажилтан оролцуулсан⁶. Энэ сургалтаар цусны хийн анализаторын төхөөрөмжийн засвар үйлчилгээ, хагалгааны тасгийн багаж, хэрэгслийн бэлэн байдал, ариутгал, халдваргүйжүүлгийн процесс, халдвар хамгаалалтай холбоотой байгууламж, тоног төхөөрөмж зэрэгтэй холбоотой заавар зөвлөгөө өгсөн.

Дээр дурдсан технологи шилжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй хийж байсан боловч коронагийн нөлөөнөөс эмнэлгийн тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал хариуцаж байсан япон мэргэжилтэн 2 жилийн турш монголд ажиллах боломжгүй байх хооронд тус албаны

⁶ Монголын ME нь тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, хангамж нийлүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, бүртгэх, ажилтнуудад ажиллуулах зааврыг өгдөг хүний нөөц бөгөөд харин японых бол багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний нэг бүрэлдэхүүн болохынхоо хувьд хагалгааны тасагт мэдээгүйжүүлгийн тоног төхөөрөмж, хиймэл амьсгалын аппарат зэргийн ажиллагааг хариуцдаг хүний нөөц байдаг.

ажилтнууд ихэнх нь солигдож, 2022 оны 7-р сард монголд хийсэн сургалтын үеэр өмнө нь зааж сургаж байсан 11 ажилтнаас ердөө 2 л хүн үлдсэн байсан нь тодорхой болсон. Иймд монголд хийсэн сургалтын үеэр япон маягийн эмнэлгийн менежмент дэх эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны зохион байгуулалтыг бэхжүүлэх, болон тоног төхөөрөмжийн урсгал засвар үйлчилгээ, зохицуулах үйл ажиллагааны чадавхийг сайжруулахад чиглэсэн технологийн талын заавар зөвлөгөө өгөх ажлыг мөн гүйцэтгэсэн.

4) (Үйл ажиллагаа 1-2-5) Эмнэлгийн мэдээллийн албаны стратеги төлөвлөгөөнд үндэслэн мэдээллийн систем (RIS (Радиологийн мэдээллийн систем) багтана) бодитоор нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. RIS-ийн хувьд RIS-тэй холбоотой тоног төхөөрөмжийг нийлүүлэх, үйл ажиллагааны тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлнэ. RIS-тэй холбоотой тоног төхөөрөмжийн нийлүүлтийн хувьд буцалтгүй тусламжаар хамтран ажиллах төслийн хүрээнд нэвтрүүлэхээр төлөвлөж буй PACS (Зураг хадгалах ба солилцох систем) -тэй нийцэж байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн мэдээллийн технологийн системийг бий болгоход шаардлагатай бусад тоног төхөөрөмжийн хувьд ч шаардлагатай бол хангана.

Мэдээллийн системийг нэвтрүүлэх тухайд, эмнэлэг нээхийн өмнөх симуляциар эмнэлгийн мэдээллийн систем(HIS)-ийн үйл ажиллагааг эхлүүлж үзэхэд янз бүрийн асуудлууд гарч ирсэн. Тэр дундаас том асуудлаас тодруулбал, үйлчлүүлэгчээс эмчилгээний төлбөр давхар авахаар болсон, нийлбэр дүн бодогдоход даатгалаас эмнэлгийн авах төлбөр нь 0 байсан зэрэг төлбөр, тооцооны үйл ажиллагаатай холбоотой олон асуудал байсан. Асуудлын шалтгаан нь программчлалын алдаа, эмнэлгийн хувьд даатгалаас авах төлбөр нь зөвшөөрөгдөж батлагдаагүй байсан зэрэг асуудлууд байсан. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд зарим үйл ажиллагаагаа цаасаар явуулах хэлбэрт шилжүүлж, онцгой чухал хэсгийн хөгжүүлэлтийг яаравчлан, амбулаторийн эмчилгээ үйлчилгээг эхлүүлсэн.

2020 оны 1 сард HIS-ийн хөгжүүлэлтийн нөхцөл байдлыг хянах зорилгоор АШУУИС, ЭМЯ-тай хамтран шалгалт хийсэн. Хамтарсан шалгалтаар амбулаторитой холбоотой системийн хувьд хэд хэдэн жижиг асуудал илэрсэн. Мөн хэвтүүлэн эмчлэх тасаг ба мэс заслын зэрэг үйлчилгээний системийн хөгжүүлэлтийн хувьд хангалтгүй болох нь илэрсэн. Тухайлбал, 1) хэвтүүлэн эмчлэх тасгийн өвчний түүх хөгжүүлэгдээгүй, 2) эмнэлэгт хэвтэх үеийн үзлэг, эмчилгээний захиалга болон нягтлан бодох бүртгэлийн функц хөгжүүлэгдээгүй зэрэг асуудлууд байсан. Хөгжүүлэлтэд саад болж байсан гол хүчин зүйлүүд гэвэл хэвтүүлэн эмчлэх тасагт өвчний түүх хөтлөх процесс болон төрөл бүрийн шинжилгээ, эмчилгээний захиалга, төлбөрийн хэлбэр нь тодорхойгүй зэрэг асуудлууд байсан. Хэвтүүлэн эмчлэх тасаг нээгдэж байсантай холбоотой үйл ажиллагаа нь тодорхой баталгаажаагүй үе шатанд бүрэн хэмжээний систем хөгжүүлэх боломжгүй байсан тул, 1) хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг цаасан хэлбэрээр үйл ажиллагааг эхлүүлэх, 2) үйл ажиллагаа нь бүрэн тогтворжиж, баталгаажсан үе шатанд системийн хөгжүүлэлт хийх, нэвтрүүлэхээр төлөвлөх (2021 оны сүүлийн хагасаас

хэрэгжүүлэх) тухай АШУҮИС, ЯМЭ-ийн удирдлагуудтай санал нэгдсэн. Нөгөөтэйгүүр HIS-ийн хөгжүүлэлт удаашралтайг харгалзан 7 сарын эхнээс 6 программист нэмж ажилд авсан, тэдгээр программистуудын хувьд хэсэг хугацаанд амбулатори болон хэвтүүлэн эмчлэх тасгийн аль алинд шаардлагатай SPD болон санхүүгийн функц зэргийн хөгжүүлэлтэд ажиллуулахаар болсон. Ийм байдлаар хөгжүүлэлтийн явцыг төлөвлөн, доор тэмдэглэсэн дагуу шат дараатайгаар үйлдэл функцуудыг нэвтрүүлэх талаар Монгол талын холбогдох хүмүүстэй санал нэгдсэн.

- 2020 оны 7 сараас 2021 оны 6 сар: Санхүү, нягтлан бодох бүртгэл, SPD-тэй холбоотой систем гүйцэтгэх
- 2021 оны 7 сараас 2022 оны 6 сар: Хэвтүүлэн эмчлэх тасаг, мэс засалтай холбоотой систем гүйцэтгэх

Мөн түүнчлэн системийг боловсруулахад хэрэглэгчид болон хөгжүүлэгчдийн хооронд нягт зөвлөлдөх шаардлагатай байдаг тул 2020 оны 8 сард санхүү, Нягтлан бодох бүртгэл, SPD-тэй холбоотой системийг хөгжүүлэх ажлын хэсгийг байгуулж, 2021 оны 7 сард Хэвтүүлэн эмчлэх, мэс засалтай холбоотой системийг хөгжүүлэх ажлын хэсгийг мөн адил байгуулсан. Түүнээс гадна эмнэлэгт мэдээллийн технологийг зохистой хэрэглэх чадамжтай болгох тал дээр дэмжлэг үзүүлэхийн тулд, 2020 оны 9 сарын эхээр бүс нутаг дахь мэдээллийн технологийн зөвлөхийг ажилд авч ажиллуулж эхэлсэн.

Гэвч 2021 оны 7 сар орчмоос ЭМЯ-ны төлбөр тооцооны системд өөрчлөлт орж, Эмнэлгийн мэдээллийн системийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын системд холбож, даатгалын нэхэмжлэхийг цаг тухай бүрд нь (real-time) хийж чадах систем шаардлагатай болсон. Тухайн үеийг хүртэл хөгжүүлж байсан систем нь нэхэмжлэхийг цаг тухай бүрд нь үүсгэхийг дэмжих функцгүй байсан тул өөрсдийн хөгжүүлж байсан HIS-ийн хөгжүүлэлтийг зогсоохоор шийдвэрлэсэн. Түүнчлэн ажлын хэсгийг байгуулж, Монгол дотоодын систем нийлүүлэгчдийн хөгжүүлж байгаагаа систем тус бүрд үнэлгээ явуулж, Axis Systems компанийн клауд хэлбэрийн HIS системийг (Axis Karte) нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

2022 оны 4 сарын 1-нд АШУҮИС болон Axis Karte-ийн нүүлүүлэгч компани хооронд албан ёсны гэрээ байгуулагдан, түүнээс хойш Axis Karte төвтэй HIS-ийг бүтэцжүүлэн, ажиллуулахад анхаарлаа хандуулахаар болсон. HIS-ийн ерөнхий дүр зураг болон Axis Karte-н хангаж байгаа модулиуд (улаан тасархай шугам доторх)-ын ерөнхий зураглал доорх байдалтай байна.

ЭМНЭЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ



Тодруулга: PACS Эмнэлгийн зураг хадгалах, солилцох удирдлагын систем, RIS Радиологийн мэдээллийн систем
Тайлбар: Цаашдаа хөгжүүлэлт шаардлагатай нь, AXIS Karte(улаан тасархай тойрог дотор)-ийн гадна байгаа хэсэг.
Эх сурвалж: Төслийн баг бэлтгэсэн.

Зураг 3 ЯМЭ-ийн HIS-ийн нийт бүрэлдэхүүн хэсгийн концепцийн диаграмм

Түүнчлэн одоо байгаа Axis Karte системээр хангагдаж байгаа HIS модулиуд болон цаашид нэвтрүүлэх (нэмэлтээр) төлөвлөгөөтэй модулиудын талаар дараах хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 12 Axis Karte дахь HIS модуль

Axis Karte системээр хангагдаж байгаа HIS модулиуд		Цаашид нэвтрүүлэх (нэмэлтээр) төлөвлөгөөтэй модулиуд			
Хувийн хэрэг	Ажилтны хувийн хэрэг Үйлчлүүлэгчийн хувийн хэрэг	Мэс заслын төлөвлөгөө	Хоол	Хэвтэн эмчлүүлэгчийн хоол	
Хоол	Ажилтны өдрийн хоолны бүртгэл Хоолны тайлан		Мэс заслын багийн цаг бүртгэл Маягтууд Хагалгааны эм, хэрэгслийн зарлага	Эмнэлгийн хуудас	Цахимаар лист бичих
	Хүний нөөц		Байгууллагын бүтэц Албан тушаал Ажилтны мэдээлэл Хандах эрх Ажилтны цахим үнэмлэх	Хэвтэн эмчлүүлэх	Хэвтэн эмчлүүлэгчийн захиалга өгөх
Үйлчилгээ		Үйлчилгээний бүртгэл Үзлэгийн цагийн хуваарь	Дугаар дуудах		Бүртгэлийн ажилтан Карте програмаас дугаар дуудах
		Статистик, тайлан	Амбулатори болон Стационарийн тайлан Үйлчилгээний захиалгын тайлан		Баримт бичиг
ЭМД	ЭМДЕГ-н систем руу дамжуулж байгаа даатгалын мэдээлэл Info Багцгийн тайлан Хөнгөлөлттэй эмийн хүсэлтүүд		Хэргийн бичиг хөтлөлт	Албан бичиг хөтлөлт	
	Төлбөр тооцоо	Үйлчлүүлэгчийн төлбөрийн түүх Төлбөрийн буцаалт Бэлэн мөнгөний орлогын тайлан Үйлчилгээний төлбөрийн тайлан	Лаборатори		
		Цус, цусан бүтээгдэхүүн		Захиалга Олголт	
Эмийн хэрэглээ				Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл Эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга Эм, эмнэлгийн хэрэгслийн олголт	Карте
	Хүлээн авах	Хүлээн авах			

мэдээлэлтэй холбоотой үндсэн журмуудыг дотооддоо хөгжүүлж байсан HIS-ийг ашиглахаар тооцон боловсруулсан байсан тул, нийцсэн хэлбэрт оруулан өөрчлөн шинэчлэх шаардлага гарсан шалтгаанаар, 2022 оны 6 сарын дундаас төслийн баг (Мэдээллийн технологийн мэргэжилтэн) тус эмнэлэг дээр очиж ажиллах хугацаандаа үндсэн журмын дагуу үйл

ажиллагаа явагдаж байгаа эсэх зэргийн талаар аудит хийн, засаж шийдвэрлэх шаардлагатай зүйлсийн талаар зөвлөгөө өгсөн. Шалгасан журмыг доор дурдав.

- Эмнэлгийн сервер ашиглах журам
- Эмнэлгийн И-Мэйл хэрэглэх журам
- Өгөгдөл зохицуулах журам
- Мэдээллийн аюулгүй байдлын журам
- Антивирусын програм ашиглах журам
- Эмнэлгийн мэдээллийн систем ашиглах журам

RIS (Радиологийн мэдээллийн систем)-ийн тухайд, эмнэлэг ашиглалтад орох үед нэвтрүүлсэн байх нь зүйтэй байсан ч Монгол талын хөгжүүлж байсан HIS нь хөгжүүлэлтийн явцдаа байсан тул интеграци хийж холбон ажиллуулахад шаардлагатай HIS-ийн техникийн дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжгүй байснаас эмнэлэг ашиглалтанд орсон эхэн үед цаасаар үйл ажиллагаа явуулж, нээгдсэнээс хойш холбож зохион байгуулахаар төлөвлөгөөн дээр тулгуурлан зөвлөгөөгөө үргэлжлүүлж байсан. Тухайн үеийн анхны төлөвлөгөөгөөр бол хоёр дахь жилийн Японд болох сургалтын үеэр RIS-ийн техникийн үзүүлэлтүүдийг эцэслэн гаргах төлөвлөгөөтэй байсан. Гэсэн хэдий ч шинэ коронавирусын нөлөөгөөр улс хооронд зорчих хязгаарлалтаас гадна дээр дурдсанчлан Axis Systems компанийн клауд хэлбэрийн HIS нэвтэрсэнтэй холбоотойгоор нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдсөн. Угтаа бол 5-10 жилийн дараах эмнэлгийн системийн ажиллааны талаар бодолцон үзвэл хамгийн боломж өндөртэй олон улсын стандарт болох HL7 хэмээх стандартыг ашиглан RIS холбох нь хамгийн дээр гэдэг шалтгаанаар, Axis Systems компанийн HIS-тэй RIS холбох аргачлалын талаар багагүй хэлэлцсэн. Эхэндээ Axis Systems-ийн захирал нь HL7-г ямар ч асуудалгүй холбох боломжтой гэж санал нийлж байсан хэдий ч, сүүл хэсэгт тус аюулгүй байдлын хувьд асуудалтай зэрэг шалтгаанаар HL7 стандартаар холбогдоход хүндрэлтэй гэж компанийн захирал хэлсэн.

Иймээс төсөл хэрэгжих хугацааг харгалзан, төслийн баг нь Дүрс оношилгооны тасагтай хамтран хэд хэдэн удаа хуралдан хэлэлцэж, хэрхэн RIS ажиллуулах, хамгийн гол нь юу шаардлагатай байгаа, албан ёсоор даатгалын орлогыг бүрдүүлэхийн ЭМДЕГ руу ямар мэдээлэл илгээх шаардлагыг тодруулан, Японд нэвтрүүлдэг зонхилон хэрэглэгддэг RIS-ийн оронд ЯМЭ-ийн өнөөгийн нөхцөл байдалд тохируулан өөрчилсөн RIS-ийг хөгжүүлж нэвтрүүлэхээр болсон. Тодруулбал, RIS өгөгдлийг зургийг JPEG, шинжилгээний хариуг HTML хэлбэрээр PACS-ийн сторэж серверт хадгалан, Axis Karte тал сторэж серверээс AP (Access Point) дамжин өгөгдлийг татаж авахаар системийг төлөвлөсөн. Энэ ажлын хувьд сторэж сервер хүртэлх хэсгийг хийх ажлыг дэмжин ажилласан бөгөөд үлдсэн хэсэг нь Axis Systems компанийн гүйцэтгэх ажлын цар хүрээнд хамаарах болно. Нөгөөтэйгүүр, өөрчлөн тохируулсны үндсэн дээр өнөөг хүртэл дүрс оношилгооны зураг харах боломжтой компьютер нь, зөвхөн PACS-ийн зориулалттай 49 компьютер л байсан бол, вэб үзэгч программ ашиглах боломжтой болсоноор эмнэлгийн бүх компьютер дээр зураг үзэх боломжтой давуу талтай болсон. RIS-ын ажил 9 сарын эхээр хэрэгжиж дууссан.

Эмнэлгийн сүлжээний тухайд, өнөөг хүртэл үе үе гэмтэл гарч, HIS-ийн компьютеруудын холболт тасрах тохиолдол байнга гардаг. Үүний шалтгаан нь DHCP систем дэх алдаа болон ажилтан сүлжээний тохиргоог өөрчилсөнтэй холбоотой байсан. Хойшид ийм байдлыг арилгахын тулд сүлжээний бүтэц, тохиргоог дахин судалж, авч үзэх шаардлагатай. Мөн зөвхөн бүтэц, тохиргоо, тоног төхөөрөмжөөс гадна хүний үйлдэл, алдаа зэрэг хувь хүнээс хамааралтай асуудал ч байдаг тул зааварчилгаа, процедурыг ойлгомжтой тодорхой болгон баримтжуулах болон ажил хүлээлцэх үйл ажиллагааны тогтсон тодорхой байдал нь бүрэлдэх хэрэгтэй байгаа. Одоогоор Мэдээллийн технологийн албанд сүлжээний мэргэжилтэн байхгүй, хүний нөөц бүрдүүлэхэд хүндрэлтэй байгаа тул цаашид сүлжээний үйл ажиллагааны хувьд бусад компани, байгууллагаас үйлчилгээ авах зэрэг арга байж болох талаар зөвлөсөн. Үүний үр дүнд Мэдээллийн технологийн албаны сүлжээ хариуцсан хуучин ажилтан шаардлагатай үед эмнэлэгт ирж нягтлах зэрэг ажлыг хийж байгаа ч зохих урсгал үйлчилгээ, зохицуулалтанд одоогийнхоос илүү давтамжтай ажиллах шаардлагатай байгаа.

PACS серверийн хувьд, СІТ компаниас⁷ Мэдээлэл технологийн албанд хүлээлцэн авах ажлын бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. Эмнэлгийн зүгээс PACS-ийг СІТ компаниас хүлээн авахтай холбоотойгоор ямар нэгэн зөрчил, дутагдалгүй хүлээн авав, түүнчлэн хүлээн авахдаа эд хөрөнгийн тооллого, бүртгэл хийх шаардлагатай тул төслийн баг PACS-тай холбоотой бичиг баримтыг PSP компаниас⁸ авч эмнэлгийн талд өгсөн.

5) (Үйл ажиллагаа 1-2-6) Эм тариа, эмнэлгийн багаж, хэрэгсэл, элэгдэж хорогддог бараа, материалыг ханган нийлүүлэх хамгийн зохист тогтолцоог бүрдүүлэх

Эмнэлэг дотоодын хангамж, нийлүүлэлт, түгээлтийн системийн тухайд монголд анх удаа нийт эмнэлгийн хэмжээнд үйлчлэх нэгдсэн хангамж, нийлүүлэлт, түгээлтийн (SPD)-ийн системийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Төслийн хүрээнд симуляци хийх замаар бараа материал болон эм, эмийн бүтээгдэхүүнийг тус бүр менежмент хийх арга, агуулхаас амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг хүртэлх түгээлт, зөөврийн урсгал, нөхөн цэнэглэх, захиалга өгөх давтамж, хугацаа, бохирыг зөөвөрлөх урсгал зэргийн тухай магадлаж, шийдвэрлэвэл зохих асуудлыг нягталж, сайжруулах арга хэмжээний талаар зөвлөгөө өгч ажилласан. Дотрын болон эрчимт эмчилгээний хэвтэн эмчлүүлэх тасгийн үйл ажиллагааг эхлүүлэхэд болон эхлүүлсний дараа ч бараа материал, эм, эмийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн нөхцөл байдал, нийлүүлэгч компанийн нийлүүлэлтийн нөхцөл байдал зэрэг өнөөгийн гч компанийн нийлүүлэлтийн нөхцөл байдал зэрэг л байдал, жруулах арга ийн хэмжээнд үйл

2020 оны 7-р сараас 9-р сард Хүснэгт 13-т дурдсанчлан SPD-тэй холбоотой нэгжийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Нөгөө талаар, өнөөг хүртэл зааж, зөвлөж ирсэн SPD-н албаны ажилтнууд ажлаасаа гарах, холбогдох алба, тасаг нэгжид түгээлт саатах,

⁷ Буцалтгүй тусламжаар өгсөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүс нутгийн төлөөлөгч

⁸ Буцалтгүй тусламжаар өгсөн PACS-ийн Япон нийлүүлэгч

эмнэлгийн алба, тасаг, нэгжүүд хоорондын уялдаа холбоо гэ мэт асуудлууд гарч байсан. Төслийн баг ЯМЭ-ийн Хангамж, түгээлтийн хорооноос бараа материал болон эм, эмийн бүтээгдэхүүний хангамж, түгээлтийн нөхцөл байдал, холбогдох алба, тасаг, нэгж хоорондын мэдээлэл хуваалцах зэрэг үйл ажиллагааны талаар тайлан авч, онлаинаар SPD-тэй холбоотой зөвлөгөө, заавраар хангаж ажиллав.

Хүснэгт 13 SPD сургалтын талаарх ерөнхий мэдээлэл

SPD 1 дэх сургалт	
Хэзээ	2020.07.09 (Пү) 11:00~13:00
Оролцогчид	- SPD албаны дарга - Санхүүгийн - Эмнэлгийн - Эм зүйн албаны эм албаны орлого мэдээллийн албаны зүйч зарлагын ня-бо IT зөвлөх - Эмнэлгийн мэдээллийн албаны дарга
Сургалтын агуулга	- Бараа материал худалдан авах процедур, SPD-с захиалга өгөх - Үндсэн хөрөнгийн менежмент (үндсэн хөрөнгө бүртгэлийн дэвтэр, элэгдэл хорогдол, бараа материалыг ангилж менежмент хийх арга, тооллого) - SPD-н ажил (ажлын үүрэг, хариуцлагын тухай, тогтмол хэрэглээний цикл)
SPD 2 дах сургалт	
Хэзээ	2020.07.28 (Мя) 10:00~11:30
Оролцогчид	- Захиргаа хариуцсан дэд захирал - Төлөвлөлт, мониторингийн албаны төсвийн эдийн засагч - SPD албаны дарга - Эмнэлгийн мэдээллийн албаны систем - Сувилахуйн албаны дэд дарга - Аналист - Нягтлан боох бүртгэлэийн албаны орлогын ня-бо - Эмнэлгийн мэдээллийн албаны дата аналит
Сургалтын агуулга	- Эмнэлгийн хэрэгслийн хороо яаралтай худалдан авалтыг батлах процедур - Худалдан авах бараа материалын жагсаалтыг алба, тасаг, нэгжүүд хооронд хуваалцах - Боловсруулж буй дүрэм, журмыг мэдээллийг холбогдох алба, тасаг, нэгж хооронд хуваалцах - Бараа материал худалдан авах, менежмент хийх удаирдлага, зохион байгуулалт (худалдан авалт, менежмент хариуцсан ажилтныг тусгаарлаж, зүй зохисгүй үйлдлээс сэргийлэхүйц удирдлага, зохион байгуулалттай болгох) - SPD модулийг хөгжүүлэх (агуулахын үлдэгдлийн менежмент, худалдан авах үнийн тэмдэглэлийн менежмент, алба, тасаг, нэгжүүдээс SPD албанд захиалга өгөх, түгээх менежмент, өвчтөн тус бүрийн хэрэгслийн ашиглалтын менежмент)
SPD 3 дах сургалт	
Хэзээ	2020.08.17 (Да) 14:00~16:00
Оролцогчид	- Эмнэлгийн - SPD - Сувилахуйн албаны дэд дарга

	<ul style="list-style-type: none"> захирал хангамжийн - Эмнэлгийн мэдээллийн - Эмнэл зүй албаны дарга албаны дата аналит хариуцсан дэд - Санхүүгийн - Эмнэлгийн мэдээллийн захирал албаны дарга албаны систем аналит - Захиргаа - Эм зүйн - Гадаад харилцааны хариуцсан дэд албаны дарга мэргэжилтэн захирал - Шим - Чанар хариуцсан тэжээлийн дэд захирал албаны дарга
Сургалтын агуулга	<ul style="list-style-type: none"> - ЯМЭ-ийн эмнэлгийн хэрэгсэл, эм, эмийн бүтээгдэхүүн, бусад элэгдэж хорогддог бараа материалын худалдан авалт, нийлүүлэлтийг хянах арга, хадгалах арга, SPD албанаас хийх түгээлжийн аргыг магадлах - Токүшимагийн ИС-ийн эмнэлгийн жишээ - Тулгамдаж буй асуудлыг магадлах, сайжруулах арга хэмжээ
SPD 4 дэх сургалт	
Хэзээ	2020.08.19 (Лха) 15:00~16:30
Оролцогчид	<ul style="list-style-type: none"> - Эмнэл зүй - SPD албаны дарга - Эм зүйн албаны хариуцсан дэд - Шим тэжээлийн дарга захирал албаны дарга - Эмнэлгийн - Захиргаа хариуцсан мэдээллийн албаны дэд захирал дарга
Сургалтын агуулга	<ul style="list-style-type: none"> - Хэвтэн эмчлүүлэх тасгийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай бараа материалын хангамж, нийлүүлэлт, түгээлт, менежментийн зохион байгуулалтыг бүрдүүлэх - Зүй зохисгүй үйлдлээс сэргийлэхийн тулд захиалга болон нийлүүлэлтийн үед шалгаж нягтлах зохион байгуулалтыг бүрдүүлэх - Бараа материалын менежмент, агуулхын үлдэгдлийн менежмент
SPD 5 дах сургалт	
Хэзээ	2020.09.16 (Лха) 11:00~13:00
Оролцогчид	<ul style="list-style-type: none"> - Захиргаа хариуцсан - Сувилахуйн - Байгууламжийн дэд захирал тусламж албаны дарга - SPD албаны дарга үйлчилгээны дэд - Эрчимт - Эм зүйн албаны дарга эмчилгээний дарга - Хэвтэн эмчлүүлэх тасгийн ахлах тасаг-1-н ахлах сувилагч сувилагч
Сургалтын агуулга	<ul style="list-style-type: none"> - ЯМЭ-ийн хэвтэн эмчлүүлэх тасгийг нээсний дараах агуулах дүүргэлтийн байдал, нийлүүлэгчид захиалга өгөх, тулгамдаж буй асуудлыг магадлах - ЯМЭ-ийн байгууламжийн менежментийн удирдлага, зохион байгуулалтыг магадлах (АШУҮИС-ийн дэвсгэр талбай ба эмнэлгийн мэдлийн талбайн хязгаар, эмнэлгийн талбай руу нэвтрэх хэсгийн хаалт байгаа эсэх, автомашин зогсоолын өвчтөн ба ажилтнуудын хэрэглээний хязгаар, автобусны буудлаас өвчтөн ирэх урсгал, задгай талбайд байрлах байгууламж, төхөөрөмжийн хяналт) - Токүшимагийн ИС-ийн эмнэлгийн жишээ

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

SPD нь HIS-д тусгагдах төлөвлөгөөтэй байсан боловч HIS-ийн хөгжүүлэлтийн явц дунд байгаа тул 2020 онд мэдээллийг цаасаар хянаж удирдах арга замыг ашиглан, захиалга,

нийлүүлэлт хийж байсан. 2021 оны сүүлийн хагаст HIS-ийг анх эхлэхдээ өөрсдөө хөгжүүлж байснаа Axis Systems компанийн систем (Axis Karte)-г нэвтрүүлэхээр өөрчлөгдсөн боловч Axis Karte нь санхүү болон бараа материалын менежментийн үйлдэл хийх боломжгүй байсан тул SPD алба нь тэр хүртэл хэрэглэж байсан UNICUS⁹-г үргэлжлүүлэн ашиглаж агуулахын менежмент хийж ирсэн. 2022 оны 6-р сарын 6-ны байдлаар Axis Karte-р эмнэл зүйн үйлчилгээний хүрээнд өвчтөнд зориулах эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой мэдээллийг авах боломжтой болсон боловч нийт SPD-н хэмжээний менежментийг хийхийн тулд Axis Karte-д төвлөрсөн HIS-ийг улам хөгжүүлэх шаардлагатай (“Зураг 3 ЯМЭ-ийн HIS-ийн ерөнхий бүтэц”-ийг харна уу)

2020 оны эхэн үеэс шинэ төрлийн корона вирусийн нөлөөгөөр 2021 оны дунд үе хүртэл монголд дэмжлэг үзүүлж ажиллах боломжгүй болсон тул SPD албанд үзүүлэх дэмжлэгийг дээр дурдсанчлан онлайнаар зохион байгуулж байсан “Санхүүгийн хурал”-аар дамжуулан хэрэгжүүлж байв. Юуны өмнө, хуучин хэрэглэж байсан Excel-р бараа материалын менежментийн форматыг төслийн баг сайжруулж, уг форматын дагуу агуулхын үлдэгдлийг хянаж, тасагт байгаа эмнэлгийн хэрэгсэл зэргийг хянахад ашиглаж байв. Нөгөөтэйгүүр, 2021 оны 7-р сард SPD албаны дарга өөрчлөгдөж, төслийн баг ЯМЭ-ийн тогтмол хугацаанд хийдэг тооллогод үндэслэн агуулхын үлдэгдлийн мэдээллийг UNICUS ашиглан идэвхжүүлснээр бараа материалын үлдэгдлийг зөв тодорхойлж, мэдээллийг оруулахад анхаара хандуулсан. Ингэснээр UNICUS-р хянах арга замаар агуулхын менежментийг зохистойгоор хэрэгжүүлж, 2022 оны эхээр хөндлөнгийн байгууллагын хийсэн аудитаар эмнэлгийн хэрэгслийн тухайд агуулхын нярав системд оруулж, тусгаж ирсэн мэдээлэл нь бодит үлдэгдэлтэйгээ зөрөхгүйгээр тулж байсныг үнэлсэн.

Шийдвэрлэвэл зохих асуудлын нэг бол зарлага гарсны дараах эмнэлзүйн тасгийн хэрэглээний мэдээлэл нь Axis Karte-р хянагддаг боловч зүй зохист хугацаанд зөв тусгагддаггүй тул эмнэлзүйн тасгийн нөөц болон SPD албаны агуулахад үлдэгдэл хүрэлцэхгүй байх асуудал юм. Энэ нь Axis Karte-н хүрээний асуудал бөгөөд хэрэглэсэн хэрэгслийг автоматаар тооцоолох боломжгүй тул өнөөгийн байдлаар SPD алба гараар тоолж байна. Нөгөө талаар, хэрэгцээгүй үлдэгдэл болон хэрэглэх төлөвлөгөөгүй эмнэлгийн хэрэгслийг захиалах гэсэн асуудал мөн гарч байна. Энэ нь, эмнэлзүйн тасагт шаардлагатай зүйлсийг хүний хүчин зүйлийн алдаа болон HIS-ийн хангалтгүй чанар, аль алины улмаас мэдээллийг бүрэн гүйцэд авахгүй байгаа шалтгаантай.

Өнөөгийн SPD албаны удирдлага, зохион байгуулалт руу орохоос өмнө 2020 онд БШУЯ-ны тотаци 8 тэрбум төгрөг оны эцсээр олгогдсон. Үүнийг оны эцэст багтаан их хэмжээний бараа материал худалдан авахад зарцуулсан бөгөөд ингэхдээ шаардлагагүй нөөц, зохисгүй хангамж нийлүүлэлт хийгдэж, энэ тухай аудит ч асуудал болгож тавьж байсан. Өнөөгийн SPD албаны дарга томилогдсон 2021 оны сүүлийн хагасын үйл ажиллагаа нь өмнө дурдсан

⁹ Монголын дотоодын вендерийн хөгжүүлсэн эмнэлгийн санхүүгийн систем

асуудалд арга хэмжээ авахад зориулагдсаж, нийлүүлэгч компанитай байгуулсан гэрээг нягтлах, бараа материалыг солих (гэвч зах зээлийн үнээс хэд дахин илүү үнээр нийлүүлэгдсэн зүйлсийг солих ямар ч боломжгүй) гэх мэтээр ажилласан. 2021 онд төсөвд тусгагдсан бараа материалын дотор ч хэрэгцээгүй бараа материал их байсан тул гэрээг дахин авч үзэж 1.4 тэрбум үргүй зардлыг хэмнэж чадсан. Гэвч SPD алба нь захиалгаар орж ирж байгаа эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээтэй эсэх талаарх дүгнэлт гаргах боломжгүй тул цаашид ч тасаг, нэгжүүдийн захиалгын агуулга болон бодит хэрэгцээний зөрүүг арилгах арга хэмжээ (Эмнэлгийн хэрэгслийн хорооны¹⁰ үйл ажиллагаа гэх мэт) авах шаардлагатай.

Мөн, төслийн төгсгөл үед SPD алба нь цаашид 1/ Корона цар тахлын зогсонги үе шиг онцгой нөхцөл байдалд хангамж, нийлүүлэлт хийх арга хэлбэр, 2/ Яаралтай хагалгаанд шаардлагатай бараа материалыг түргэн шуурхай худалдан авах шаардлагатай үед зохицуулах дүрэм, журамгүй байгаа гэсэн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байгаа нь тодорхой болсон. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Токүшимагийн ИС-ийн жишээг хуваалцахын зэрэгцээ хангамж, нийлүүлэлт хариуцсан ажилтан онлайнаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.

(3) Үр дүн 2-той холбоотой үйл ажиллагаа

- 1) (Үйл ажиллагаа 2-1-1) Өвчтөний менежмент /багаар үзүүлэх тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний стандарчлал, аюулгүй байдал г.м/-ийн сэдвээр японд сургалт зохион байгуулж, сургалтын дагуу хянаж, холбогдох эмнэлгийн ажилтнууд, эмнэлзүйн бус албаны ажилтнууд, дэмжлэгийн албаны ажилтнуудыг хамруулан эмнэлгийн дотоодод сургалтыг тасралтгүй хэрэгжүүлэх замаар өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг төлөвлөхөд дэмжлэг үзүүлнээр дүнд холбогдох ажил, мэргэжлийн хүмүүсийг хамруулах

Багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний стандартчлал, аюулгүй байдал зэрэг өвчтний менежменттэй холбоотой эмнэлгийн үйл ажиллагааны тухайд төслийн нэг дэх үед хэрэгжүүсэн 9 дэх удаагийн японд зохион байгуулсан сургалт болон монгол дах сургалтаар тасралтгүй заавар зөвлөгөө өгч ирсэн. Эдгээр нь өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний гол цөмийг бий болгоход чиглэсэн байв. Коронагийн цар тахлын өмнө, энэ хүртэл шилжүүлсэн технологийн хүрээнд ялангуяа ЯМЭ-ийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ба үйл ажиллагааг эхлүүлсний дараах эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой технологийн дэмжлэгийг хамтатган бодит эмнэлгийн талбар дээр симуляци голлосон заавар зөвлөгөө өгч ажиллаж ирсэн (симуляци хийх замаар өгч байсан зөвлөгөөний дэлгэрэнгүйг “Үйл ажиллагаа 2-1-3”-аас харна уу)

Багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний тухайд, талбар дээрх симуляци

¹⁰ Японд бол оны эхэнд алба, тасаг, нэгжийн бүрэлдэхүүнтэй байгуулсан ижил төрлийн хороо хангамж, нийлүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж, уг төлөвлөгөөний дагуу нийлүүлэлт хийгддэг.

хэлбэрийн заавар зөвлөгөөний зэрэгцээ хагалгааны тасаг, хэвтэн эмчлүүлэх тасгийн үйл ажиллагааг эхлүүлэхэд чиглэсэн сургалтыг (10 дах удаагийн, 11 дэх удаагийн сургалт) японд зохион байгуулсан. 10 дах удаагийн сургалтын ерөнхий танилцуулгыг Хүснэгт 14-д дурдав. Сургалтад хагалгааны албаны эмч, сувилагчаас гадна мэдээгүйжүүлгийн тасаг, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, халдварын сэргийлэлт, хяналтын албанаас оролцож, хагалгааны тасгийг менежмент, зохион байгуулалтын талаар багаар суралцах боломжийг бүрдүүлсэн. 11 дэх удаагийн сургалт нь Хүснэгт 20-д дурдсанчлан эрчимт эмчилгээний тасгийн менежмент, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд чиглэв.

**Хүснэгт 14 Япон дах 10 дах удаагийн сургалтын ерөнхий танилцуулга
(хагалгааны тасаг)**

Нэр	Багийн ЭМТҮ (Хагалгаа)
Хугацаа	2019 оны 11-р сарын 18-ны өдөр (Даваа)-2019 оны 11-р сарын 22-ны өдөр (Баасан) (5 өдөр)
Суралцагч	Ганболд Цолмонуяа (СА-ны дэд дарга) Тайван Энхзаяа (Мэдээгүйжүүлэг Сувилагч) Чойжилжав Нямлхагва (Хагалгаа Сувилагч) Дашдорж Мөнхбаяр (Хагалгаа Ахлах сувилагч) Санжаа Бурмаа (МХНТ-ын эрхлэгч Эмч) Баянхүү Дөлгөөн (Мэдээгүйжүүлэг Эмч) Мягмар Бумцэнд (ЭТТА Био Медикал Инженер) Чулуунбаатар Базардарь (ХСХА Халдвар судлаач)
Зорилт	Хагалгаатай зэрэгцэн хэвтэн эмчлүүлэгчийг хүлээн авах ХЭТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд чиглэн хагалгааны зохистой менежмент, хяналтыг ойлгох, багаар хамтран үйл ажиллагааг бүрдүүлэх
Агуулга	<p>① Хагалгааны багийн зохион байгуулалт, олон мэргэжлийн уялдаа холбоо</p> <ul style="list-style-type: none"> - ЯМЭ-ийн хагалгааны симуляцийг нягтлах - Хагалгааны зохистой менежмент (СА-ны дэд дарга, ахлах сувилагчийн үүрэг, ажил) - Хагалгааг ажиглах <p>② Хагалгааны өмнөх бэлтгэл</p> <ul style="list-style-type: none"> - ХЭТ-асс хагалгаа луу тээвэрлэх урсгал - Өвчтөнд мэдээлэл, тайлбар өгөх, таниулсан зөвшөөрөл авах, бусад зөвшөөрлийн хуудас тайлбарлах - Хагалгаа ажиглах <p>③ Хагалгааны дараах багажийн угаалга, ариутгалын үйл явц</p> <ul style="list-style-type: none"> - Ариутгалын үйл явцыг ажиглах, ариун материалын чанарыг хянах систем, ариун багаж, хэрэгслийг хадгалах, хянах - Төрөл бүрийн хог хаягдал (энгийн, үйлдвэрлэл, халдвартай)-ын ангилал, устгалын урсгал - Цэвэр бүсийн хяналт <p>④ ХЭТ дахь сувилахуй (Холголт, цооролтын эсрэг арга хэмжээ)</p> <p>⑤ Цусны хийн анализаторын хяналт, асуудалд суурилсан арга хэмжээ(МЕ)</p>

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

Эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлын хүрээнд, амбулаторийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан 2019 оны 5-р сард шинэ ажилтнуудад зориулан эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан (хуучин ажилтнуудад төслийн нэг дэх үед хийсэн) Сургалтын танилцуулгыг Хүснэгт 15-д дурдав. Монголд эмнэлгийн дотоод халдвараас шалтгаалах осолтой тохиолдлын талаар ил гаргах нь эмнэлгийн итгэл найдвартай байдал, үнэлгээг бууруулна гэж үздэг тул урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээ, осолтой тохиолдол гарсны дараах илтгэн мэдээлэх зэргийг өнөөгийн байдлаар зохистой хэрэгжүүлдэггүй тул эмнэлгийн дотоодод урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлж, осолтой тохиолдол гарсан үеийн удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах тал дээр ажилласан. Үүний дүнд, ЯМЭ-ийн Халдварын сэргийлэлт, хяналтын алба нь эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээтэй холбоотой сургалтыг төлөвлөж, хэрэгжүүлж байна. Мөн, урьдчилан сэргийлэх үүднээс халдварын хяналтын баг (халдварын сэргийлэлт, хяналтын албанаас гадна сувилахуйн алба, захиргааны алба, SPD албаны төлөөллөөс бүрддэг) 7 хоногт 1 удаа эмнэлгээр тойролт хийж заавар, зөвлөгөө өгч ажиллах удирдлага, зохион байгуулалт бүрдсэн.

Хүснэгт 15 Эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээний талаарх сургалтын ерөнхий танилцуулга

Хэзээ	2019 он 5-р сарын 27-ны өдөр(Даваа)14:00-16:00
Оролцогчид	ЯМЭ-ийн шинэ ажилтан (удирдлага, эмч, сувилагч, техникч, эм зүйч гм)
Агуулга	<ul style="list-style-type: none"> - Халдвараас сэргийлэх, хянах албаны үүрэг, эмнэлгийн менежмент үйл ажиллагаанд үзүүлэх ач холбогдол - Амьсгалын замын халдварт өвчин гарсан тохиолдолд авах арга хэмжээ - Халдварын хяналтын магадлан итгэмжлэгдсэн сувилагч Халдварын сэргийлэлтийн албаны эм зүйчийн үүрэг

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

Улмаар, төслийн зүгээс японы эмнэлгүүдэд ашигладаг эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангах арга хэрэгсэл болох “хияари хатто” буюу болзошгүй тохиолдлоос сэргийлэх анзаарга мэдээлэх формат (Хавсралт 1-7)-ыг танилцуулж, нэвтрүүлэв. Энэ нь эмнэлгийн тусламж үйлчилгээний осол болоогүй хэдий ч осол болж болох магадлалтай болзошгүй тохиолдлыг эмч, сувилагчаар зогсохгүй холбогдох захиргааны алба, арын дэмжлэгийн албаныхан хэлэлцэж ярилцаад нэгтгэн, цаашид урьдчила сэргийлэх, арга хэмжээ авахын тулд ашигладаг формат юм. Энэхүү форматыг хийхэд тухайн шууд хариуцах ажилтнаар зогсохгүй хамаатай бүх алба, тасаг, нэгжийн ажилтнууд бүгд оролцдог тул формат бөглөх, бичих болон арга хэмжээний талаар хэлэлцэж ярилцах зэргээр багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний ухамсар, ойлголт бүрэлддэг давуу талтай юм.

Монголд эмнэлгийн тусламж үйлчилгээний осол, болзошгүй тохиолдлын талаарх мэдээлэх нь хувь хүн рүү чиглэсэн хяналт шалгалт, шийтгэж хариуцлага тооцох шалтгаан болох хандлага хүчтэй байдаг, мөн, эмнэлгийн хувьд сөрөг үнэлгээтэй холбогддог гэж үзэх үзэл нийтлэг байдаг тул дарж мэдээлэх хандлагатай бөгөөд зарим тохиолдолд мэдээлэхгүй

өнгөрөх нь ч бий. Иймд, болзошгүй тохиолдол мэдээлэх формат нь хувь хүнийг шийтгэхийн тулд бус осол гарахаас урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр болохуйц арга хэрэгсэл гэдэг талаас нь олон дахин давтан заавар зөвлөгөө өгч ажилласан. Үүний дүнд, зохистойгоор мэдээлдэг болж, төлөвшиж эхэлж байна. Цаашид, алба, тасаг, нэгж тус бүрийн мэдээлэх түвшинг жигдрүүлж, чанарыг дээшлүүлж, хуримтлагдсан мэдээлэл, тоо баримтыг ангилж ялгадаг болох нь зүйтэй.

2) (Үйл ажиллагаа 2-1-2)

(өөрчлөхийн өмнө) Японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагад суурилан багаар үзүүлэх тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх удирдамж, нэвтрүүлэх төлөвлөгөө, эмнэлгийн ажилтан, ажиллагсдын ур чадварыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулах

(өөрчилсний дараа) Японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагад суурилан багаар үзүүлэх тусламж үйлчилгээний бодит практик арга хэрэгсэл болон харилцааны системийг бүрдүүлж, эмнэлгийн ажилтан, ажиллагсдын чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулах

Нэг дэх үед зохион байгуулсан 5 дах удаагийн (эмнэлгийн мэдээллийн систем) сургалтын эмнэлгийн ажилтнуудын баг, мөн 6 дах удаагийн (эмнэлгийн менежмент) сургалтын эмнэлзүйн инженерингийн багт японы эмнэлгийн баг гэж юу болох тухай бодитоор үзэх боломжийг бүрдүүлсэн. MRI, CT-р дүрс авах, судас тодотгогч бодис тарих тасалгаанд хийгддэг катетер тавих ажилбар, хагалгааны өрөөнд хийгддэг хагалгаа гэх мэтчилэн эмч, сувилагч, техникч нар нэгэн баг болон нэгдэж өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлж буйг бодитоор харж, туршлага судлан багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг ойлгуулж, мэдрүүлэх зорилготой сургалт байсан юм.

Нөгөө талаар, японд багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ гарын авлага, удирдамжийг тэр бүр боловсруулж бэлддэггүй. Багаар үзүүлэх тусламж үйлчилгээ гэдэг бол зөвхөн нэг өвчтөнд зориулж хэлэлцэж ярилцаад тусламж үйлчилгээ үзүүлэхийг хэлдэг бус багийн гишүүд хоорондоо “яг одоо юу хийж байна вэ” гэдгийг харилцан ойлгохоос эхлэх бөгөөд хэзээд харилцан ойлголцоход бэлэн байдал, хандлага, ойлголт ухамсрыг бүрдүүлэх орчныг бий болгох нь багаар үзүүлэх тусламж үйлчилгээг бүрдүүлэхэд хамгийн чухал юм. Иймд, төслийн баг холбогдох удирдамжийг боловсруулахад оролцож, эмнэлгийн дотоодын сургалтын систем, өөрөөр хэлбэл хэзээд харилцан ойлголцоход бэлэн хандлага, ойлголт ухамсрыг бий болгох орчныг бүрдүүлэхийг зорин, эхний алхам болгож японд зохион байгуулсан сургалтын үеэр японы багаар үзүүлдэг тусламж үйлчилгээний талаарх ойлголтыг монгол талд өгөхөд анхаарсан.

Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлснээр 2021 оны 10-р сарын 1-нд зохион байгуулагдсан 5 дах удаагийн Хамтарсан зохицуулах хорооны хурлаар “Багаар үзүүлэх эмнэлгийн

тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх удирдамж болон нэвтрүүлэх төлөвлөгөө” гэж байсныг “Багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний практик арга хэрэгсэл болон харилцааны системийг бүрдүүлэх” болгож ТТМ-ын агуулгыг өөрчлөн шинэчилсэн. Багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний практик арга хэрэгсэл болон харилцааны системийг бүрдүүлэх тухайд, тодруулбал дээр дурдсан халдварын менежментийн багийг зохион байгуулах, болзошгүй тохиолдлыг мэдээлэх форматыг нэвтрүүлэх, Өвчтөнд дэмжлэг үзүүлэх төв болон хэвтэн эмчлүүлэх тасгийн ашигладаг өвчтний үндсэн мэдээллийн форматыг нэг болгох ¹¹ зэрэгтэй холбоотой технологийн дэмжлэгийг үзүүлсний дүнд ЯМЭ-т багаар үзүүлэх тусламж үйлчилгээний арга хэрэгсэл болон ашиглагдаж, харилцааны системийн удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэх суурь болсон.

3) (2-1-3) Эмнэлгийн дотоодод эмнэлгийн ажилтан болон эмнэлзүйн бус ажилтнууд, дэмжих албаны ажилтнуудад багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх сургалт (эмнэлгийн үйл ажиллагааны симуляци мөн багтана) зохион байгуулах

Дээр дурдсанчлан багаар үзүүлэх тусламж үйлчилгээний талаарх технологийн заавар зөвөлгөөг төслийн нэг дэх үед японд болон монголд зохион байгуулсан сургалтаар өгсөн заавар, зөвлөгөөний дагуу төслийн хоёр дах үед симуляци хэлбэрээр дэмжлэг үзүүлсэн. Амбулаторийн үйлчилгээг эхлүүлэхтэй холбогдуулан симуляцийг системтэйгээр зохион байгуулж, шийдвэрлэвэл зохих

Хүснэгт 16 Симуляцийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: Эмнэл зүй хариуцсан дэд захирал
- Дэд ахлагч: Сургалтын менежер
- Гишүүд:
 - Чанар, АБ хариуцсан дэд захирал
 - SPD алба
 - УАУ хариуцсан алба - Эмнэлгийн мэдээллийн алба
 - Сувилахуйнмэдээ - Эм зүйн алба
 - Өвчтөн дэмжих төв - Бүртгэлийн алба
 - Халдварын сэргийлэлт, хяналтын алба

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

асуудал болон сайжруулах арга замын талаар багаар авч хэлэлцэхийн тулд ажлын хэсэг байгуулах зөвлөгөө өгсөн. Хүснэгт 16-д үзүүлсэнчлэн Эмнэлзүй хариуцсан дэд захирлыг ажлын хэсгийн ахлагч, сургалтын менежерийг дэд ахлагч болгон, холбогдох бүх алба, тасаг, нэгжээс төлөөлөл оролцуулан салбар, чиглэлийг нийтэд нь нэгдсэн байдлаар авч үзэн асуудалд хандахуйц удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлсэн. Ажлын хэсэг байгуулсны дараа нийт эмнэлгийн хэмжээнд симуляцийг төлөвлөж, гүйцэтгэж, гүйцэтгэсний дараах дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудлуудын талаар нийтлэг ойлголттой болох үйл ажиллагааг системтэйгээр хэрэгжүүлж, багаар үзүүлэх тусламж үйлчилгээг хэрэгжүүлэхэд чиглүүлсэн.

Амбулаторийн үйлчилгээг эхлүүлсний дараа корона цар тахлын улмаас хилээр зорчиход

¹¹ Өнөөг хүртэл алба, тасаг тус бүр өөр өөр форматтай байсныг нэгтгэж, 1 өвчтөнд 1 формат ашигладаг болсноор, алба, тасгууд уялдаатай ажиллаж 1 өвчтөнд хэрэглэх форматыг боловсруулснаар баг хамт олны сэтгэлгээ, ухамсар бүрдсэн.

хориг хязгаар тавигдаж, япон мэргэжилтнүүд монголд ажиллахад бэрхшээлтэй болж, багаар үзүүлэх тусламж үйлчилгээний дадлагыг монголд талбар дээр шууд магадлах нөхцөл байдалтай байсан боловч онлайнаар дэмжлэг үзүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэн ажилласан. Тухайлбал, холбогдох алба, тасагтай онлайнаар тогтмол уулзаж, талбар дээрх уялдаа холбоотой үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар магадлахын хамт монгол талаас талбар дээр бодитойгоор тодорхой болсон болон эргээзтэй асуудал зэргийн талаар зөвлөгөө өгч ажилласан. Мөн, эмнэлзүйн үйл ажиллагаа өргөжих үед нөхцөл байдатай онлайнаар виртуал танилцаж, монгол талын симуляци зохион байгуулж буй байдалд мониторинг хийж, заавар зөвлөгөө өгч ажилласан. Үүний үр дүнд, 2021 оны 9-р сард дотрын хэвтэн эмчлүүлэх тасаг, эрчимт эмчилгээний тасаг, 11-р сард мэс заслын хэвтэн эмчлүүлэх тасаг, хагалгааны тасаг, яаралтай тусламжийн тасгийн үйлчилгээг эхлүүлж чадсан.

4) (2-1-4)

(өөрчлөхийн өмнө) АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг дээр хэд хэдэн туршилтийн тасагт удирдамжийн дагуу багаар үзүүлэх тусламж үйлчилгээг туршилтаар нэвтрүүлэх (өөрчилсний дараа) АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг дээр хэд хэдэн туршилтийн тасагт практик арга хэрэгсэл болон харилцааны системийг ашиглан, багаар үзүүлэх тусламж үйлчилгээг туршилтаар нэвтрүүлэх

“Үйл ажиллагаа 2-1-4” бол ЯМЭ-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм. Дээр дурдсан “Үйл ажиллагаа 2-1-2”-тэй адил шалтгаанаар АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэгт багаар үзүүлэх тусламж үйлчилгээг туршилтаар нэвтрүүлэх тухайд “удирдамжийн дагуу” гэсэн арга хэлбэрээр бус багаар үзүүлэх тусламж үйлчилгээний орчныг бүрдүүлэхэд илүү анхаарсан дэмжлэг үзүүлсэн. Иймд, японд зохион байгуулсан сургалт болон АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг дээрх симуляциар дамжуулан технологи шилжүүлсэн. “Үйл ажиллагаа 2-1-4” ч “Үйл ажиллагаа 2-1-2”-ийн мөн нэг адил Хамтарсан зохицуулах хорооны 5 дах удаагийн хурлаар ТТМ-д өөрчлөлтийг тусгасан.

6 дах удаагийн японд зохион байгуулсан сургалтад оролцсон эмч нарын баг (радиологийн тасгийн ажилтнууд) радиологийн дүрс авах сургалтын явцад багаар үзүүлэх тусламж үйлчилгээний чухлыг ойлгож, монголд буцахын өмнө танилцуулсан үйл ажиллагааны төлөвлөгөө /action plan/-нд ч багаар үзүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэхийн тул “Радиологийн тасгийн 7 хоногийн ажлын хуваарь, хувааж хариуцах ажил үүргийн хуваарийг боловсруулсан. Улмаар клиник тохиолдлын зөвлөгөөн, эмнэлзүйн тасаг болон бусад нэгж хоорондын хурал, зөвлөгөөнийг 7 хоног бүр зохион байгуулж ажиллах боломжийг бүрдүүлнэ” гэж төлөвлөж бичсэн байсан. Монгол руу буцсаны дараа АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлгийн радиологийн тасагт багаар үзүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай ажилтнууд хоорондоо мэдээлэл солилцох, харилцан ойлголцох орчныг бүрдүүлэх үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлж энэхүү АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг дээрх туршилтаар

нэвтрүүлсний үр дүнд 2019 оны 10-р сард ЯМЭ-ийн дотрын тасгийн үйлчилгээ эхлэсэн.

5) (2-1-5) Туршилтийн үр дүнд үндэслэн удирдамжийг сайжруулан өөрчилж эмнэлгийн үйл ажиллагааг бүрэн эхлүүлсний дараа багаар үзүүлэх тусламж үйлчилгээг шат дараатайгаар нийт тасгуудад нэвтрүүлэх

Дээр дурдсан “2-1-4”-д байгаачлан, багаар үзүүлэх тусламж үйлчилгээний удирдамжийн оронд эмнэлгийн олон мэргэжлийн ажилтнууд (эмч, сувилагч, биомедикал инженер, эм зүйч гэх мэт) нар өөр өөрсдийн байр суурийг ойлгосны үндсэн дээр нэгэн баг болж өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх соёлыг бий болгож, орчныг бүрдүүлэхэд голлон анхаарч дэмжлэг үзүүлж ирсэн. Үүний дүнд, ЯМЭ-ийн эмнэлзүйн тасгууд, хэвтэн эмчлүүлэх тасгуудын дүрэм, журам, гарын авлагад сагаар үзүүлэх тусламж үйлчилгээний үзэл санаа тусгагдаж, тодорхой үйл ажиллагаа (өглөө ээлж хүлээлцэх, олон мэргэжлийнхний хамтарсан хурал, зөвлөгөөн гэх мэт) болон хэрэгжиж байна.

6) (Үйл ажиллагаа 2-2-3) Туршилтийн үр дүнд үндэслэн клиникал патвэй ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээний стандарчлалыг эмнэлгийн үйл ажиллагааг бүрэн эхлүүлсний дараа шат дараатайгаар нийт тасгуудад нэвтрүүлэх

Клиникал патвэй-н тухайд төслийн нэг дэх үед японд зохион байгуулсан сургалт (1 дэх, 2 дах, 3 дах) болон монголд зохион байгуулсан сургалтаар нэвтрүүлэх зорилго, үр ашиг, патвэй-н төрлүүд, ашиглах урсгал, хөгжүүлэх үйл ажиллагаа зэргийн тухайд зааж, зөвлөн японы их сургуулийн эмнэлгийн клиникал патвэй-г жишээ материал болгон хуваалцсан билээ. Үүний дүнд, монгол талаас клиникал патвэй нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, дараахан нь сувилахуйн албаны санаачилгаар монголд элбэг тохиолддог диабет, зүрхний өвчний тохиолдол дээр 2 клиникал патвэй хийсэн. Гэвч, боловсруулсан клиникал патвэй нь эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарчлах үүднээс хангалттай бус байсан. Клиникал патвэй нь эмнэл зүйн удирдамж биш бөгөөд үзүүлж, оношлуулсан өвчтнийг эмчлэх зорилготой төлөвлөгөө бөгөөд эмчилгээ дуусч, эдгэрэх хүртэлх урсгалыг үзүүлсэн төлөвлөгөө юм. Үүний тулд, эмч, сувилагч, эмнэлзүйн бус ажилтнууд хамтран өвчтөнд үйлчлэх шаардлагатай. Мөн, клиникал патвэй-н хамгийн эцсийн зорилго бол “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах” бөгөөд санхүү, эдийн засгийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг сайжруулж өвчтний сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлөхийн төлөөх арга зам юм.

Энэ үүднээс, онлаинаар лекц уншиж, талбар дээр заавар, зөвлөгөө өгөх хэлбэрээр ажилласан. 2022 оны 5-р сарын 17-нд дэд захирлууд (эмнэлзүй, захиргаа, чанар хариуцсан), сувилахуйн албаны дарга, мэс заслын хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч, эмч, халагааны тасаг, эм зүйн алба, өвчтөн дэмжих төвийн төлөөлөл зэрэг холбогдох хүмүүсийг хамруулан клиникал патвэй боловсруулах талаар лекц зохион байгуулав. Тухайлбал, 1/ Клиникал патвэй-н зорилго, 2/ Клиникал патвэй-н хороо байгуулах ажлын хэсгийн үүрэг, 3/ Статистик

үүднээс хамруулах өвчний жагсаалт гаргах, өвчнийг сонгох арга, 4/ Клиникал патвэи-н форматын тайлбар, танилцуулга, боловсруулах дэс дараалал (эмчид, сувилагчид, өвчтөнд тус бүр зориулсан), 5/ Боловсруулах үед анхаарах зүйл (клиникал патвэи нь бүх өвчний хувьд нийтлэг үйлчлэхгүй тул ашиглах стандарт, ашиглахгүй байх нөхцөлтэй уялдуулан авч үзэх шаардлагатай, бусад тасгийн санал бодлыг сонсох шаардлагатай) зэргийн талаар тайлбарлан таниулсан.

Ингэснээр ЯМЭ нь Эмнэлзүй хариуцсан дэд захирлаар ахлуулсан клиникал патвэи боловсруулах хороо байгуулж, хорооны дор эмэгтэйчүүд, чих, хамар, хоолой, нэгдсэн хагалгааны 3 ажлын хэсэг байгуулагдсан. Нэгдсэн хагалгааны ажлын хэсэг хэвлийн дуран ашиглан цесний уут авах хагалгааны клиникал патвэи-г боловсруулсан боловч эмч, сувилагч, өвчтөнд нийтэд нь зориулсан ганц л клиникал патвэи боловсруулсан байсан тул тус бүрээр салгаж боловсруулах, засах ажлыг хийж, 8-р сарын 4-нд төслийн багт ирүүлж, 9-р сараас загвар клиникал патвэи-г ашиглаж эхлэсэн.

Нөгөөтэйгүүр, нэг асуудал байгаа нь, монголд өнөөг хүртэл клиникал патвэи-г ашиглаж байгаагүй тул японы 20 жилийн өмнөх (клиникал патвэи-г нэвтрүүлж эхэлсэн үе)-тэй адилаар эмч нарын эсэргүүцэл хүчтэй байх магадлалтай. Эмч нар өөрийн эмчилгээний арга барилыг шалгарсан, стандарчлал хэрэггүй гэж үздэг. Энэ тухайд, японд ч мөн адил шалтгаанаар төлөвшиж жигдэртэл цаг хугацаа орсон бөгөөд ашиглангаа, цаг зарж ойлгуулахад анхаарах шаардлагатай тухай зөвлөсөн. Мөн, холбогдох талуудыг оролцуулан ворк шоп зохион байгуулсан.

7) (Үйл ажиллагаа 2-3-3) Эмнэлгийн үйл ажиллагааг бүрэн эхлүүлсний дараа эмнэлгийн тусламж үйлчилгээний ослоос урьдчилан сэргийлэх хороо нь тогтмол мониторинг хийх

Эмнэлгийн тусламж үйлчилгээний ослоос сэргийлэх тухайд, төслийн нэг дэх үед японд зохион байгуулсан сургалт (1 дэх, 2 дах, 7 дох, 8 дах) болон монголд зохион байгуулсан сургалтаар технологи шилжүүлсэн. Тухайлбал, эмнэлгийн тусламж үйлчилгээний ослоос сэргийлэхэд шаардлагатай эрсдлийн менежментийн алба, чанарын менежментийн алба, халдварын сэргийлэлт, хяналтын албаны үйл ажиллагааны дүрэм, журам зэргийг боловсруулахад дэмжлэг үзүүлснээс гадна аюулгүй байдлын менежмент, эрсдлийн менежмент, халдварын менежмент, гамшгийн үеийн менежмент зэргийн талаарх сургалт зохион байгуулсан. Мөн, төслийн мэргэжилтнүүд монголд ажиллах үеэрээ монгол дах сургалт гэсэн хэлбэрээр япон дах сургалтын үр дүнд мониторинг хийж ажилласан.

Үүний дүнд, ЯМЭ-т эрсдлийн менежментийн хороо байгуулагдаж, эмнэлгийн дотоодод гарсан тохиолдол зэрэг эрсдлийг үнэлэх, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар авч хэлэлцдэг босон. Мөн, эмнэлгийн эрсдлийн менежментийн ач холбогдлын талаар ойлгож ухамсарлан, монголд анх удаа чанар, аюулгүй байдал хариуцсан дэд захирал

томилогдон ажиллаж байна. 2019 оны 9-р сар, 10-р сар, 11-р сард их хэмжээний ус алдсан осол гарахад эрсдлийн хороо голлон үүрэгтэйгээр байгууламжийн менежментийн албатай хамтран ажиллаж, ослын нөхцөл байдлыг магадлан, эрсдлийн дүн шинжилгээ хийж, ослын тайлан бичсэн. Дараа нь ч ижил төрлийн осол гарч байсан боловч 2020 оны өвлөөс хойш ижил төрлийн осол гараагүй.

Мөн, өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээний үед гардаг осол, тохиолдлын тухайд “Үйл ажиллагаа 2-1-1”-д дурдсанчлан эмнэлгийн итгэл найдвартай байдал, үнэлгээнд сөргөөр нөлөөлж, бууруулж байдаг тул тохиолдлыг ил тод болгохгүй байх хандлага ажиглагддаг, мөн, тохиолдлыг хянаж шалгах үйл явц нь хуучин социалист нийгмийн үеийн нөлөөгөөр буруутныг хайх өнгө аяс хүчтэй байдгийг харгалзан ижил төрлийн тохиолдлоос урьдчилан сэргийлэхийн тулд тохиолдлыг шалгахын ач холбогдол болон эрсдлийн менежментийн хорооны ач холбогдлыг ойлгуулж ухамсарлуулах зорилгоор болзошгүй тохиолдол, тохиолдол мэдээлэх форматыг танилцуулж, нэвтрүүлэх тал дээр төслийн баг ажилласан. Заавар зөвлөгөөг олон удаа давтан өгснөөр төлөвшиж эхэлж байна. Цаашид, алба, тасгуудын мэдээлэх түвшинг нэгтгэж, чанарыг сайжруулж, хуримтлагдсан мэдээлэл, тоо баримт, арга хэмжээг ангилж ялгах шаардлагатай.

8) (Үйл ажиллагаа 2-4-4) Хороод голлох үүрэг гүйцэтгэж удирдамж, дүрэм журам зэргийн биелэлтэд тогтмол мониторинг хийх. Мөн, коронагийн цар тахлын үеийн эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээний тухайд монгол орны нөхцөл байдлыг харгалзан ЯМЭ-ийн дүрэм, журам, удирдамж зэргийг боловсруулах, эмнэлгийн дотоодод сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. Улмаар, семинар зэрэг арга хэмжээ зохион байгуулах замаар цар тахлын үеийн ЯМЭ-ийн эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээний талаарх мэдлэг, туршлагыг монголын эрүүл мэндийн ажилтнуудад түгээн мэдээлэх.

2019 оны 10-р сард амбулаторийн тусламж үйлчилгээг эхэлснээс хойш долоо хоног бүр халдварын сэргийлэлт, хяналтын багийн ICT(Infection Control Team) тойролтыг зохион байгуулж байна. Халдварын сэргийлэлт, хяналтын удирдамжийн дагуу тойролтыг зохион байгуулж, үзлэгийн өрөө, шинжилгээний өрөөний халдвар сэргийлэлтийн арга хэмжээний нөхцөл байдал, эмч сувилагчийн гарын халдваргүйжүүлэлт, эмнэлгийн хог хаягдал зэргийг шалгаж, хангалтгүй болон буруу тохиолдолд ХСХ-ын багийн зүгээс заавар, зөвлөгөө өгч байна. Тойролтын талаар эмнэлгийн хурал болон тайлангаар дамжуулан мэдээлэл солилцож байгаа хэдий ч эмнэлгийн мэргэжилтний ХСХ-ын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, нутагшуулах, ухамсар зэргийг дээшлүүлэхийн тулд ХСХА-ны зүгээс эмнэлгийн дотоод сургалтыг зохион байгуулж байна. Төслийн үйл ажиллагааны хүрээнд ХСХ хариуцсан зөвлөх багш, ЯМЭ-ийн ХСХА, ХСХ-ын багтай тогтмол мэргэжлийн хурлын зохион байгуулж, сургалт болон ICT тойролтын хэрэгжилтийг магадлах, ХСХ-т тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл солилцож, заавар зөвлөмжийг өгч байна.

Хагалгааны хувьд халдвараас сэргийлэхийн тулд ариутгалын албаны зохистой ариутгал, үйл ажиллагаа шаардлагатай. Шинэ төрлийн коронавирусийн цар тахлын улмаас хилээр зорчих хөдөлгөөн хязгаарлагдаж цахимаар хурлыг зохион байгуулж, ариутгалын бэлтгэл, урсгал зэргийн талаар цахим систем ашигласан мониторинг болон бичлэгээр шалгаж, ариутгалын үйл ажиллагаанд заавар зөвлөмжийг өгсөн. Жишээлбэл 2020 оны 10-р сард зохион байгуулсан цахим ажиглалтаар цэвэр, бохир бүсийн хязгаар тодорхойгүй, хагалгааны багажийг тээвэрлэх аргад хамаарах эрсдэл зэргийг магадалж, шаардлагатай заавар зөвлөмжийг өгсөн. Цаашид хагалгааны үйл ажиллагааг өргөжүүлэхэд илүү тохиромжтой ариутгал, ХСХ-д чиглэсэн тасаг нэгжийн уялдаа холбоог бэхжүүлэх тодорхой заавар зөвлөмжийг өгсөн. Хилээр зорчих хөдөлгөөн дахин сэргэсний дараа газар дээрх шууд мониторинг, заавар, чиглэлийн өгч, үүний үр дүнд одоо зохистой ариутгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэн байна.

Шинэ төрлийн коронавирусийн хувьд ЯМЭ нь Шинэ төрлийн коронавирусийн халдвартай өвчтөн хүлээн авах чиглэл авсан. Тиймээс ХСХ-ын үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд цахимаар ХСХА-тай хуралдаж, Монгол Улс дахь Шинэ төрлийн коронавирусийн халдвар авсан өвчтөний нөхцөл байдал болон ЯМЭ-ийн хэрэгжүүлж буй арга хэмжээг магадалж, заавар зөвлөмжийг өгсөн. 2020 оны 11-р сард ЯМЭ-ийн 40 гаруй ажилтан(тасгийн эрхлэгч, албаны дарга, ахлах сувилагч, ХСХ менежер)-нд Шинэ төрлийн коронавирусийн ХСХ-ийн талаарх семинарыг зохион байгуулсан. Япон Улсын туршлагад үндэслэн Шинэ төрлийн коронавирусийн онцлог, ЭМБ-т авч хэрэгжүүлэх арга хэмжээний арга барилын талаар заавар өгсөн. Үүний үр дүнд ХСХА нь цар тахлын үед хэрэгжүүлэх ХСХ-ын мануалыг боловсруулсан.

Түүнчлэн 2022 оны 6-р сарын 28-ны өдөр ЯМЭ-ийн ХСХА, АШУҮИС болон ХӨСҮТ хамтран “Эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналт-олон улсын жишиг тогтолцоо” сургалтыг АУС-ийн хурлын танхимд зохион байгуулсан. Уг сургалтын зорилго нь олон улсын ХСХ-ын жишиг тогтолцоог Монгол Улсын эмнэлгийн мэргэжилтэнд танин мэдүүлэх, түгээн дэлгэрүүлэх бөгөөд УБ хотын ЭМБ, орон нутгийн ЭМБ(цахимаар)-ийн төлөөлөл, ЯМЭ-ийн хариуцсан ажилтан оролцсон. Өнөөг хүртэлх хугацаанд төслийн багийн зүгээс өгсөн заавар, зөвлөмжийн агуулгын талаар Монгол талаас илтгэл тавьсан. Мөн төслийн багийн зүгээс цаашид ХСХ-д чухал болох “ХСХ: Хууль эрх зүйн асуудал”, “Антибиотикийн зохистой хэрэглээ, эмэнд тэсвэртэй бичил биетний халдвар”-ын талаарх илтгэлийг тавьсан. Илтгэлийн дараа нийт оролцогч нартай ЯМЭ-ийн ICT тойролтыг зохион байгуулсан. ЯМЭ-т бий болгосон ХСХ-ын тогтолцоог Монгол Улсын жишиг тогтолцоо болгох, түгээн дэлгэрүүлэх нь ИСЭ-ийн цаашдын үүрэг юм.

(4) Үр дүн 3-ийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

- 1) (Үйл ажиллагаа 3-2) Дээрх сургалтын төлөвлөгөөний дагуу холбогдох эмнэлгийн ажилтан, ажиллагсдыг японд зохион байгуулах сургалтад хамруулж сургалтын мөрөөр магадлах. СТ болон MRI-г ажиллуулахад шаардлагатай аппликэшн сургалтыг монголын туслан гүйцэтгэгчид захиалж хэрэгжүүлсэн. Корона цар тахлын үеийн арга хэмжээний тухайд, шинжилгээний болон тоног төхөөрөмжийн алба зэрэг холбогдох бүх ажилтнуудад оношлох, эмчлэх сургалтыг зохион байгуулсан

Эмнэлгийн дэвшилтэт тусламж үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд радиологийн тасагт СТ, MRI-ийн нэмэлт ашиглалтын сургалтыг Монгол Улсад зохион байгуулсан. Ашиглалтын сургалтын хувьд ханган нийлүүлтийн үед үйлдвэрлэгчийн зүгээс зохион байгуулах ерөнхий сургалт(ажиллуулах үндсэн зарчим, ерөнхий хэсгийн зургийг авах)-аар техникч хангалттай техникийг эзэмшиж чадаагүй байсан. Нэмэлт сургалтаар төслийн манай байгууллага зардлыг хариуцаж мэргэжилтэн томилж, хэрэгцээнд нийцсэн зөвлөмж, зааврыг өгөх зохион байгуулалтыг хийсэн. Сургалтын агуулгыг хүснэгт 17, 18-д харуулсан.

Хүснэгт 17 СТ-н нэмэлт аппликэшн сургалт (монгол туслан гүйцэтгэгчээр хийлгүүлсэн)-ын ерөнхий танилцуулга

Хугацаа	2019 оны 9-р сарын 30-ны өдөр (Даваа)-2019 оны 10-р сарын 4-ний өдөр (Баасан) (5 өдөр)
Багш	Пелесикоти Колопауа (CANON)
Суралцагч	Д.Норовбанзад (Дүрс оношилгооны эмч) Ө.Анхболд (Дүрс оношилгооны техникч) Б.Мөнгөн (Дүрс оношилгооны техникч) Б.Тэмүүжин (Дүрс оношилгооны техникч) Г.Бямба-Далай (Дүрс оношилгооны техникч)
Агуулга	1 дэх өдөр: Илрүүлэгчийг хэрхэн ашиглах, хоолойн эргэлтийн хугацаа, протоколын өөрчлөлт гм 2 дахь өдөр: Хэвлийн СТ (энгийн+артер+үүдэн вен+тэнцвэр)-ийн 4 харагдац-зураг авах, тарих хэрэгслийг ашиглах гм 3 дахь өдөр: Уушгины эзлэхүүний шинжилгээ, ангиографи, өөх тосыг хэмжих, тодосгогч бодис 4 дэх өдөр: Дадлага, Асуулт, хариулт 5 дахь өдөр: Дадлага, Асуулт, хариулт

Боловсруулсан: Төслийн баг

Хүснэгт 18 MRI-н нэмэлт аппликэшн сургалт (монгол туслан гүйцэтгэгчээр хийлгүүлсэн)-ын ерөнхий танилцуулга

Хугацаа	2019 оны 10-р сарын 28-ны өдөр (Даваа)-2019 оны 11-р сарын 1-ний өдөр (Баасан) (5 өдөр)	
Багш	Mr. Garrett Hablitz (CANON)	
Суралцагч	Д.Мөнхбаатар (Дүрс оношилгооны эмч) Д.Түвшинжаргал (Дүрс оношилгооны эмч) Х.Дэлгэр-Далай (Дүрс оношилгооны	П.Хишигээ (Дүрс оношилгооны техникч) Б.Мөнгөн (Дүрс оношилгооны техникч) Б.Тэмүүжин (Дүрс оношилгооны

	эмч) Т.Эрдэнэбал (Дүрс оношилгооны эмч)	техникч) Г.Бямба-Далай (Дүрс оношилгооны техникч)
Агуулга	1 дэх өдөр: Параметрийн тохиргоо, тодосгогчтой холбоотой тайлбар, өвдөг, нуруу нугасны MRI гм 2 дахь өдөр: Хөхний MR, MRCP, гар MR гм 3 дахь өдөр: Амьсгалах+хэвлий MR, өвдөгний коил+2 гар MR, ЗЦ+хэвлий-доод мөчид MRA гм 4 дэх өдөр: Хөлний үе, хөлийн хэсэг MRI, зүрх MR гм 5 дахь өдөр: Дадлага, Асуулт, хариулт	

Боловсруулсан: Төслийн баг

Ангиографийн аппарат(ангиографи)-ын хувьд 2019 онд гарсан ус алдалтын дараа ажиллагаа сэргэсэн хэдий ч Шинэ төрлийн коронавирүсийн цар тахлын улмаас ашиглалтын сургалтын багш(инженер)-ийг томилоход хүндрэл тулгарсан. 2022 оны 4-р сарын 28-ны өдрөөс нийт 3 баг(тоног төхөөрөмжийн тохируулга, ажиллагаа, ашиглалт, эмнэлзүйд нэвтрүүлэх)-ийн инженер дараалан томилогдож, сургалтыг зохион байгуулсан. 1 дэх багийн томилогдсон багш Шинэ төрлийн коронавирүсийн халдвар авсан хэдий ч 2022 оны 6-р сарын 24-ны өдөр сургалтын дуусгасан. Сургалтыг зөвхөн ЯМЭ-ийн ажилтанд бус УНТЭ, УХТЭ-ийн эмнэлгийн мэргэжилтнийг урьсан. Энэ эмнэлгүүд нь ангиографигаар катетрийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ур чадвар, туршлагатай учраас ЯМЭ бие даан тус тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх хүртэл дэмжлэг авах зорилготой юм(тус бүр ЯМЭ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан).

Хүснэгт 19 Ангиографийн аппликэшн сургалт

(монгол туслан гүйцэтгэгчээр хийлгүүлсэн)-ын ерөнхий танилцуулга

Хугацаа	2022 оны 4-р сарын 28-ны өдөр (Пүрэв)-2022 оны 6-р сарын 24-ны өдөр (Баасан)	
Багш	Тамари Юсүкэ, ЯмамотоТошиюки, Коно Чихиро, Шёожи Юмико(Шимазү)	
Суралцагч	ЯМЭ: Тархины мэс заслын эмч, зүрх судасны эмч, Дүрс оношилгооны эмч техникч	УНТЭ: зүрх судасны эмч, техникч УХТЭ зүрх судасны эмч, техникч
Зорилго	<ul style="list-style-type: none"> Ашиглалтын заавар Эмнэлзүйн тохиолдол бүрд нэвтрүүлэх(зураг шалгах, төрөл бүрийн тохиргоо гм) 	
Агуулга	<ul style="list-style-type: none"> Тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах, төрөл бүрийн анхны тохиргоо Төхөөрөмжийг ажиллуулах журам Эмнэлзүйн тохиолдол бүрд нэвтрүүлэх(зүрх, тархины мэс засал, хэвлий), тохиргоо өөрчлөх 3D зургийн шаардлага, 3D ажлын станцыг ажиллуулах 	

Боловсруулсан: Төслийн баг

“Эмнэлзүйн төв лаборатори”-ийн хувьд Монгол дахь сургалтаар лабораторийн техникч нарт дадлага (сепсис, цочмог миелоид лейкеми, миелофиброз, цочмог лимфоцитын лейкеми гм)-ыг зохион байгуулж, тодорхой түвшний ур чадварыг эзэмшсэн эсэхийг шалгахаас гадна эсүүдийг оптик микроскоп ашиглан хэрхэн ялгах талаар зааварчилгаа өгсөн. Түүнчлэн

буцалтгүй тусламжаар хүлээлгэн өгсөн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний төрөл хязгаарлагдмал учраас бусад эмнэлэгтэй хамтран ажиллах зэрэг ЯМЭ-ийн лабораторийн тогтолцоо, зохион байгуулалтын талаар заавар, зөвлөмж өгсөн.

2020 онд Шинэ төрлийн коронавирусийн цар тахлын улмаас газар дээр шалгах, заавар өгөхөд хүндрэл гарсан хэдий ч 2022 оны 7-р сард Монголд зочлон нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх болон эргэн заавар зөвлөгөө өгсөн. Үр дүн:

“Цус, шээс”

- Цусны сорьц 120-150 хүн/өдөр, шээсний сорьц 60-70 хүн/өдөр, баркод уншигч ашиглах зэрэгт асуудалгүй

“Лабораторийн төхөөрөмж”

- Тохиромжтой хяналтыг хийдэг

“Шинжилгээ тус бүр”

- Зохистой зохион байгуулж байгаа ба асуудалгүй. Гэвч микроскопоор харах чадвартай боловсон хүчин хангалтгүй бөгөөд өнөөгийн хүний нөөцийн хүчин чадал хүрэлцээгүй

“Эрсдэлийн хяналт”

- Яаралтай хэвийн бус утга гарсан тохиолдолд авах арга хэмжээ зохистой

“Сургалтын программ”

- Шинэ ажилтан эхний хагас жил тасаг бүрээр тойрч, сургалт авна

“Дүрс оношилгооны тасаг”-ийн хувьд Япон дахь сургалт, Монгол дахь сургалтаар заавар өгч, тохиромжтой ажиллагаа, удирдлага зэргийг зааж зөвлөсөн. Шинэ төрлийн коронавирусийн халдвар багассан 2022 оны 7-р сарын сард Монголд зочлон дараах зүйлийг шалгаж, заавар зөвлөгөө өгсөн.

“Үйл ажиллагааны нөхцөл байдал”

- Рентген зураг: өдөрт 40-60, СТ: өдөрт 15-25, MRI: өдөрт 8-10, эхо: өдөрт 40, дүгнэлт: өдөрт 110-120 хийж байгаа, одоогийн хүний нөөц дүрс оношилгооны эмч 12, техникч 7 байгаа ба хамгийн дээд хүчин чадлаараа ажиллаж байна гэж үзнэ(24 цагаар хүлээн авч, 3 ээлж).

“Тулгамдаж буй асуудал”

- Шинэ төрлийн коронавирусийн цар тахлын улмаас техникч ирэх боломжгүй эсхүл Хятад улсын хөл хорионы улмаас сэлбэг авахад хүндрэлтэй байгаа учраас нэг хэсгийн эвдрэлээс шалтгаалан ажиллахгүй байгаа тоног төхөөрөмжүүд бий.
- Өнөөгийн хүний нөөцийн хувьд байж болох хамгийн дээд хүчин чадал учраас орон тоог нэмбэл зохистой. Жишээлбэл маммографи нь ашиг өндөр шинжилгээ боловч өдөрт 2 удаа хийдэг.

“Үйл ажиллагаа 1-2-4”-ны дагуу “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерчлэл”-ийн хувьд ч бусад албадтай ижил Япон дахь сургалт, Монгол дахь сургалтаар заавар өгч, зөвлөсөн.

Шинэ төрлийн коронавирусийн цар тахлын улмаас 2022 оны 7-р сард Монголд дахин зочилж ажиглалт, мониторинг, холбогдох ажилтнаас мэдээлэл авснаар хүний нөөц, ур чадварын хувьд тулгамдаж буй асуудлыг илрүүлсэн. Батлагдсан орон тоо 14 хэдий ч 2022 оны 9-р сарын байдлаар 11(3 дутуу) ажилтан байна. Түүнчлэн 11 ажилтны 2 нь өнөөг хүртэлх сургалтад суусан мэргэжилтэн үлдэж, бусад нь ажлаас гарсан байна. Тиймээс Япон менежменттэй ЭТТА-ны бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх, тоног төхөөрөмжийн хяналт, ур чадварыг сайжруулахад чиглэсэн заавар, зөвлөмжийг дахин өгсөн.

Ашиглалтын асуудлын хувьд 1. Буцалтгүй тусламжаар хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн доторх зай(Литиум)-г солих хугацаа(3-4 жил) болсон боловч зардал болон Японоос зайг тээвэрлэх(агаарын тээврийн асуудал, Хятадын хөл хорионы улмаас тухайн улстай хиллэдэг боомтоос импортыг түр зогсоосон) зэрэг асуудлаас шалтгаалан авахад хүндрэлтэй байгаа ба хэрэгжүүлээгүй байна, 2. Шинэ төрлийн коронавирусийн халдвар тархаж байгаатай холбогдуулан Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр эмнэлэгт хүчилтөрөгч үйлдвэрлэх байгууламж суурилуулсан боловч дэлбэрэлтээс хамгаалах хана байхгүй, мөн цахилгаан зэрэг нь дэлбэрэлтээс хамгаалах зохион байгуулалтгүй учраас онцгой байдалд бэлэн байх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээрх асуудлыг ЭТТА болон эмнэлгийн удирдлагад тайлбар, мэдээлэл өгсөн.

Цаашид ЯМЭ-г өндөр түвшний ЭМТҮ-г үзүүлэхэд эмнэлгийн багана болох дүрс оношилгооны техникч, лабораторийн техникч, эмнэлзүйн инженерүүдийн түвшнийг дээшлүүлбэл зохистой. Үүний тулд 2-3 долоон хоногийн Япон дахь сургалт үр дүнтэй гэж үзэж байна. Түүнчлэн ирээдүйд эзэмшсэн мэдлэг, техникийг Монгол Улс даяар түгээн дэлгэрүүлж, ЯМЭ-г төвлөрсөн DRL(Diagnostic Reference Level: Оношилгооны лавлагааны түвшин)-г тусгасан жишиг зураг авах арга, шинжилгээний арга, багаар үзүүлэх ЭМТҮ-ний нэг хэсэг болох эмнэлзүйн инженер зэрэг зохион байгуулалтыг бий болгох нь зүйтэй.

2) (Үйл ажиллагаа 3-3) Технологи түгээх, хуваалцах үйл ажиллагааг үр хүртээмжтэй байлгахын тулд сургалтын тайлан болон хэсэг, нэгж хоорондын хамтарсан сургалт зэргийг зохион байгуулах. Улмаар семинар зэргийг зохион байгуулж ЯМЭ дэх коронагийн халдвартай өвчтөн хүлээж авах удирдлага, зохион байгуулалтын мэдлэг, туршлагыг монголын эрүүл мэндийн ажилтнуудад өргөн хүрээнд түгээн таниулах.

Сургалт зэрэг эзэмшсэн техник ур чадварыг түгээн дэлгэрүүлэхийн тулд Япон дахь сургалтад оролцсон суралцагч нар тайлан боловсруулж, эмнэлэг дотооддоо тайлангийн хурал зохион байгуулж байна. 10 дахь удаагийн сургалт(Багийн ЭМТҮ: Хагалгаа)-аар цусны хий анализаторын хяналтын талаар үйлдвэрлэгч(Siemens Healthcare Diagnostics Ltd.)-ийн сургалтын агуулгыг сургалтад оролцсон Био медикал инженер бичлэг хийж, буцаж ирээд ЯМЭ-ийн хэрэглэгч(эмч, сувилагч, техникч) болон хяналтын ажилтанд лекц зохион байгуулсан. Түүнчлэн СТ, MRI-ийн нэмэлт ашиглалтын сургалтын хувьд ч оролцогчид сургалтад оролцоогүй эмнэлгийн мэргэжилтэнд мэдээллийг хуваалцаж, шинжилгээний ур

чадварыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Дүрс оношилгооны тасгийн сургалтад оролцогчид Радиологийн мэргэжлийн зөвлөл зэргээр дамжуулан Монгол Улс дахь нийт мэргэжилтнүүдэд мэдээлэл хуваалцаж байна. Ижил үйл ажиллагааг ХСХА хэрэгжүүлж байгаа бөгөөд сургалтад оролцогчид ЭМЯ-ны мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүний зүгээс Япон менежментийн ХСХ-ыг түгээн дэлгэрүүлж байна. Түүнчлэн Шинэ төрлийн коронавирусийн ХСХ-ын хувьд “Үйл ажиллагаа 2-4-4”-т заасан ба Монгол талын хариуцагч нар сургалт зэргээр дамжуулсан мэдээллийг хуваалцаж байна.

(5) Үр дүн 4-ийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

- 1) (Үйл ажиллагаа 4-1) Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах ажилтан, ажиллагсдыг хүний нөөцийг зохион байгуулах, санхүүгийн менежмент зэрэг асуудлыг багтаасан яаралтай тусламж үзүүлэх өвчтний менежмент, яаралтай тусламжийн тасгийн менежментийн талаарх сургалтыг японд зохион байгуулах, сургалтын мөрөөр магадлах.

Япон Улсын ЯТ-ийн ЭМТҮ-ний зохион байгуулалт, тогтолцооны талаар эхний жил зохион байгуулсан Япон дахь сургалт (1 дэх: Японы эмнэлгийн системийн танилцуулга, 3 дахь: Сувилахуйн менежмент, 7 дахь: Эмнэлгийн менежмент)-аар холбогдох эмнэлгийн мэргэжилтэн болон захиргаа, бичиг хэргийн ажилтанд мэдлэг, мэдээлэл олгосон. Жишээлбэл эрэмбэлэх, өвчтөний үр ашигтай урсгалыг хангах зэрэг ЯТ-ийн менежмент, ЭЭТ болон ХЭТ-д шилжсэний дараа асаргаа, хүний нөөцийн зохион байгуулалт, санхүүгийн удирдлага зэрэг ЯТТ-ийн үйл ажиллагааны менежмент зэргийн талаар заавар, зөвлөгөө өгсөн.

Нөгөөтээгүүр Япон дахь сургалтад хамрагдсан суралцагч нараас одоо ЯМЭ-ийн ЯТТ-т ажиллаж байгаа хүн байхгүй бөгөөд Япон талаас хуваалцсан мэдээлэл, мэдлэгийг нутагшуулахад асуудал тулгарч байсан. Тиймээс төслийн байгийн зүгээс хагалгаа, ХЭТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд багаар үзүүлэх ЭМТҮ-ний талаар Япон дахь сургалтыг төлөвлөж, хэрэгжүүлсэн. 11 дэх удаагийн сургалт(Багийн ЭМТҮ: ҮДА/ЭЭТ)-нд ЯТТ ахлах сувилагч 1, ҮДА ахлах сувилагч 1 хүн оролцсон. Яаралтай өвчтөнийг ЯТТ-аас ЭЭТ лүү тээвэрлэхэд холбоотой мэдээллийг тасаг хооронд солилцох, сувилахуйн асаргааны талаар лекц зохион байгуулж, газар дээр нь ажиглалт хийснээр дэлгэрэнгүй ойлголт авсан. Сургалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 20 Япон дахь 11 дэх удаагийн сургалтын ерөнхий танилцуулга (ЭЭТ)

Нэр	Багийн ЭМТҮ(ҮДА/ЭЭТ)
Хугацаа	2019 оны 11-р сарын 25-ны өдөр(Даваа)-2019 оны 11-р сарын 29-ны өдөр(Баасан)(5 өдөр)
Суралцагч (ICU)	Сүхбат Соёл-Эрдэнэ(ЯТТ Ахлах сувилагч) Дорлигбаатар Сарантуяа(ЭЭТ Ахлах сувилагч)
Зорилт	ЭЭТ-ийн цогц урсгалын талаар ойлголт авах, зохистой үйл ажиллагаа,

	менежментийг суралцах
Агуулга	<p>① ЭЭТ-ийн цогц урсгал</p> <ul style="list-style-type: none"> - Өвчтөн хүлээж авах, ТҮ-ний урсгал - Эрэмбэлэх, сувилахуй - Тасаг бүрийн ахлах сувилагчтай мэдээлэл солилцох, олон мэргэжлийн уялдаа холбоо - Хүний нөөцийг бэлтгэх тогтолцоо <p>② Ажиглалт (ЭЭТ)</p> <ul style="list-style-type: none"> - Тасаг бүрт орчин бүрдүүлэх (Хүлээлгийн өрөө, ар гэр, сахиурын өрөө гм) - Өвчтөн хүлээж авах бэлтгэл(Эмнэлгийн хэрэгсэл, төхөөрөмж, сувилахуйн хэрэгсэл зэргийг бэлтгэх) - 6S, эрүүл ахуй, ХСХ

Боловсруулсан: Төслийн баг

ЯТ-ийн ЭМТҮ-г 2020 оны 11-р сард ХЭТ2, хагалгаатай хамт эхлүүлсэн. ЯТТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд ХЭТ2, ЭЭТ, хагалгааны үйл ажиллагааг баттай зохион байгуулах шаардлагатай. Тиймээс эмнэлгийн ЭМТҮ-ний тогтолцоонд анхаарсан. Жишээлбэл ЯМЭ-т эдгээрх ТҮ-г эхлүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажил, шаардлагыг жагсааж, 7 хоног бүр зохион байгуулдаг Япон талтай хийх хурлаар явцыг магадалж, ЯТТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлсэн.

2020 оны 11-р сард ХЭТ2, хагалгаа, ЯТТ-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Тогтолцоо бүрэн бий болох хүртэл ЯМЭ байрлах Баянзүрх дүүргийн 5 хорооны яаралтай өвчтөнд мухар олгой, амьсгалын хүндрэл зэрэгт тусламж үйлчилгээг үзүүлсэн. Гэвч Шинэ төрлийн коронавирусийн цар тахлын улмаас ЭМЯ-ны сайдын тушаалын дагуу ЯМЭ нь эерэг өвчтөн хүлээн авч, ЯТТ нь маш хүнд өвчтөний ЭЭТ-ийн үүргийг гүйцэтгэсэн. 2022 оны 3-р сард Шинэ төрлийн коронавирусийн халдвартай өвчтөн хүлээн авч дуусан, хэвийн үйл ажиллагаанд шилжин ажиллаж байна.

2022 оны 7-р сарын байдлаар ЯТТ-ийн ор 14, эмч 6(орон тоо 7), сувилагч 15(орон тоо 18) байна. 4 ээлжээр(24:72) ажиллаж байна. 2022 оны 4-р сараас харьяа хорооны хязгааргүй болж хороо хамаарахгүй өвчтөн хүлээн авах боломжтой болсон хэдий ч эмнэлгийн орны тоо цөөн, мэргэжлийн эмч, сувилагч хангалтгүй тул одоогийн байдлаар тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. Одоогийн байдлаар гэмтэл, хүүхэд, дотор, мэдрэлийн өвчтөн их байна. Өдөрт 15 өвчтөн хүлээн авч байна.

ЯТ-ийн үйл ажиллагаа дахин эхэлснээр ЯТТ-тай олон удаагийн хурлыг зохион байгуулж цаашид ТҮ-г өргөжүүлэхэд шаардлагатай зүйлсийг магадалсан. Үүний үр дүнд хүүхдийн ЯТ, хордлого, гэмтэл, ЯТ эхо гэсэн 4 ерөнхий сэдвийн хүрээн цахим семинарыг эхлүүлсэн. Цахим семинарын 1 сэдвийг 1 цагт багтаан 6 удаа семинарыг зохион байгуулсан (Агуулга: 4 бүлэг, 15 сэдэв). Цахим семинарыг 2022 оны 9-р сард зохион байгуулсан. ТИС-ийн тасаг тус бүрийн нарийн мэргэшлийн эмч-багш нар зааж, ТИС-ийн хичээлд ашигладаг модулыг ЯМЭ-т тохируулан зохион байгуулсан. Семинарын бичлэгийг авч, ЯМЭ-т цаашид төгсөлтийн өмнөх,

дараах сургалтын материал болгосон.

2) (Үйл ажиллагаа 4-3) ЯМЭ-ийн яаралтай тусламж үйлчилгээний хүрээнд бий болсон мэдлэг, туршлагыг АШУҮИС-ийн сургалтад тусгах

Буцалтгүй тусламжаар ЯМЭ-ийн ЯТТ-ийн байгууламж, орчин бүрдсэн. Өнөөг хүртэл Монгол Улсад ЯТ-ийн тогтолцоо бүрэн бүрдээгүй, бусад эмнэлэгт мэс заслын хэсэг ЯТ-ийн тусламж үйлчилгээг үзүүлдэг ба хүлээн авч буй өвчтөний дийлэнх хувь нь хөнгөн(24 цагийн амбулаторийн үүрэг гүйцэтгэдэг) байдаг. Тиймээс ЯТ-ийн загварыг бий болгох талаас өвчтөн хүлээн авахаас эрэмбэлэх, өвчтөний урсгалыг хангах зэрэг яаралтай өвчтөний менежментийн заавар зөвлөгөөг өгсөн.

ЯМЭ, АШУҮИС-ийн АУС(Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхим)-ийн зүгээс ч ЯМЭ-ийн байгууламж, орчин нь өнөөг хүртэл Монгол Улсын эмнэлэгт байгаагүй Япон менежментийн олон улсын жишигт нийцсэн ЯТ-г үзүүлэх, ЯМЭ-т АШУҮИС-ийн эмнэлзүйн дадлагыг хийх боломжтой болсноор олон улсын жишиг бүхий ЯТ-ийн боловсрол, сургалтыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Гэвч өнөөг хүртэл АУС-ын Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхим болон ЯМЭ-ийн ЯТТ нь хоорондоо уялдаа холбоо, хамтын ажиллагаа бага байсан учраас төслийн багийн зүгээс хоёр талын тогтмол, тасралтгүй мэдээлэл солилцох ажлын хэсгийг бүрдүүлэх санал тавьсан. Монгол тал ЯМЭ-ийн ЯТТ-ийн эмнэлгийн мэргэжилтнүүдийг(дарга гм) АУС-ын Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхимийг тусгай профессорын хувьд хүлээн авч, харилцан мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлсэн. Үүний үр дүнд ЯТ-т чиглэсэн үйл ажиллагаа улам бэхжиж, тогтмол мөн тасралтгүй хурлыг зохион байгуулж байна.

Хөтөлбөрийн хувьд “Төгсөлтийн өмнөх 3-р курсийн оюутан”, “Төгсөлтийн өмнөх 4-р курсийн оюутан”, “Төгсөлтийн дараах сургалт” гэсэн 3 төрөл бий боловч олон улсын жишиг бүхий агуулга биш тул 2023 оны 9-р сарын шинэ хичээлийн жилд бэлтгэн шинэчлэх ажил эхэлсэн. Тус хөтөлбөрийг Япон талын зөвлөх багш нарт хуваалцаж, Японы хөтөлбөртэй харьцуулан шаардлагатай хэсгийн талаар зөвлөмж өгч байна(дээрх хүүхдийн ЯТ гм). Түүнчлэн төслийн бус үйл ажиллагаа болох(ИС хоорондын гэрээнд заасан үйл ажиллагааны хүрээнд 2023 оны 4-р сар хүртэл шинэчлэгдэх хөтөлбөрт тухай бүр зөвлөмж өгөхөөр төлөвлөж байна. Мөн ЯМЭ болон АУС-ийн эцсийн зорилго нь “Яаралтай амилуулах тусламж”-ийг үзүүлэх юм.

3) (Үйл ажиллагаа 4-4) Эмч нарын зөвлөгөөн зэргийг зохион байгуулах замаар ЯМЭ-ийн яаралтай тусламж үйлчилгээний хүрээнд бий болсон мэдлэг, туршлагыг монголын эрүүл мэндийн ажилтнуудад өргөн хүрээнд түгээн таниулах

“Үйл ажиллагаа 4-3”-т заасан алсын зайны семинарын үр дүнд бий болсон сургалтын материалыг үр дүнтэй ашиглаж, Монгол Улсад анх удаагаа олон улсын жишиг ЯТ-ийн загвар болж, Монгол Улсын бусад ЭМБ-т мэдээлэл түгээх, хуваалцах зэрэг хэрэгцээ шаардлагад

үндэслэн хамгийн түрүүнд эмнэлэг дотор ойлголт өгөх зорилгоор эмнэлэг дотооддоо семинарыг зохион байгуулахаар бэлтгэлийг хийж ирсэн. Эмнэлгийн дотоод семинар зохион байгуулах тогтолцоо бүрдүүлсэн.

1 дэх удаагийн эмнэлгийн дотоод семинарыг 2022 оны 9-р сарын 22-ны өдөр ҮДА, ХСХ, аюулгүй байдлын удирдлага гэсэн сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Эмнэлгийн дотоод семинарыг тогтмол зохион байгуулж, ЯТ-ийн хувьд 2 дахь удаагийн семинараас хойш эмнэлгийн дотоод мэдээлэл түгээх, солилцох арга хэмжээг зохион байгуулж, ижил үр дүнд хүрсэн бөгөөд Монгол Улсын бусад ЭМБ-т мэдээлэл түгээж, хуваалцана. Түүнчлэн Монгол Улс даяарх ЭМБ-т чиглэсэн мэдээлэл түгээх арга хэмжээг ХСХ болон сувилахуйн менежментийн хүрээнд ЯМЭ санаачлан зохион байгуулсан бөгөөд ЯТ-ийн хувьд ч ижил арга барилаар хэрэгжүүлнэ.

(6) Гэрээний нийт хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил

1) Мэдээлэл хуваалцах, солилцох зорилгоор хурал зохион байгуулах (Төслийн зохицуулалтын хурлыг мөн тооцно)

2020 оны 6-р сарын 4-нд шинэ төрлийн корона вирусын цар тахлын нөлөөнөөс монголд ажиллах бэрхшээлтэй байсан тул 4 дэх удаагийн Хамтарсан зохицуулах хорооны хурал (ХЗХ)-ыг онлаинаар зохион байгуулав. Монгол талаас БШУЯ, ЭМЯ, СЯ, ГХЯ, АШУУИС, ЯМЭ, япон талаас Японы элчин сайдын яам, ЖАИКА, ЖАИКА-гийн Монгол дах Төлөөлөгчийн газар, төслийн баг оролцов.

ЯМЭ-ийн харъяалал ЭМЯ-наас БСШУСЯ-нд шилжсэн тул ХЗХ-ны гүйцэтгэх үүрэг, төслийн зорилт, ИСЭ-ийн концепц зэргийг дахин магадлаж, үйл ажиллагааны явц болон хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, цаашдын үйл ажиллагаа зэргийн талаар хэлэлцэв. Төслийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудалтай холбогдуулан цаашид, ялангуяа доорх асуудлын талаар онцгойлон анхаарч ажиллах тухай магадлалцав (Дэлгэрэнгүйг Хавсралт 4-2 “Хамтарсан зохицуулах хорооны хурлын тэмдэглэл”-ээс үзэх)

- Эмнэлгийн захиралд төвлөрсөн эмнэлгийн менежментийн удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэх
- Төслийн холбогдох талууд хоорондын уялдаа холбоот үйл ажиллагааг бэхжүүлэх
- ЯМЭ-ийн хороодын үүрэг, үйл ажиллагааг бэхжүүлэх
- Эмнэлгийн санхүүг зохистойгоор удирдан хянах
- Эмнэлзүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэхэд чиглэсэн тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамж, нийлүүлэлт, хүний нөөцийн бэлтгэл, төсвийн хангамж
- Шинэ төрлийн корона вирусын халдвартай өвчтөн хүлээж авахтай холбоотой үйл ажиллагаа

Мөн, 2021 оны 10-р сарын 1-нд хосолсон хэлбэрээр (монголд ажиллаж байгаа төслийн багийн гишүүн монголоос, японд байгаа гишүүд онлаинаар оролцсон) 5 дах удаагийн ХЗХ-

ны хурлыг зохион байгуулав. Хуралд монгол талаас БШУЯ, ЭМЯ, СЯ, ГХЯ, АШУҮИС, ЯМЭ, япон талаас Японы элчин сайдын яам, ЖАИКА, ЖАИКА-гийн Монгол дах Төлөөлөгчийн газар, төслийн баг оролцов. Хурлаар хэлэлцсэн асуудлыг дор дурдав. Төсөл хэрэгжих хугацааг сунгаж, ТТМ-д өөрчлөлт оруулсан болно (Дэлгэрэнгүйг Хавсралт 4-2 “Хамтарсан зохицуулах хорооны хурлын тэмдэглэл”-ээс үзэх).

- ЯМЭ-ийн үйл ажиллагаа, төслийн үйл ажиллагааны тайлан
 - АШУҮИС-ийн харъяанд орсны дараах шинэ удирдлага, зохион байгуулалт
 - Коронагийн халдвартай өвчтөн хүлээж авч буй удирдлага, зохион байгуулалт
 - Үйлчилгээ үзүүлж буй нөхцөл байдал
 - Эмнэлгийн менежментийн хувьд цаашид шийдвэрлэх асуудлууд
- Төслийн цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө
 - Төсөл хэрэгжүүлэх хугацааг сунгах
 - Хүрвэл зохих зорилтыг эргэн нягтлах (ТТМ-д өөрчлөлт оруулах)
 - Үйл ажиллагааны төлөвлөгөө

2022 оны 9-р сарын 14-нд, хосолсон хэлбэрээр 6 дах удаагийн ХЗХ-ны хурлыг зохион байгуулав. Хуралд монгол талаас БШУЯ, ЭМЯ, АШУҮИС, ЯМЭ, япон талаас ЖАИКА, ЖАИКА-гийн Монгол дах Төлөөлөгчийн газар, төслийн баг оролцов. Хурлаар хэлэлцсэн асуудлыг дор дурдав. Хурлын зорилго нь тус төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл, ТТМ-д тодорхойлсон төслийн зорилт, үр дүнд хүрсэн байдал, DAC үнэлгээний стандартад суурилсан үнэлгээний дүнгийн талаар тайлагнах, хэлэлцэх байв. Хэлэлцэж ярьсны дүнд, төслийн зорилт, үр дүнд хүрсэн, DAC үнэлгээний стандартын 6 зүйлт үнэлгээгээр өндөр үнэлгээ авсан тухайд хуралд оролцогчид санал нэгдэв. (Дэлгэрэнгүйг Хавсралт 4-2 “Хамтарсан зохицуулах хорооны хурлын тэмдэглэл”-ээс үзэх)

- ЯМЭ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэл
 - ЯМЭ-ийн замнал
 - Үйлчилгээ үзүүлж буй нөхцөл байдал
 - Монгол талын оролцоо, хамтын ажиллагаа болон бусад
- Төслийн үйл ажиллагааны эцсийн тайлан
 - Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл, оролцоо, үүрэг
 - Төслийн зорилт, үр дүнд хүрсэн байдал
 - DAC үнэлгээний стандартад суурилсан үнэлгээний дүн

2.2 Төслийн хүрсэн үр дүн

2.2.1 Үр дүн ба шалгуур үзүүлэлт

Үр дүн болон үр дүн тус бүрд хүрсэн байдлыг дүгнэх шалгуур үзүүлэлт болон биелэлтийн байдлыг Хүснэгт 21-д харуулав.

Хүснэгт 21 Үр дүнд хүрсэн байдал

Биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлт	Биелэлт
Үр дүн 1: ЯМЭ нь зүй зохистой менежменттэй болох	
<p>Шалгуур үзүүлэлт 1-1</p> <p>Төсөл дуусахад ЯМЭ-ийн Захиргааны хороо байгуулагдаж, хорооны дүрэм, журмын дагуу хорооны үйл ажиллагааг явуулдаг байх</p>	<p>【Биелсэн】</p> <p>Захиргааны хороо нь дүрмийн дагуу сард нэг удаа хуралддаг болсон. Удирдах дээд зохион байгуулалт болох эмнэлгийн захирлын хороо (эмнэлгийн захирал, дэд захирлууд, хүний нөөцийн албаны дарга) нь улиралд 1 удаа хуралддаг болсон. Эмнэлгийн захирлын хороогоор эмнэлгийн үйл ажиллагааны удирдлага, стратеги, чиглэлийг шийдвэрлэдэг болсон. Уг шийдвэрийн дагуу үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөөг гаргаж захиргааны хороо шийдвэрлэдэг болсон. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.</p>
<p>Шалгуур үзүүлэлт 1-2</p> <p>Төсөл дуусахад ЯМЭ нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу эмнэлгийн (санхүүгийн менежмент, бараа материал, хэрэгслийн хангамж, нийлүүлэлт, түгээлтийн менежмент, эмнэлгийн мэдээллийн менежмент) менежментийг хэрэгжүүлж чаддаг байх</p>	<p>【Биелсэн】</p> <p>Нэгж, албадын удирдлагаас бүрдэх захиргааны хурлыг 7 хоног бүрийн Даваа гаригт хийдэг. Захиргааны хурлаар шийдвэрлэсэн төлөвлөгөөний дагуу хэлэлцэж ярилцан, мөнхүү үр дүнгийн дагуу нэгж, албадууд тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлдэг. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.</p>
Үр дүн 2: ЯМЭ-т өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	
<p>Шалгуур үзүүлэлт 2-1</p> <p>Төсөл дуусахад эрэмбийн хувьд тэргүүлэх эмнэл зүйн тасгуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний бодит гүйцэтгэлд тулгуурлан клиникал патвэй (clinical pathway)-н загвар/жишгийг боловсруулж, багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээнд хэрэгждэг байх</p>	<p>【Биелсэн】</p> <p>Клиникал патвэй-н хороо болон ажлын хэсгийг байгуулж, өвчнийг сонгон, боловсруулахаар ажиллаж байна. Хэвлийд дурангаар хагалгаа хийж цөсний уут авах клиникал патвэй-г боловсруулсан. Уг клиникал патвэй-г холбогдох хүмүүс /баг/ 9-р сард багтаан ашиглаж эхэлнэ. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.</p>
<p>Шалгуур үзүүлэлт 2-2</p> <p>Төсөл дуусахад ЯМЭ-ийн бүх нэгжид эмнэлгийн тусламж үйлчилгээний ослоос сэргийлэх болон эмнэлгийн дотоод халдварын эсрэг арга хэмжээтэй холбоотой дүрэм, журам болон удирдамжийг дагаж мөрддөг байх</p>	<p>【Биелсэн】</p> <p>Болзошгүй эгзэгтэй тохиолдол, тохиолдлын форматыг ашиглан ЭТҮ-ний осол гарахаас сэргийлэх зохион байгуулалтыг бүрдүүлсэн. Эмнэлгийн дотоод халдварын дүрмийн дагуу Халдварын сэргийлэлт, хяналтын алба долоо хоног бүр тойролт хийж, эмнэлгийн дотоод</p>

Биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлт	Биелэлт
	халдварын арга хэмжээг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг бүрдүүлсэн. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.
Үр дүн 3 : Дэвшилтэт эмнэлгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	
Шалгуур үзүүлэлт 3-1 Төсөл дуусах үед дор хаяж 3 салбар (СТ, MRI, дуран гэх мэт)-т японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан шинэ оношилгоо, эмчилгээний технологи нэвтэрсэн байх	【Биелсэн】 СТ, MRI, дуран, маммограф, эхо-н оношилгоо хийгдэж байна. Уг үр дүнд үндэслэн эмчилгээ хийгдэж байна /ангиографаар судасны эмчилгээ (зүрх судас, тархины судас), 12 нугалмай гэдэс тайрах, өвдөг, аарцагны үенд дурангаар хагалгаа хийх, арьс шилжүүлэн суулгах, бүдүүн гэдэсний хавдар, ходоод тайрах, хэвлийн хөндийн дурангаар цөсний уут авах, элэгний хорт хавдрын хагалгаа гэх мэт/ Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.
Шалгуур үзүүлэлт 3-2 Төсөл дуусах жилд дор хаяж 3 удаа ЯМЭ-ийн дотоодод воркшоп зохион байгуулах	【Биелсэн】 Дүрс оношилгооны тасгаас дүрс оношилгооны төхөөрөмжтэй холбоотой эмнэлгийн дотоодын сургалт болон корона вирусын үед авч хэрэгжүүлэх япон маягийн халдвар хамгаалалт, сувилахуйн албанаас япон маягийн менежментээр өвчтний менежментийг хэрэгжүүлэх, халдварын сэргийлэлт, хяналтын албанаас халдвар хамгааллын менежмент гэх мэт сэдвээр тус бүр сургалт, воркшоп зэргийг зохион байгуулж байна. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.
Үр дүн 4 : ЯМЭ-т өндөр түвшний яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх	
Шалгуур үзүүлэлт 4-1 Төсөл Төсөл дуусахад голлох эмнэлгийн тусламж үйлчилгээг 24 цагаар үзүүлэх удирдлага, зохион байгуулалт бүрдсэн байх	【Биелсэн】 ЭМЯ-наас коронагийн халдвартай өвчтөн авах заалтыг цуцалсны дараа яаралтай тусламж шаардлагатай өвчтнийг хүлээн авч байна. Ажилтнуудыг 4 багт хуваан 24 цагаар яаралтай тусламж үйлчилгээ үзүүлж байна. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.
Шалгуур үзүүлэлт 4-2 Төсөл дуусахад ЯМЭ-ийн яаралтай тусламж үйлчилгээний туршлага, мэдлэгээс АШУҮИС-ийн тухайлах сургалтын хөтөлбөрт тусгах	【Биелээгүй】 Коронагийн нөлөөгөөр яаралтай тусламжийн үйл ажиллагааг бодитоор эхлүүлсэн нь 2022 оны 3-р сар буюу саяхан тул төслийн үлдсэн хугацаанд

Биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлт	Биелэлт
	<p>сургалтын хөтөлбөрт тусгах зохион байгуулалтыг бий болгох, бэлтгэл ажилд анхаарал хандуулан ажиллаж ирсэн. Үүний дүнд сургалтын хөтөлбөрт тусгах асуудлыг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг бий болгосон (яаралтай тусламжийн тасгийн ажилтан нь АУС-ийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тэнхмийн багшаар томилогдож тогтмол хугацаанд санал солилцож ажиллаж ирсэн) Энэхүү зохион байгуулалтын дагуу өнөөгийн сургалтын хөтөлбөрийг эргэн харж өөрчлөх ажил эхлээд, 2023 оны 4-р сар орчимд дуусах төлөвтэй байгаа.судалж эхлээд байна. Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийг биелсэнд тооцов.</p>

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

2.2.2 Төслийн зорилт ба шалгуур үзүүлэлт

Төслийн зорилт, зорилтийг биелүүлсэн байдлыг дүгнэхийн тулд шалгуур үзүүлэлт болон биелэлтийн байдлыг Хүснэгт 22-т үзүүлэв.

Хүснэгт 22 Үр дүнгийн биелэлтийн байдал

Биелэлтийн байдлыг дүгнэх шалгуур үзүүлэлт	Биелэлт
Төслийн зорилт: ЯМЭ нь технологийн түвшин, чанарын хувьд өндөр түвшиний эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхүйц бүтэц зохион байгуулалтыг бий болгох	
Шалгуур үзүүлэлт 1. Төслийн сүүлийн жилд орны эргэлт 80%-иас дээш хувьд хүрсэн байх	<p>【Биелсэн】 Захиргааны албаны мэдээг авч үзвэл (өглөө бүр 8 цагт авдаг мэдээний дундаж) 2022 оны 6-р сарын байдлаар орны эргэлт 85% хүрч зорилтот үзүүлэлтийг давсан бөгөөд уг шалгуурыг биелсэнд тооцов.</p>
Шалгуур үзүүлэлт 2. Төсөл дуусахад ЭТҮ-ний талаарх өвчтний сэтгэл ханамж 80% давсан байх	<p>【Биелсэн】 ЭМ-ийн сайдын А/578 тушаалаар батлагдсан маягтыг ашигласан. Өвчтний сэтгэл ханамжийн судалгааны дүнд 2022 оны эхний хагасын байдлаар сэтгэл ханамж 89,6% байгаа нь зорилтот үзүүлэлтийг давсан бөгөөд уг шалгуурыг биелсэнд тооцов (1897 өвчтөн оролцсон)</p>
Бусад	<p>【Биелсэн】 Менежментийн чадавх, тусламж үйлчилгээний</p>

Биелэлтийн байдлыг дүгнэх шалгуур үзүүлэлт	Биелэлт
	удирдлага, зохион байгуулалт үнэлэгдэж, 2022 оны 7-р сард ISO олгосон /Монголд цөөхөн эмнэлэг авсан/ Үүнээс авч үзсэн ч эмнэлгийн тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт бүрдсэн гэж дүгнэх боломжтой.

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

2.2.3 Нэгдсэн үнэлгээ

“Үр дүн 4 Яаралтай тусламж үйлчилгээ”-ний “Шалгуур үзүүлэлт 4-1-н ЯМЭ-ийн туршлагыг АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөрт тусгах”-аас бусад үр дүнгийн тухайд төслийн зорилт болон үр дүн биеллээ олсон гэж үзэж болно. Яаралтай тусламж үйлчилгээний тухайд, ЯМЭ нь коронагийн халдвартай өвчтөн хүлээн авах эмнэлгээр ажиллах чиглэл авч, яаралтай тусламжийн тасаг нь коронагийн халдвартай өвчтний эрэмблэлт, хүнд өвчтөн хүлээж авах үйл ажиллагаа хэрэгжүүлж байсан учраас яаралтай тусламж үйлчилгээг 2022 оны 3-р сараас нэгдсэн байдлаар үзүүлж эхлэсэн бөгөөд сургалтын хөтөлбөрийг шинэчлэхээр АШУҮИС болон ЯМЭ-ийн хамтарсан зохион байгуулалт хийгдэж, АШУҮИС-ийн 2023 оны шинэ хичээлийн жилийг угтан хөтөлбөрийг шинэчлэн өөрчлөх ажлыг эхлүүлсэн байгаа бөгөөд 2023 оны 4-р сар орчимд ЯМЭ-ийн туршлагыг тусгасан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэн шинэчлэх ажил хийгдэх төлөвтэй байна.

3. ТТМ-д өөрчлөлт оруулсан явц

2019 оны эцсээр тархсан шинэ хэлбэрийн корона вирусын цар тахлын нөлөөнөөс мэргэжилтнүүд монголд ажиллах, монголоос японд сургалтад хамрагдах нь хүндрэл бэрхшээлтэй болсон. Иймд, онлайн систем ашиглан хурал, уулзалт зохион байгуулах, мониторинг хийх, технологи шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байсан боловч талбар дээр зааж зөвлөх боломжгүй байсан. 2021 оны 3-р сар хүртэл 1 жил гаруй хугацаанд мэргэжилтэн эзгүй байж, төслийн хэрэгжих хугацааг сунгах гэх мэтчилэн үйл ажиллагааны агуулга, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг өөрчлөх шаардлагатай болсон. Өөрчлөх агуулгын талаар 2021 оны 10-р сард зохион байгуулсан 5 дах удаагийн ХЗХ-ны хурлаар хэлэлцэж ярилцаад бүх гишүүд санал нэгдсэн. Уг агуулгыг дор дурдав.

Хүснэгт 23 ТТМ-д оруулах өөрчлөлт

	Шалгуур үзүүлэлт	Өөрчлөгдөхийн өмнө	Өөрчилсний дараа
Төсөл хэрэгжих хугацаа	—	2017.02 - 2022.01	2017.02 - 2022.10
Төслийн зорилт	1	Төслийн сүүлийн жилд эмнэлгийн орны эргэлт 90%-иас дээш байх	Төслийн сүүлийн жилд эмнэлгийн орны эргэлт 80%-иас дээш байх
	2	Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх өвчтний сэтгэл ханамж **%-иас дээш байх	Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх өвчтний сэтгэл ханамж 80%-иас дээш байх
Үр дүн 1	1-1	Төсөл дуусахад ЯМЭ-ийн бүтцийн зурган дээрх бүх алба, тасаг, нэгж хангалттай үйл ажиллагаатай байх	Төсөл дуусахад ЯМЭ-ийн Захиргааны хороо байгуулагдаж, хорооны дүрэм, журмын дагуу хорооны үйл ажиллагааг явуулдаг байх
	1-2	Төсөл дуусахад ЯМЭ-ийн менежментийн үйл ажиллагаа бие даасан, амжилттай явагддаг байх	Төсөл дуусахад, ЯМЭ нь эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу эмнэлгийн (санхүү, нягтлан бодох бүртгэл, бараа материал, хэрэгслийн хангамж, нийлүүлэлт, түгээлт, эмнэлгийн мэдээллийн менежмент) менежментийг хэрэгжүүлж чаддаг байх
Үйл ажиллагаа	2-1-2	Японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагад тулгуурлан багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх удирдамж, нэвтрүүлэх төлөвлөгөө, эмнэлгийн ажилтнуудын ур чадварыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулан	Японд зохион байгуулсан сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагад тулгуурлан багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний практик арга, хэрэгсэл, харилцааны системийг бүрдүүлж, эмнэлгийн ажилтнуудын ур чадварыг бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулан гаргах

	Шалгуур үзүүлэлт	Өөрчлөгдөхийн өмнө	Өөрчилсний дараа
		гаргах	
	2-1-4	АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэгт хэд хэдэн туршилтийн тасгуудад удирдамжийн дагуу багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг туршилтаар нэвтрүүлэх	АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэгт хэд хэдэн туршилтийн тасгуудад практик арга, хэрэгсэл, харилцааны системийг ашиглан, багаар үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг туршилтаар нэвтрүүлэх
	2-2-3	Туршилтаар нэвтрүүлсэн үр дүнд үндэслэн клиникал патвэй (clinical pathway) ашиглаж эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартчлах үйл ажиллагааг ЯМЭ-г ашиглалтад орсны дараа шат дараатайгаар бүх тасгуудад хэрэгжүүлэх	Туршилтаар нэвтрүүлсэн үр дүнд үндэслэн ЯМЭ-г зохицож нийцсэн жишиг клиникал патвэй (clinical pathway)-г боловсруулж, эрэмбийн хувьд тэргүүлэх тасгуудад хэрэгжүүлэх

Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

4. Бусад

4.1 Байгал орчин, нийгмийн нөлөөллийг анхаарах нь

Уг төслийн хүрээнд онцгойлон анхаарвал зохих зүйл биш юм. Гэхдээ эмнэлгийн хог хаягдлын хувьд эмнэлгийн дотоодод стандартын дагуу ялгаж байж эмнэлгийн хог хаягдлыг устгадаг мэргэжлийн байгууллагад ханддаг.

4.2 Жендер, энх тайвныг тогтоох болон ядуурлыг бууруулах зэргийг анхаарах нь

Уг төслийн хүрээнд, эмнэлгийн менежментийг бүрдүүлж, эмнэлийн тусламж үйлчилгээний тогтолцоог төгөлдөржүүлэхийг зорьсон юм. Ялангуяа. Эмэгтэй өвчтний менежмент болон сувилагч (ажилтны ихэнх нь эмэгтэй) нартай холбоотой удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлж, өвчтний жендерийн асуудалд дараах байдлаар анхаарал хандуулж, дэмжлэг үзүүлэн ажилласан.

- Өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний гол ажлыг нугалах сувилахуйн албаны эмнэлгийн дотоод дах байр суурийг бэхжүүлэхийн тулд сувилахуй хариуцсан эмэгтэй дэд захирлын албан тушаалыг бий болгосон
- ЯМЭ-ийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа нь 20:80-н харьцаатай бөгөөд эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлдэг. Иймд, эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцааг засах болон захиргааны хурал зэрэгт үг хэлэх тэгш эрхээр хангахад дэмжлэг үзүүлсэн
- Эрүүл мэндийн үзлэгт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн онцлогтой өвчин (хөхний хавдар, түрүү булчирхайн хавдар гэх мэт)-д анхаарал хандуулсан үзлэгийн жагсаалтыг гаргах зөвлөгөө өгсөн
- Маммографаар дүрс авахад эмэгтэй техникч ажиллах
- Өвчтөн дэмжих төвд эрэгтэй, эмэгтэй өвчтөнд зориулсан эмнэлэгт хэвтүүлэх төлөвлөгөө гаргах болон өвчтөнд чиглэсэн дэмжлэг
- Хэвтэн эмчлүүлэх тасгийг нээх менежментийн тогтолцоог нэвтрүүлж, эрэгтэй, эмэгтэй хүйсийн тоогоор ялгаж эмнэлэгт хэвтүүлэх орчин

Мөн, ядуу давхаргын өвчтөнд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх тухайд, Өвчтөн дэмжих төвийг байгуулан, уг төв нь эмнэлэгт хэвтэх өвчтний эдийн засгийн нөхцөл байдалд тааруулж нийцүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх процедурыг хийх тогтолцоог бүрдүүлсэн.

5. Төслийн үнэлгээ

5.1 DAC үнэлгээний стандартад суурилсан үнэлгээний дүн

DAC-н 6 шатлалт үнэлгээний стандартыг дор дурдав¹². Үнэлгээний түвшинд “өндөр”, “харьцангуй өндөр”, “дунд зэрэг”, “харьцангуй доогуур”, “доогуур” гэсэн 5 шатлалыг ашиглав.

【Зохицож нийцэх байдал (Relevance)】

- Дэмжлэг хэрэгжүүлэлтийн зохицож нийцэх байдал (тухайн орны хөгжлийн төлөвлөгөө, хөгжлийн хэрэгцээ шаардлага/нийгмийн хэрэгцээ шаардлага/төслийг хэрэгжүүлэх бүс нутгийн ашиг хүртэх давхарга)
- “Ашиг хүртэгч”-д анхаарал хандуулж, эмзэг давхаргынханд очих нөлөөллийг анхаарч, тэгш, шударга байдлыг харгалзаж төслийг төлөвлөсөн эсэх. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд нөхцөл байдал өөрчлөгдөхөд ч хэзээд зохицож нийцэх байдлаа хадгалсаар байхын төлд зохистой зохицуулалт хийсэн эсэх
- Төслийн төлөвлөгөө, арга замын зүй тогтлын зохист байдал

【Уялдаатай байдал (Coherence)】

- Японы ЗГ, ЖАИКА-гийн хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлтэй уялдах байдал
- ЖАИКА-гий бусад төсөл (техникийн хамтын ажиллагаа, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хамтын ажиллагаа зэрэг)-тэй тодорхой харилцан үр дүнтэй нөлөөлөх, харилцан уялдах
- Японы бусад төсөл, бусад тусламжийн байгууллага зэргийн дэмжлэгтэй зохистойгоор харилцан нөхөж, зохилдож, нийлэмжтэй байж, олон улсын үйл ажиллагаа (Тогтвортой хөгжлийн зорилго гэх мэт олон улсын хамтын зорилт, санаачилга), олон улсын журам, стандарттай уялдаж, тодорхой үйл ажиллагаа болон найдвар тавихуйц үр дүн үзүүлж буй эсэх

【Үр ашигт байдал (Effectiveness)】

- Үр дүн хүлээгдэж буй төслийн үр ашгийн зорилтот хугацаанд зорилтот түвшинд хүрэх байдал (байгууламж, тоног төхөөрөмж зэргийг мөн тооцно), ашиг хүртэгч хооронд биелэлт, үр дүнгийн талаар ялгаатай байдал байгаа эсэх

【Нөлөөлөл (Impact)】

- Эерэг, сөрөг, дам болон урт хугацааны нөлөөллийн бодит нөхцөл байдал (нийгмийн тогтолцоо болон хэм хэмжээ, хүмүүсийн аз жаргал, жендерийн тэгш байдал, байгал орчин, нийгмийн нөлөөллийг анхаарах)

【Бүтээмжит байдал (Efficiency)】

- Төсөлд хариуцах үүрэг, оролцооны төлөвлөлт, төслийн хугацаа, зардлын

¹² “ЖАИКА-гийн үнэлгээний тогтолцоо гэж юу вэ”-с иш татав.<https://www.jica.go.jp/activities/evaluation/about.html>

төлөвлөгөө ба гүйцэтгэлийн харьцуулалт

【Тогтвортой байдал (Sustainability)】

- Төсөл хэрэгжсэнээр бий болсон үр нөлөөны тогтвортой байдлын төлөв
- Зохион байгуулалт, тогтолцоо (бүтэц, зохион байгуулалт/хүний нөөц), технологи, санхүү (менежмент, байнгын хэвийн ажиллагааг хангах төсвийн хангамжийн өнөөгийн байдал, байгал орчин, нийгэм, эрсдлийн арга хэмжээ, үйл ажиллагааг хэвийн хэрэгжүүлж буй нөхцөл байдал

(1) Зохицож нийцэх байдал (Relevance) : Өндөр

Монгол Улс Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-г 2016 онд баталсан. Энэхүү үзэл баримтлалд жирэмсэн эхийн эндэгдэл болон нярайн эндэгдлийг бууруулах зорилт тавьсан. Эрүүл мэндийн салбарын стратегийн хувьд “үр дүнтэй бөгөөд сайн чанартай, хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоо”-г бий болгох зорилт дэвшүүлсэн ба тухайлбал эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, шинжилгээ, оношилгооны чадавхыг дээшлүүлэх, өвчлөх, нас барах эрсдлийг бууруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх гэх мэтийг дурдаж болно. Нөгөөтэйгүүр, 2020 оны 12-р сард УИХ-аар баталсан “Алсын хараа-2050”-д 9 зорилт дэвшүүлсэн бөгөөд үүний доторх “2. Хүний хөгжил”-д “Эрүүл монгол хүнийг зорино” гэж тусгасан байдаг.

Мөн, дээр үндэслэлд дурдсанчлан уг төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө, эрүүл мэндийн байгууллагын ажилтны чанар доогуур байгаа тухай асуудал хөндөгддөг байв. Монгол Улсын ЗГ нь эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын ур чадавхыг бэхжүүлэхээс эхлүүлэн олон янзын бодлогын хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо болон сургалтын хөтөлбөр гэх мэтчилэн сургалтын тогтолцоо, сургалтын орчин хангалттай бүрдээгүй асуудлууд байсаар байсан. Тус төсөл нь, ЯМЭ-ийг эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын бааз суурь байхын зэрэгцээ сүүлийн үед нэмэгдэх хандлагатай байгаа халдварт бус өвчин (Non-Communicable Diseases, цаашид ХБӨ гэх) болох тархины судасны өвчнүүд, хорт хавдар зэргийг оношилж, эмчлэх өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг түшиц болгож, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэхийг зорьсон бөгөөд тус эмнэлэг нь ирээдүйд монголын эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад хувь нэмрээ оруулна гэж найдвар хүлээж байгаа юм.

Төслийн үйл ажиллагааг эхлүүлж байхад ЯМЭ-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч байгууллага болох АШУҮИС нь 25 ортой эмнэлгийг л ажиллуулж байснаас өөр туршлагагүй байв. Иймд сургалтын эмнэлэг нь “эмнэлзүй”, “сургалт”, “эрдэм шинжилгээ, судалгаа” гэсэн 3 гол үүрэгтэй боловч тус төсөл юуны өмнө нэгдсэн эмнэлгийнхээ нь хувьд өндөр түвшинд үйл ажиллагаа явуулдаг, сайн чанарын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэхийг зорьсон юм. Мөн, эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлэхээс

өмнө, голдуу японд сургалт зохион байгуулах замаар монгол талын холбогдох хүмүүст технологи шилжүүлж, эмнэлгийн үйл ажиллагаа эхэлснээс хойш ажлын байран дээрх сургалтаар дамжуулан технологи шилжүүлж, корона цар тахлаас үүдсэн зогсонги үед онлаинаар дамжуулан технологи шилжүүлж, өнөөгийн байдлаар амбулаторид өдөрт 500 орчим хүн үйлчлүүлж, хэвтэн эмчлүүлэх тасгийн орны эргэлт 85%-ийг давж, эмнэлэг өндөр түвшинд үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээрээс үзэхэд тус төсөл нь монголын ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулахад хувь нэмэр оруулах төсөл бөгөөд монгол талын хэрэгцээ шаардлагад нийцэж, төслийн төлөвлөгөө, арга зам нь ч зохицож, нийцэж байгаа гэж хэлж болно.

(2) Уялдаатай байдал (Coherence) : Өндөр

Манай улсын ГХЯ-ны “Монголд хэрэгжүүлэх хөгжлийн хамтын ажиллагааны чиглэл” (2017 оны 12-р сар)-д “Тухайн улс, бүс нутаг руу чиглэсэн хөгжлийн хамтын ажиллагааны зорилго”-д “Нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах” гэж дурдсан байдаг. Тухайлбал, “Тэргүүлэх салбар (3) Тэгш оролцоот нийгмийг бүтээх” дотор “Нийгмийн нөхцөл байдалтай нийцэхүйц эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний түвшинд хүрэх үйл явцад дэмжлэг үзүүлэх” гэсэн байдаг. Улмаар, ЖАИКА “Монгол Улс, ЖАИКА Улс орны ангиллаар дүн шинжилгээ хийсэн баримт бичиг” (2017 оны 9-р сар)-т “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжүүлэх үйл ажиллагааг бэхжүүлснээр эдийн засгийн өсөлтөд нийцсэн сайн чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж, уг үйлчилгээний хүртээмж дэх бүс нутгийн ялгаатай байдлыг арилгахын зорих” гэж дурдсан байдаг. Тус төслийн хүрээнд, өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээн дээр нэмээд ирээдүйд монголын эрүүл мэндийг хамгаалах, сайжруулахад хувь нэмэр оруулах эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг бэлдэх, хөгжүүлэх, клиник судалгааны удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхийг зорьсон бөгөөд Японы Засгийн газар, ЖАИКА-гийн тусламжийн чиглэлтэй яв цав нийцэж байгаа гэж дүгнэж байна.

Тус төслөөс өмнө буцалтгүй тусламжаар “Япон-Монгол сургалтын эмнэлгийн төсөл” (цаашид буцалтгүй тусламж гэх) хэрэгжиж, ЯМЭ баригдсан. Уг төсөл нь буцалтгүй тусламж болон техникийн хамтын ажиллагаа, өөрөөр хэлбэл хард болон софт талыг нэгтгэж байж биеллээ олсон төсөл юм. Барьж байгуулах явцад буцалтгүй тусламжийн төслийн зөвлөх компани болон холбогдох талуудтай тогтмол уулзаж, хуралдан, софт талаас нь байгууламжийн зураг төсөл, төлөвлөлт зэрэгтэй холбоотой санал, зөвлөгөөг өгч ажилласан. Мөн, буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн СТ, MRI, ангиографын төхөөрөмжийг илүү үр ашигтай ашиглаж, оношилгоонд хэрэглэх үүднээс эдгээр төхөөрөмжийн аппликэшн сургалтыг тус төслийн хүрээнд хэрэгжүүлсэн.

Улмаар, ЖАИКА анхан болон хоёрдугаар шатлалын эмнэлгийн ажилтнуудад зориулсан төгсөлтийн дараах сургалтын бэхжүүлэхээр “Анхан болон хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл” (2015-2020 он) (1-р шат)-ийг

хэрэгжүүлж ирсэн. Өнөөгийн байдлаар эхний шатанд хэрэгжүүлсэн ерөнхий мэргэшлийн сургалтыг улам бүр өргөжүүлж, сувилагч болон эх баригч нарын төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлийн монгол талын төрийн захиргааны байгууллагын хяналтын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл” (2021-2025 он) (2-р шат)-ийг хэрэгжүүлж байна. ЯМЭ дээрх төгсөлтийн дараах сургалтын удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэх нь сургалтын эмнэлэг болон ЯМЭ-ийн хувьд маш чухал үүрэг юм. Үүний тулд, монголын эрүүл мэндийн байгууллагы ажилтнуудыг сурган бэлдэх удирдлага, зохион байгуулалтыг бий болгох үүднээс төгсөлтийн дараах сургалтын төслийн мэргэжилтнүүдтэй тухай бүр санал солилцож, хэрхэн оролцох үйл ажиллагааг төлөвлөхийн тулд чухал мэдээлэл болгон ашиглаж ирлээ. Энэ мэтчилэн, ЖАИКА-гийн хэрэгжүүлж буй бусад төсөлтэй үр ашигтайгаар уялдаж, хамтарснаар функционал эмнэлэг төлөвлөлт, тоног төхөөрөмжийн зохистой хэрэглээ, ЯМЭ дээр суурилсан төгсөлтийн дараах сургалт болон сувилагчийн сургалтыг зохион байгуулахад чиглэсэн үйл ажиллагаа, ЯМЭ-ийн ажилтан бөгөөд удирдагч багш/сувилахуйн ТОТ сургалт, фасилитаторыг бэлдэхэд оролцоо хамааралтай байх гэх мэтчилэн харилцан үр нөлөөтэй байгаа юм.

(3) Үр ашигт байдал (Effectiveness) : Өндөр

Тус төсөл нь төслийн зорилтын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн бүх зорилтот үзүүлэлтийг биелүүлсэн бөгөөд үр ашигт байдал өндөр гэж хэлж болно. Буцалтгүй тусламжийн төслийн эмнэлгийн барилгын ажлын удаашрал, хоцрогдол, ЯМЭ-ийн төсвийн хүрэлцээгүй, хангалтгүйгээс шалтгаалсан монгол талын хангамж, нийлүүлэлт хоцорсон, ЯМЭ-ийн хүний нөөцийн дутагдалтай байсан гэх мэт асуудал байсан боловч АШУҮИС-ийн анги танхимыг ашиглан эмнэлгийн симуляци хийх, япон дах сургалтуудыг оновчтой ашиглах, монгол талаас төсвийн тал дээр гаргасан (АШУҮИС-иас олгосон санхүүжилт ч мөн багтана) хүчин чармайлтын дэмээр эмнэлэг ашиглалтад орох боломжтой болсон. Нөгөө талаар, коронагийн нөлөөгөөр мэргэжилтнүүд монголд ажиллахад хүндрэл бэрхшээл тулгарч, онлаинаар технологи шилжүүлэх зэргээр ажиллаж байсан боловч ажлын талбар дээрх технологи шилжүүлэлт хангалтгүй байсан. Иймд, 5 дах удаагийн ХЗХ-ны хурлаар энэхүү нөхцөл байдлыг авч үзэн, төслийн хугацааг 8 сар орчим сунгахаар болсон. Үүний дүнд, төслийн зорилгыг биелүүлж чадсан билээ.

Төслийн үр дүн, үйл ажиллагаа тус бүрийг авч үзвэл ЯМЭ нь коронагийн цар тахлын зогсонги үед монгол улс дотроо коронагийн халдвартай өвчтөн хүлээж авах эмнэлэг болох чиглэл авч ажиллан, ялангуяа яаралтай тусламжийн тасаг нь коронагийн халдвартай өвчтний илрүүлэх шинжилгээ болон хүнд өвчтнийг хүлээн авах зэрэг үүрэг, хариуцлагыг үүрч байсан тул үндсэн яаралтай тусламж үйлчилгээгээ 2022 оны 3-р сараас эхлэсэн. Өнөөгийн байдлаар ТТМ-д дурдсан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлыг хийж байгаа боловч яаралтай тусламж үйлчилгээтэй холбоотой төслийн үйл ажиллагаа биеллээ олтол бага зэрэг

хугацаа шаардлагатай байна (2023 оны 4-р сар орчимд шинэчлэх ажил дуусах төлөвтэй байна).

Мөн, буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн ангиографын төхөөрөмжийн тухайд байгууламжид ус алдсан осол гарч, завсрын хугацаанд төхөөрөмжийг ажиллуулах боломжгүй болсон бөгөөд үүний улмаас тус төслийн хүрээнд сургалт хийх ажлыг төлөөлөн гүйцэтгэхээр болсон боловч коронагийн нөлөөгөөр сургалтын хугацааг товлоход хүндрэл гарч, эцэст нь 2022 оны 6-р сард хийж дууссан. Сургалтыг зохион байгуулснаар технологийн талын асуудал шийдвэрлэгдэж, цаашид үндсэн зориулалтаар нь ашиглаж эхлэх төлөвлөгөөтэй байгаа юм.

Төслийн зорилт хэрэгжсэн боловч хэрэгжих явцад тулгарсан саад бэрхшээл гэвэл ЯМЭ-ийн удирдлага олон дахин солигдож байсан явдал юм. Төсөл эхлэхэд харъяалал нь БШУЯ-нд байсан боловч 2019 оны 1-р сард ЭМЯ-нд шилжиж, 2020 оны 3-р сард дахин БШУЯ-нд шилжиж, 2022 оны 2-р сард БШУЯ-наас АШУҮИС-д шилжсэн. Энэ хооронд ЯМЭ-ийн захирал ч өөрчлөгдөж, өнөөгийн байдлаар 4 дэх захирал ажиллаж байна. Мөн, эмнэлгийн захирал солигдоход дагаад эмнэлгийн хүний нөөц солигддог асуудал байсан. Үүнээс болоод тухай бүр сургалтын эмнэлэг, япон маягийн менежментийн талаар холбогдох хүмүүст тайлбарлан танилцуулж, ярилцаж, ойлголт өгч, эмнэлгийн менежментийн тогтолцоог бүрдүүлж ажиллаж ирсэн. Энэ мэтчилэн уян хатан арга хэмжээ авч ажиллаж байсан нь төслийн зорилтыг биелүүлэхэд түлхэц болсон гэж хэлж болно.

(4) Нөлөөлөл (Impact) : Өндөр

Тэргүүлэх зорилт болох “ЯМЭ нь нэгдсэн эмнэлэг, сургалтын эмнэлэг болохынхоо хувьд өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах” тухайд сургалтын эмнэлэгт тавигддаг үүрэг болох “эмнэлзүй”, “сургалт”, “эрдэм шинжилгээ, судалгаа”-ны дотроос тус төслийн хүрээнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх менежментийг бүрдүүлэх шатанд хүргэсэн. Тухайлбал, 2019 оны 10-р сард амбулаторийн үйл ажиллагааг эхлүүлснээс хойш шат дараатайгаар дотрын хэвтэн эмчлүүлэх тасаг, мэс заслын хэвтэн эмчлүүлэх тасаг, хагалгааны тасаг, эрчимт эмчилгээний тасаг, яаралтай тусламжийн тасаг гэх мэтээр үйлчилгээнийхээ хүрээг улам бүр өргөжүүлэн тэлж, өнөөдөр амбулаториор өдөрт дунджаар 500 орчим хүн үйлчлүүлж, эмнэлгийн орны эргэлт 85%-д хүрч, өдөрт 10-20 хагалгаа хийгдэж, өвтөнд хүргэх өдөр тутмын эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг болсон.

Улмаар, ЯМЭ эмнэлгийн менежмент, удирдлага, зохион байгуулалттай холбоотой ISO-г энэ 7-р сард нэвтрүүлсэн¹³. Энэхүү ISO-г монголд цөөн тооны эмнэлэг нэвтрүүлсэн байдаг бөгөөд төслийн хүрээнд үзүүлсэн дэмжлэгийн нэг үр дүн мөн гэж хэлж болно. Эмнэлгийн зохистой менежментийн дор чанар сайтай эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны тогтолцоог бүрдүүлэх эхний нөхцөл мөн юм. Тэргүүлэх

¹³ Монголын Стандарт, Хэмжил зүйн газраас олгодог

зорилтод хүрэхийн тулд сургалт болон эрдэм шинжилгээ, судалгааны тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай бөгөөд цаашид япон талаас дор дурдсан дэмжлэгийг авахын зэрэгцээ монгол талын өөрсдийн хүчин чармайт ихээхэн үүрэгтэй.

【Япон тал】

- Клиник сургалт зохион байгуулахын тулд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх
- ЯМЭ дээр төвлөрсөн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалт, мэргэжлийн сургалтын тогтолцоог бүрдүүлэх
- Сайн чанартай клиник сургалт, клиник судалгааг хэрэгжүүлэхийн тулд өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх
- Монголд эмчлэх боломжгүй 26 өвчний клиник болон эрдэм шинжилгээ, судалгааны тогтолцоог бүрдүүлэх

【Монгол тал】

- ЯМЭ-ийн хууль эрх зүйн статус (дээд боловсролын тухай хуулинд оруулах өөрчлөлт)
- ЯМЭ-ийн үйл ажиллагааг тогтвортой байлгахын тулд санхүүжилтийг бататгах (сургалт, эрдэм шинжилгээ, судалгаанд шаардлагатай санхүүжилтийг төрөөс дэмждэг байх гэх мэт)
- Сургалтын тогтолцоог нэгтгэх үйл ажиллагаа (БШУЯ болон ЭМЯ-ны 2 тогтолцоог нэгтгэх)

Төслийн дам нөлөөний тухайд 1/ Нийт монголын хэмжээний эмнэлгийн тусламж үйлчилгээний түвшинг дээшлүүлэх, 2/ Монголын ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулах гэж дурдаж болох юм. ад илэрч болох юм. Эмнэлгийн тусламж үйлчилгээний түвшинг дээшлүүлэх тухайд, улсын хэмжээнд ЯМЭ-ийн сувилахуйн алба нь сувилахуйн менежментийн тухай, халдварын сэргийлэлт, хяналтын алба нь эмнэлгийн дотоод халдварын тухай ворк шоп зохион байгуулж, радиологийн эрдэм шинжилгээний хурал дээр илтгэл тавьж, эмнэлгийн мэдээллийн системийн мэргэжлийн салбар зөвлөлийг байгуулалцах зэргээр олон үйл ажиллагааны дүнд монголын дотоодын эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд, эмнэлэг зэрэгт олон тооны үр дүн гарч байна. Мөн, төслөөс заавар, зөвлөгөө өгч ажилладаг байсан ажилтнуудаас Хавдар судлалын үндэсний төв болон Улсын Хоёрдугаар төв эмнэлэг, Өргөө амаржих газрын удирдах албан тушаалд томилогдож, өвчтөн дэмжих төв байгуулж, өвчтөн төвтэй эмнэлгийн менежментийг бодитоор хэрэгжүүлэн ажиллах гэх мэт дам нөлөө гарсаар байна.

Коронагийн цар тахлын зогсонги үед бусад эмнэлгээс илүү ЯМЭ-ийн хэрэгжүүлж байсан халдвар хамгааллын арга хэмжээний талаар суралцах хүсэлт тал талаас ирж байсан ба ЯМЭ-ийн зүгээс заавар зөвлөгөө өгч, мэдээлэл, материалаар хангаж ажилласан. Ард иргэдийн дунд коронагийн халдвар аваад эмнэлэгт хэвтвэл ЯМЭ-т л хэвтэнэ гэхчлэн нэр нь түгж, ам сайтай байна¹⁴. Эрүүл мэндийг сайжруулах тухайд, амбулаториор өдөрт дунджаар 500 орчим хүн үйлчлүүлж, жилд 6000 гаруй өвчтнийг хэвтүүлэн эмчилж, өдөрт 10-20 хагалгаа

¹⁴ Улаанбаатар хотын иргэдийн фэйсбүүк дэх пост, comment

хийх зэргээр ЯМЭ нь ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулж байна. Тодруулбал, нийт 140 мянга орчим хүнд үйлчилж, эрүүл мэндийг сэргээх, хамгаалахад хувь нэмрээ оруулж байна.

Ялангуяа, ЯМЭ-ээр үйлчлүүлдэг өвчтний ихэнх нь жирийн иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настнууд гэх мэт нийгмийн эмзэг хэсэг байдаг бөгөөд ЯМЭ нь эрүүл мэндийн даатгалаар үйлчилдэг тул өвчтөн нь хямд бөгөөд найдвартай, өндөр түвшний тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхэд төслийн нөлөөлөл өндөр юм. Тухайлбал, өнөөг хүртэл хувийн эмнэлэгт болон гадаадад эмчлүүлж байсан 12 нугалмай гэдэс тайрах, өвдөг, аарцагны үеийн дурангийн хагалгаа, арьс шилжүүлэн суулгах, бүдүүн гэдэсний хавдар, ходоод тайрах зэрэг тусламж үйлчилгээг ЯМЭ дээр үзүүлэх боломжтой болсноор өнөөг хүртэл баян чинээлэг хүмүүс л авдаг байсан эмнэлгийн үйлчилгээг хямд төсөр үнээр авах боломжтой болсон юм. Өвчтөн болон өвчтний гэр бүлийн хувьд эдийн засгийн хувь нэмэр өндөр. Энэ мэтчилэн, тус төсөл хэрэгжсэнээр олон тооны технологийн болон удирдлага, зохион байгуулалтын үр нөлөө гарч байна. Нөгөөтэйгүүр, байгал орчин, нийгмийн хувьд сөрөг нөлөөгүй.

(5) Бүтээмжит байдал (Efficiency) : Өндөр

Япон дах сургалтууд, технологи шилжүүлэхээр япон мэргэжилтнүүд монголд ирж ажилласан нь монгол талын хувьд үр бүтээмжтэй, үр дүнтэй болж байсан. Тодруулбал, эмнэлэг үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө хангах ёстой бэлтгэл ажлуудыг жагсааж, тухайн гарсан үр дүнгийн дагуу япон дах сургалтыг төлөвлөж, уг сургалтыг үр бүтээмжтэй зохион байгуулж байсан. Япон дах сургалтын үеэр сургалтын мэргэжлийн шинж чанарын дагуу тухайн салбарын япон мэргэжилтнийг оролцуулж байсан. Мөн, монгол дах сургалтаар технологи шилжүүлэхдээ эхэн үедээ эмнэлгийн менежмент, санхүүгийн төлөвлөлт, хүний нөөцийн төлөвлөлт, дүрэм, журам боловсруулахтай холбоотой мэргэжилтнүүдийг оролцуулан, уг япон дах сургалтаар сурч мэдсэнийг магадлаж, сургалтын мөрөөр хамтран ажиллаж байсан. Эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт бүрдэхийн хэрээр тасаг тус бүртэй холбоотой япон мэргэжилтнүүдийг оролцуулан, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой дэмжлэг үзүүлж ажилласан. Монгол тал ч мөн адил нөөц бололцоогоо дайчлан эрүү мэндийн даатгалийн итгэмжлэлийг түргэн шуурхай авч, АШУҮИС болон БШУЯ, ЭМЯ нь ЯМЭ-т төсөв хуваарилуулах, монгол талын хариуцсан бараа, материалыг хангаж нийлүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх зэргээр эмнэлэг үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнөх, эхлүүлсний дараах, эмнэлгийн тусламж үйлчилгээний шат болгонд зохих байдлаар оролцож, хамтран ажиллаж, япон, монгол хоёр талын оролцоо зохистой байсан гэж дүгнэж байна.

Япон талын оролцоо, хариуцсан ажил (мэргэжилтний хүн/сар, төслийн санхүүжилт)-ын тухайд төслийн үр дүнг улам нэмэгдүүлэх, төслийн зорилтыг өндөр түвшинд ханган биелүүлэх үүднээс 2016 оны 9-р сард анх гаргасан төлөвлөгөөгөөр 88 хүн/ сар, 500 сая иений төсөвтэй байсныг шинэчилж, 186.05 хүн/сар, 757 сая иений төсөвтэй болсон. Энэ нь их

сургуулийн эмнэлэг болохынхоо хувьд ЯМЭ нь олон тасаг, албатай, улмаар нарийн мэргэжлүүдэд хуваагддаг тул олон салбарын япон мэргэжилтнийг оролцуулах шаардлагатай болсноос үүдэлтэй. Төслийн эхэнд төсөөлж тооцоогүй байсан төслийн үр дүнг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай төхөөрөмж, хэрэгслийн нийлүүлэлт, RIS хөгжүүлэлт, дүрс оношилгооны төхөөрөмжийн аппликэшн сургалт зохион байгуулах зэрэг шинэ оролцоо шаардлагатай болсны үр дүн юм. Улмаар, коронагийн цар тахал хэмээх төсөөлөгдөшгүй нөхцөл байдлаас шалтгаалан төслийн хэрэгжих хугацааг сунгасан (2022 оны 1-р сараас 2022 оны 10-р сар). Эдгээр шинж оролцоо, ажил, төслийн хугацааг сунгасан гэх мэт өөрчлөлт нь төслийн зорилтод хүрэхийн тулд хамгийн зүйтэй арга хэмжээ болсон гэж үзэж байна. Мөн, буцалтгүй тусламжийн барилгын ажил удааширч хоцорсон зэрэг шалтгаан байсан хэдий ч дэмжлэг үзүүлэх ажлын төлөвлөгөөг уян хатан шинэчлэн өөрчилж байснаар эмнэлэг үйл ажиллагаагаа эхлүүлж чадсан юм.

Төслийн үр дүн болон зорилтын биелэлтийг илүү үр өгөөжтэй болгохын тулд төслийг эхлүүлсэн хугацаа нь буцалтгүй тусламжийн нарийвчилсан зураг төслийн шатанд таарсан нь японы сургалтын эмнэлгийн мэдлэг, туршлагыг эмнэлгийн зураг төсөлд тусгах боломжоор хангасан бөгөөд энэ нь зүйтэй байсан гэж үзэж байна. Энэ тухайд төсөл эхэлсний дараа буцалтгүй тусламжийн төслийнхөнтэй тогмтол уулзаж ярилцан, сургалтын эмнэлгийн барилгыг илүү сайжруулан барьж байгуулахад санал зөвлөгөө өгч ажилласан.

(6) Тогтвортой байдал (Sustainability) : Өндөр

Доор дурдсан үүднээс тус төслөөс бий болсон үр дүн нь тогтвортой байдал өндөр гэж үнэлэгдэнэ.

1) Бодлогын хувьд

Монголын Засгын газар “үр дүнтэй бөгөөд сайн чанартай, хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх” болон “эрүүл монгол хүнийг зорино” гэсэн улсын стратеги баримталж байгаа бөгөөд энэ стратегийг хэрэгжүүлэхийн тулд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын чанарыг дээшлүүлэх шаардлагатай. ЯМЭ нь эдгээрт хувь нэмэр оруулахуйц монголд ганцхан байх сургалтын эмнэлэг бөгөөд бодлогын талаас тогтвортой гэж хэлж болно.

2) Удирдлага, зохион байгуулалтын хувьд

Удирдлага, зохион байгуулалтын хувьд ЯМЭ нь өнөөгийн байдлаар АШУҮИС-ийн удирдлага, харъяалал дор байгаа бөгөөд японы төрийн өмчит их сургуулийн харъяаны эмнэлэгтэй адил удирдлага, зохион байгуулалтын хэлбэр гэсэн үг юм. Иймд, анагаах ухааны боловсрол олгох, клиник сургалтыг нэг байгууллагын хувьд хамтран төлөвлөж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааг хэрэгжүүлэн, түүнийгээ үнэлэн, сайжруулаад явах боломжтой болсон. Нөгөөтэйгүүр, ЯМЭ нь төслийн заавар зөвлөгөөгөөр эмнэлгийн дотоод бүтэц, зохион

байгуулалт, хүний нөөцийн хуваарилалтын төлөвлөлтүүд хийгдэж, уг төлөвлөгөөний дагуу удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлж ажилладаг. Жишээлбэл, өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний үүднээс монголын уур бусад эмнэлгүүдтэй харьцуулахад сувилагчийн тоо 2 дахин их. Мөн, халдварын сэргийлэлт, хяналтын алба болон өвчтөн дэмжих төв гэх мэт өнөөг хүртэл монголын улсын эмнэлэгт байгаагүй, япон маягийн менежментэд зайлшгүй нэгжүүдийг зохион байгуулж, хүний нөөцийг ч нийцүүлэн хуваарилсан. Улмаар, хүний нөөцийн тогтвор суурьшлыг хангахын тулд өөр бусад улсын эмнэлгээс өндөр цалинтай гэх мэтчилэн удирдлага, зохион байгуулалтын хувьд тогтвортой байдал өндөр гэж хэлж болно.

3) Технологийн хувьд

Эмнэлгийн тусламж үйлчилгээний үүднээс ЯМЭ нь өдөрт дунджаар 500 орчим хүнд амбулаториор үйлчилж, орны эргэлт 85%-д хүрч, өнөөгийн байдлаар технологийн хувьд асуудалгүй. Гэвч, сургалтын эмнэлэг болж төлөвшихийн тулд цаашид эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд, оюутнуудад зориулан клиник боловсрол, сургалт зохион байгуулах болон монголын эрүүл мэндийг хамгаалахад хувь нэмэр оруулахын тулд эрдэм шинжилгээ, судалгаа хийх шаардлагатай. Үүний тулд япон талаас клиник сургалт зохион байгуулах бэлтгэл болгож сургалтын хөтөлбөрийг шинэчлэн өөрчлөхөд дэмжлэг авах, ЯМЭ дээр төвлөрсөн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах, мэргэжлийн сургалтын тогтолцоог бүрдүүлэх, монголд эмчлэгдэх боломжгүй 26 өвчний клиник болон судалгааны тогтолцоог бүрдүүлэхэд нэмэлт дэмжлэг авах шаардлагатай. Нөгөө талаар, монгол тал нь ЯМЭ-ийг сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны цөм төв болгон төлөвшүүлэхийн тулд ЯМЭ дээр эмч нарын зөвлөгөөн зохион байгуулах, мэдээлэл түгээх, БШУЯ болон ЭМЯ-ны сургалтын 2 тогтолцоог нэгтгэж, сургалтын хөтөлбөрийг өөрчлөн шинэчлэх гэх мэт өөрсдийн идэвх санаачилга шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээр ирээдүйд ЯМЭ нь олон улсын түвшний сургалтын эмнэлэг болох боломж нээгдэх юм.

4) Санхүүгийн хувьд

Санхүүгийн хувьд, үйл ажиллагаагаа эхэлсний дараахан алдагдалтай ажиллаж байсан тул төрөөс авах тотацид найдахаас өөр аргагүй байсан. 2021 онд ашигтай ажилласан. Гэвч, цаашид өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд өртөг зарах шаардлагатай болох ба эмнэлгийн тусламж үйлчилгээний орлого дангаараа бол тэрхүү өртгийн зардлыг нөхөх нь хүндрэл бэрхшээлтэй. Иймд, БШУЯ, ЭМЯ-наас тотаци авах зайлшгүй шаардлагатай. Манай улсын төрийн өмчит их сургуулийн харъяа эмнэлэг сургалт, судалгаа хийхийн тулд эмнэлгийн нийт төсвийн 20%-г тотациар бүрдүүлдэг. Энэ талаар төслийн багийн зүгээс монгол талын холбогдох хүмүүст завшаан гарах болгонд танилцуулж тайлбарлаж ирсэн. Нөгөө талаар, өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өндөр түвшинд хийж гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгө зардлын тухайд монголд энэ талаар өмнөх туршлага үгүй тул цаашид

хийж гүйцэтгэнгээ шаардлагатай өртөг зардал, түүнийг хэмнэх боломж зэргийн талаар авч үзэж, бодолцох шаардлагатай. Иймд, сургалтын эмнэлэг болохынхоо хувьд зохих санхүүгийн удирдлага, зохион байгуулалт хийхийн тулд санхүүгийн менежменттэй холбоотой дэмжлэг шаардлагатай.

5.2 Хэрэгжүүлэлт болон үр дүнд нөлөөлсөн чухал хүчин зүйлүүд

Тус төслийн үр дүнд нөлөөлсөн чухал хүчин зүйлүүд (эрсдэл, шийдвэрлэвэл зохих асуудал) болон авсан арга хэмжээний тухай дор дурдав.

- ЯМЭ нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар коронагийн халдвартай өвчтөн хүлээн авах эмнэлэг болж хэвтэн эмчлүүлэх тасаг, яаралтай тусламжийн тасагтаа урт хугацааны туршид хүлээн авч байв.. Үүний дүнд, мэс засал, яаралтай тусламж, хэвтэн эмчлүүлэх тасагт коронагийн халдвартай өвчтнөөс бусад өвчтөнд чиглэсэн тусламж үйлчилгээ хязгаарлагдсан. Амбулатори нь уг хугацаанд ч жирийн өвчтөн хүлээж авч байсан боловч аж, коронагийн халдвартай өвчтөн хүлээж авч байсан тул жирийн хагалгаа, хэвтэн эмчлүүлэх өвчтний тоо хязгаарлагдаж, эмнэлгийн үйл ажиллагаа, менежментэд нөлөөлсөн. Мөн уг хугацаанд, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлээгүй. Энэ хугацаанд ЯМЭ-т коронагийн халдвартай өвчтөн хүлээн авч байгаа нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудлын талаар онлайнаар магадлаж, японы их сургуулийн эмнэлгийн жишээн дээр коронагийн халдвартай өвчтөнд авч буй арга хэмжээ, эмчилгээний арга технологийг шилжүүлж, зөвлөгөө өгсөн. Ялангуяа эмнэлгийн дотоод халдварын арга хэмжээний тухайд монгол талд байнга мэдээллийг шинэчилж заавар, зөвлөгөө өгч байсан.
- 2021 оны 3-р сард богино хугацаагаар мэргэжилтнүүд монголд ажиллах боломжтой болж, эмнэлгийн ажилтнуудтай уулзаж ярилцан, эмнэлгээр тойролт хийн нөхцөл байдлыг магадлаж ажилласан. Гэвч, япон мэргэжилтнүүд монголд ажиллах хязгаар хориг бүрэн тавигдаагүй байсан тул монголд суурин ажиллаж байсан мэргэжилтний цуглуулсан мэдээллийг японд байгаа бусад мэргэжилтнүүдтэй солилцож, тэдний заавар, зөвлөгөөг монгол талд дамжуулж, хэрэгжүүлэх гэсэн арга хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан.
- 2021 оны 6-р сард 4 дэх шинэ захирал эмнэлэгт томилогдож, үүний хамт голлох удирдах ажилтнууд мөн солигдсон. Ингэсний улмаас төрийн өмчийн их сургуулийн эмнэлгийн үндсэн ойлголтууд, япон маягийн эмнэлгийн менежментийн тухай холбогдох хүмүүст нийтлэг ойлголтыг дахин танилцуулах шаардлагатай болсон. Үүссэн нөхцөл байдалд зохицуулан япон мэргэжилтнүүд холбогдох хүмүүст тайлбарлах, танилцуулах, санал солилцох замаар эмнэлгийн менежментийг тогтолцоонд дэмжлэг үзүүлсэн.
- 2021 оны 8-р сарын 13-нд БШУ-ны сайдын тушаалаар ЯМЭ нь АШУҮИС-ийн шууд харъяанд орсон. 2021 оны 9-р сарын 24-нд БШУЯ болон АШУҮИС-ийн хооронд гэрээ байгуулагдсан боловч агуулга учир дутагдалтай байсны улмаас 2021 оны 10-р сарын 5-нд БШУЯ болон ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газрын хооронд гэрээний

агуулгыг хянах, засвар өөрчлөлт оруулах тухай хурлаар авч хэлэлцэн, гэрээнд засвар өөрчлөлт оруулахаар болсон.

- Монголд улсын эмнэлгүүд санхүүгийн бие даасан тогтолцоонд шилжихтэй холбогдуулан санхүүгийн менежментийн системд шилжсэн. Энэ мэтчилэнгийн нөхцөл байдал дунд үйл ажиллагаагаа эхлүүлээд удаагүй ЯМЭ нь тогтвортой санхүүгийн менежментийн системийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байсан. Иймд, төслийн зүгээс орлого, зарлагын мониторингийн удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх, өдөр тутмын санхүүгийн менежментийн арга барилыг төлөвлөжүүлэх, өртөгт хийсэн дүн шинжилгээнд үндэслэн нарийвчилсан төсөв, орлого, зарлагын төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласан.
- 2021 оны 10-р сарын 1-нд 5 дах удаагийн ХЗХ-ны хурлыг зохион байгуулав. Хурлаар төслийн үйл ажиллагаа хэрэгжиж буй явц, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай хэлэлцэж ярилцсан. ХЗХ-ны хурлаар коронагийн цар тахлын нөлөөг харгалзан авч үзсэн хэлэлцүүлгийг өрнүүлэв. Үүний дүнд, монгол, япон хоёр тал төслийн хугацааг сунгаж, ТТМ-д өөрчлөлт оруулахаар санал нэгдэв. Мөн, ХЗХ-ны хуралд оролцсон төрийн захиргааны байгууллагын төлөөлөгч нар монголын ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалахын тулд ЯМЭ-ийн бүх талаар дэмжих талаар саналаа хэлж байв.
- ЯМЭ бол монголд анхны их сургуулийн эмнэлэг юм. Иймд, дээд боловсролын тухай хуулинд их сургуулийн эмнэлэг болон ЯМЭ-ийн хууль эрх зүйн статусыг бататгах нь зайлшгүй шаардлагатай. Хуулинд, ЯМЭ нь бусад бүх эрүүл мэндийн байгууллагын дээрх топ лавлах эмнэлэг байж, монголын ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад хувь нэмэр оруулахын тулд өндөр түвшний эмнэлзүй, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа хэрэгжүүлэн ажиллаж, үүний тулд төрөөс санхүүгийн дэмжлэг авах боломжтой гэсэн агуулга оруулахаар төлөвлөж байна. БШУЯ-наас хуулинд оруулах өөрчлөлтийн бэлтгэл ажлууд хийгдэж байгаа бөгөөд төслийн зүгээс японы их сургуулийн эмнэлгийн хуулийн тогтолцооны тухай холбогдох хүмүүст тайлбар, танилцуулга хийж ирсэн.

5.3 Төслийн эрсдлийн менежментийн үнэлгээ ба үр дүн

(1) Эрсдлийн менежментийн үр дүн

1) Монгол талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- ЯМЭ нь монголд анхны их сургуулийн эмнэлэг бөгөөд эмнэлзүй, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа гэсэн 3 гол үүргийг хүлээнэ. Мөн, япон маягийн эмнэлгийн менежментийг хэрэгжүүлж, монголд хамгийн дээд түвшний эмнэлэг болохыг зорьж байна. ЯМЭ-тэй холбоотой монгол талын холбогдох бүх хүмүүс дээр дурдсан нийтлэг ойлголттой болох нь маш чухал бөгөөд улмаар их сургуулийн эмнэлгийн хууль эрх зүйн статус ч мөн чухал юм. БШУЯ, АШУУИС, ЯМЭ-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг БШУЯ дээр байгуулагдсан. Төслийн зүгээс сургалтын эмнэлгийн концепц болон хууль

эрх зүйн байр суурийн тухай ажлын хэсэгт зөвлөмж өгсөн.

- 2021 оны 3-р сараас Эрүүл мэндийн албан даатгалын тогтолцоо бүх эмнэлэгт нэвтэрсэн. ЯМЭ нь даатгалын шинэ тогтолцоонд хамрагдан, даатгалаар орлогожиж байгаа хэдий ч үйл ажиллагаагаа эхлээд удаагүй тул тогтвортой үйл ажиллагаа явуулдаг болтол тодорхой хугацаа шаардлагатай гэж үзэж байна. Үүний тулд, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг зайлшгүй гэдэг талаар ЯМЭ, АШУҮИС, БШУЯ-нд тайлбарлан танилцуулсны дүнд БШУЯ ЯМЭ-т тотаци олгож байгаа. Улмаар, БШУ-ны сайд чиглэл өгч, төрийн өмчит бүх их, дээд сургуулийн багш, ажилтны эрүүл мэндийн үзлэгийг ЯМЭ дээр хийхээр болж, ЯМЭ болон их, дээд сургуулиуд хооронд эрүүл мэндийн үзлэг хийх гэрээ байгуулагдсан. Үүний дүнд, ЯМЭ-ийн өөрийн орлого өссөн. Дээрх арга хэмжээнүүдийн дүнд 2021 онд ЯМЭ ашигтай ажилласан.
- ЯМЭ нь ЭМ-ийн сайдын тушаалаар хэвтэн эмчлүүлэх тасгийн ихэнх хэсэг, эрчимт эмчилгээний тасаг, яаралтай тусламжийн тасагт коронагийн халдвартай өвчтөн хүлээж авч ажилласан. ЯМЭ-т хэвтэн эмчлүүлсэн коронагийн халдвартай өвчтнүүд нь хөнгөнөөс хүнд хүртэл янз бүрийн шинж тэмдэгтэй байсан. Корона халдвартай өвчтнийг хүлээн авахад тодорхой хэмжээний эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг төрөөс төлж, хариуцаж ажилласан эмнэлгийн ажилтнуудад ч тусгай олговор олгогдож байсан боловч төрөөс олгож байсан санхүүжилтээр эмнэлгийн үйл ажиллагааг зохистой явуулах боломжгүй нөхцөл байдалтай байсан. 2022 оны 3-р сараас хойш коронагийн халдвартай өвчтөн авахаа зогсоож, өнөөгийн байдлаар эмнэлгийн эрүүл менежментийг хэрэгжүүлэхийг зорьж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бодит өртгийг ухамсарлан, сар бүрийн төлөвлөгөө ба гүйцэтгэлийн харьцаа болон уян хатан орлого, зарлагын төлөвлөгөөг нягтлахад дэмжлэг үзүүлж ажилласан.

2) ЖАИКА-гаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газар нь ЯМЭ-ийн тогтмол хурлууд, АШУҮИС болон төрийн захиргааны байгууллагуудтай хийх хурал, уулзалтад оролцож, япон талыг төлөөлөн санал, хүсэлтээ танилцуулж ирсэн. Ялангуяа, ЯМЭ-ийн төсвийн дутагдалтай, хомсдолтой байдал үүсэхэд ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газар монголын засгийн газарт хандаж, төсвийн тодотгол хийх талаар санал илэрхийлсэн. Мөн, төрийн захиргааны байгууллагын удирдлага, БШУЯ-ны албаны холбогдох хүмүүс, АШУҮИС-ийн захирал зэрэг талуудтай уулзалт хийж, тус төслийн танилцуулга, хэрэгжиж буй явц, хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, монгол талаас шаардлагатай байгаа дэмжлэг зэргийн тухай тайлбарлан таниулж, хэлэлцэж ярилцаж ирсэн.
- ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газар нь БШУЯ-нд хандаж ЯМЭ-ийн хууль эрх зүйн статус болон төсвийн хангамжийн талаар тодруулах үүднээс засгийн газарт ажлын хэсэг байгуулж, хэлэлцэн, шийдвэрлэхийг санал болгож ажилласан. БШУЯ нь энэхүү саналыг хүлээн авч, БШУЯ, АШУҮИС, ЯМЭ-ийн төлөөллөөс бүрдэх ажлын хэсгийг

байгуулсан.

5.4 Сургамж ба зөвлөмж

Төслийн хүрээнд бий болсон сургамж ба зөвлөмжийг дор дурдав.

(1) Буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны төсөл (барилга барьж байгуулах)-тэй хийсэн зохицуулалт

Тус төсөл нь буцалтгүй тусламжийн хамтын ажиллагаа болох “Япон-Монгол сургалтын эмнэлгэ барьж байгуулах төсөл”-өөр баригдсан ЯМЭ дээр япон маягийн эмнэлгийн менежмент болон сайн чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон техникийн хамтын ажиллагааны төсөл юм. Гэвч, эмнэлгийн барилгыг хүлээлгэн өгөх явц удаашран хоцорч, амбулаторийг тусламж үйлчилгээг бодитоор эхлүүлсэн нь анх төлөвлөж байсан 2018 оны 7-р сараас 2019 оны 10-р сар болон хойшлогдож, энэ нь төслийн нийт үйл ажиллагаанд нөлөөлсөн. Үйл ажиллагааны тухайд, эмнэлгийн барилгын шинэчилсэн төлөвлөгөөг магадлахын тулд буцалтгүй тусламжийн төслийнхөнтэй уулзаж, ярилцан, зохицуулалт хийнгээ ажлаа урагшлуулах шаардлагатай болж, төслийн нэг дэх үед буцалтгүй тусламжийн төслийн багтай хамтарсан хурал хийхийг санал болгож, “Техникийн хамтын ажиллагааны төсөл болон буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны төслийн хамтарсан хурал”-ыг ЖАИКА-гийн төв оффист зохион байгуулсан.

Эмнэлгийн барилгын дотор орж ажиллах боломжтой болсон 2019 оны 4-р сараас хойш ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газар, АШУҮИС, ЯМЭ, буцалтгүй тусламжийн төслийн зөвлөх болон гүйцэтгэгч компани, төслийн мэргэжилтнүүд оролцсон хурлыг эмнэлгийн барилгын талбар дээр зохион байгуулж, барилгын ажлын явц, хийгдээгүй үлдсэн барилгын ажлыг магадлаж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүднээс сайжруулвал зохих асуудлуудын талаар хүсэлт тавьж, цаашид анхаарвал зохих асуудлын талаар үргэлжлүүлэн хэлэлцэж ярилцаж ирсэн.

Үүний дүнд, буцалтгүй тусламжийн төслийн талаас барилгын ажлын дундуур симуляци хийхэд санаа тавьж, эмнэлгийн тусламж үйлчилгээг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд бага боловч нөлөөлөхүйцээр өөрчлөн засварлаж, төслийн зүгээс ч байгууламжийн дизайн, концепцид нийцсэн эмнэлгийн менежментийг төлөвлөх боломжтой болсон. Энэ мэтчилэн, ЯМЭ-тэй холбоотой төслийн хязгаараас давсан харилцааг төслүүд хооронд, ялангуяа ЖАИКА-гийн төв оффисийнхны оролцоотойгоор, барилгын зураг төслийн шатнаас авахуулаад японы барилгын компанитай санал солилцож, нийтлэг ойлголт бий болгож ажилласан нь төслийн үйл ажиллагаанд ач холбогдолтой арга зам болсон гэж хэлж болно.

(2) Барилгын ажил удааширч хоцорсны нөлөөгөөр техникийн дэмжлэг үзүүлэхэд анхаарсан зүйлс

Буцалтгүй тусламжийн төслийн эмнэлгийн барилгын ажил удааширч, хоцрогдол гарснаар

тус төслийн эхэн үед төлөвлөж байсан техникийн дэмжлэгийн агуулга, хуваарьт өөрчлөлт оруулсан. Мөн, монгол талын төсвийн хангамж ч эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлэх хугацаа хойшилсноос төлөвлөж байсан төслийг бүрэн дүнгээр авах боломжгүй болж, шаардлагатай хүний нөөцийг ажилд авч чадалгүй, шаардлагатай бараа, материалын хангамж, нийлүүлэлт хийгдэхгүй байх гэх мэт нөхцөл байдал үүссэн.

Үүний улмаас, барилгыг хүлээлгэн өгч, монгол талын бэлтгэл хангагдсаны дараа эмнэлгийн үйл ажиллагааг шуурхай эхлүүлэх боломжийг хангахын тулд төслийн баг японд болон монголд зохион байгуулсан сургалтын дагуу дүрэм, журам, гарын авлага боловсруулах, симуляци хийх зэргээр дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтыг бүрдүүлэн ажиллаж ирсэн. 2019 оны 10-р сард ЯМЭ амбулаторийн үйлчилгээ үзүүлж эхлэн, өвчтөн төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг зохистой хэрэгжүүлж, хэвтэн эмчлүүлэх тасаг, хагалгааны тасаг, эрчимт эмчилгээний тасгийн үйл ажиллагааг ч хэвийн эхлүүлэхийн тулд мэргэжилтнийг тасралтгүй томилон ажиллуулж, талбар дээр заавар, зөвлөгөө өгөхийн хамт япон дах сургалтаар нөхөн гүйцээх зарчмаар техникийн дэмжлэг үзүүлж ирсэн. Мөн, коронагийн цар тахлын нөлөөгөөр хилээр зорчиход хязгаар, хориг тавигдсан хугацаанд онлаинаар заавар, зөвлөгөөг тасралтгүй өгч байв. Ингэснээр, амбулаторийн тусламж үйлчилгээг эмнэлзүй тасгууд, лаборатори, эмзүйн алба зэрэг нэгжүүд уялдаа холбоотой ажиллаж тусламж үйлчилгээ үзүүлэх удирдлага, зохион байгуулалт бүрдэж, өвчтөн төвтэй тусламж үйлчилгээний талаарх ойлголт, ухамсар дээшлэв. Мөн, хэвтэн эмчлүүлэх тасаг зэргийн тусламж үйлчилгээг эхлүүлэхтэй холбоотой ЯМЭ-ийн талын бэлтгэл ч хангагдсан. Энэ мэт гадны хүчин зүйлийн улмаас үйл ажиллагааг өөрчлөх шаардлагатай болсон тохиолдолд салбаруудын мэргэжилтнийг томилон ажиллуулах тов, хугацаанд зохицуулалт хийх зэргээр уян хатан арга хэмжээ авч, шаардлагатай бүх бэлтгэлийн хангалттай хийснээр техникийн дэмжлэгийн үр өгөөжийг дээд хэмжээгээр дээшлүүлэх боломжтой болдог.

(3) Эмнэлгийн үйл ажиллагааг шат дараатай эхлүүлэх талаарх зөвлөмж

2019 оны 6-р сарын 16-нд ЯМЭ-ийн барилга, тоног төхөөрөмжийг албан ёсоор монгол талд хүлээлгэн өгсөн. Гэвч, эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлэх монгол талын бэлтгэл ажил тийм ч хангалттай гэж хэлэхээргүй нөхцөл байдалтай байсан. Эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлэх, өөрөөр хэлбэл, эмнэлгийн тусламж үйлчилгээг эхлүүлэхэд эмнэлгийн үйл ажиллагааны гол цөм болох алба, нэгж, үйл ажиллагаа (өвчтний бүртгэл, санхүү, нябо, эм зүй, SPD, HIS, ариутгал, халваргүйжүүлэг, хог хаядал, дүрс оношилгоо, лаборатори, даавуун эдлэл, өвчтний хоол, байгууламжийн хэвийн ажиллагааг хангах гэх мэт) нь зохистойгоор хэрэгжиж байх нь чухал бөгөөд ажилтнуудыг ажилд авч, сурган дадлагажуулахад техникийн заавар, зөвлөгөө шаардлагатай байсан. Нөгөө талаар, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд гэнэт яаралтай тусламж үйлчилгээг ч мөн үзүүлдэг болох гэж зүтгэх нь бэрхшээлтэй, улмаар их эрсдэл дагуулна гэж үзсэн тул амбулаторийн дотрын тасгаас эхлэн бага багаар мэс засал, хэвтэн эмчлүүлэх, хагалгаа гэх мэтээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, эдгээрийг бүгдийг

зохих түвшинд чаддаг болсны дараа яаралтай тусламж үйлчилгээг эхлүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Ингэснээр, эхний шатанд амбулаторийн дотрын тасгийн үйл ажиллагаанаас эхлэлээ тавих нь зүйтэй гэсэн саналыг монгол талд тавьсан. Мөн, бэлтгэл ажлын тухайд эх үүсвэр тарамдахаас сэргийлэх үүднээс амбулаторийн дотрын тасгаас үйл ажиллагаагаа эхлүүлэхийн тулд хийгдэх ажлыг нэгтгэж, энэхүү үйл ажиллагаандаа төвлөрч ажиллахыг зөвлөж, монгол тал ч санал нийлсэн. Энэ мэтчилэн, эмнэлгийн талын бэлтгэл ажлын нөхцөл байдалтай уялдуулан боломжтой үйлчилгээний агуулгыг санал болгох, хүч хаян анхаарах ажил болон ямар ажлыг сонгох гэх мэтээр бэлтгэлийг үр өгөөжтэй хийхэд чиглэсэн дэмжлэг нь гадны хүчин зүйлийн нөлөөгөөр хязгаарлагдах төслийн үйл ажиллагаанд ч үр ашигтай гэж үзэж байна.

(4) Амбулаторийн тусламж үйлчилгээг эхлүүлэх болон эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэхэд чиглүүлэн боловсруулсан хяналтын хуудас ба хариуцах эзэн оноосон арга хэмжээ

Дээр дурдсанчлан, төслийн эхэнд төлөвлөж байсан 2019 оны 6-р сарын 17-нд өвчтөн хүлээж авах удирдлага, зохион байгуулалт, бэлтгэл хангалттай бус байсан тул амбулаторийн дотрын тасагт 2019 оны 10-р сарын 1-нээс бодитоор үйлчилгээ үзүүлж эхлэсэн.

Амбулаторийн тусламж үйлчилгээний бэлтгэлийг зохих ёсоор хангахын тулд төслийн зүгээс амбулаторийн тусламж үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлын хяналтын хуудсыг боловсруулсан. Хяналтын хуудас нь 1/ Эмнэлгийн нийт менежментийн концепц, 2/ Бүтэц, хороод болон хурал, 3/ Захиргааны үйл ажиллагаа (бүртгэл, тооцоо, HIS, байгууламжийн менежмент, ариутгал), 4/ Чанар, аюулгүй байдлын менежмент, 5/ Эмнэлзүй, 6/ Сувилахуй гэсэн ерөнхий хэсгүүдээс бүрдэж, нийт 144 зүйлтэй байв. Энэхүү хяналтын хуудсын магадлах зүйлийн дагуу үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлын явцыг монгол талтай хамтран магадлах хурлыг 7 хоног бүрийн Пүрэв гаригт зохион байгуулж байв. Үүний дүнд, төлөвлөсөн ёсоор 2019 оны 10-р сарын 1-нд Амбулаторийн үйлчилгээг үзүүлж эхлэсэн. Ялангуяа, ЯМЭ-ийн холбогдох хүмүүсийн дотор эмнэлгийг шинээр нээн ажиллуулж байсан туршлагатай хүн бараг байхгүй байсан тул мэргэжитнүүдийн туршлагад үндэслэн маш нарийвчилсан хяналтын хуудас боловсруулж, хэрэгжиж буй явцыг магадлахын тулд хурал зохион байгуулж, хуудсын дагуух үйл явцын удирдлага, хяналт нь амбулаторийн үйлчилгээг эхлүүлэхэд маш үр өгөөжтэй арга хэмжээ байсан гэж үзэж байна.

Нөгөөтэйгүүр, амбулаторийн үйлчилгээг эхлүүлсний дараа бусад үйлчилгээг өргөжүүлэхэд шаардлагатай шинэ хяналтын хуудсыг боловсруулах шаардлагатай болсон. Эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнөхтэй харьцуулбал ЯМЭ-ийнхэн тодорхой хэмжээнл туршлагаай болсон байсан учраас шинээр боловсруулах хяналтын хуудсыг монгол тал бие даан хийхэд анхаарсан. Энэ нь цаашид, мөн адил нөхцөл байдалд бие даан асуудлыг шийдвэрлэх чадавхыг суулгахад анхаарсан дэмжлэг байсан юм. Үүний дүнд, ЯМЭ нэгж тус

бүрээр шаардлагатай ажлуудаа жагсаан нэгтгэж, нийт 200 гаруй зүйл бүхий хяналтын хуудсыг боловсруулж, түүнийхээ дагуу бэлтгэлээ хангаж ажилласан. Төслийн баг нь өмнөхийн мөн нэгэн адил хурал уулзалтаар бэлтгэл хангах үйл явцыг магадлаж, үйлчилгээг өргөжүүлэхэд заавар, зөвлөгөө өгч, үүний дүнд 2020 оны 9-р сард дотрын хэвтэн эмчлүүлэх тасаг, эрчимт эмчилгээний тасаг, мөн оны 11-р сард мэс заслын хэвтэн эмчлүүлэх тасаг, хагалгааны тасаг болон яаралтай тусламжийн тасгийн үйлчилгээг эхлүүлж чадсан юм. Энэ мэтчилэн, ЯМЭ-ийн талын санал, санаачилгыг хүндэтгэн, явцыг ажиглангаа зохих зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллах арга барил нь ЯМЭ-ийн өөрийн асуудал шийдвэрлэх чадавхыг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон гэж дүгнэж байна. Энэхүү арга барил нь бусад төсөлд ч үр дүнгээ өгнө.

(5) Шинэ хэлбэрийн корона вирусн нөлөөгөөр хилээр зорчиход тавигдсан хориг ба онлайн системийн ашиглалт

2019 оны эцсээр тархсан корона вирусн нөлөөгөөр мэргэжилтнүүд монголд ажиллах, монголоос японд суралцах үйл явц хүндрэлтэй болсон. Үүний улмаас онлайн систем ашиглан хурал, уулзалт, мониторинг, технологи шижлүүлэлтийг хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Тухайлбал, доор дурдсан хурал, уулзалтыг зохион байгуулсан.

- Эмнэлгийн үйлчилгээг эхлүүлсний дараа үйлчилгээг өргөжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлын явцыг магадлах хурал, уулзалтын зохион байгуулсан (ЯМЭ-ийн удирдлага, ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газар, төслийн баг)
- Салбар чиглэл тус бүрээр хорооны хурлыг зохион байгуулсан (захиргаа, SPD, IT, халдвар хамгаалал, сувилахуй, санхүү)
- Онлайнар эмнэлгийн үйл ажиллагаатай танилцсан (ЯМЭ-ийн үйл ажиллагааны нөхцөл байдал, үйлчилгээг өргөжүүлэх бэлтгэл ажлын явцыг магадлахын тулд онлайн хэлбэрээр танилцсан)
- АШУҮИС-ийн захирал, дэд захиралтай хуралдсан (төслийн чиглэл баримтлалыг магадлах, цаашдын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой санал солилцох зорилгоор зохион байгуулсан)
- ЯМЭ-ийн захиралтай тогтмол хугацаанд хуралдаж байсан (бүх тусламж үйлчилгээг эхлүүлсний дараах эмнэлгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг асуудлаар санал солилцох зорилгоор зохион байгуулсан)
- ЖАИКА-тай хийдэг хурал, уулзалт (дээрхийн адил ЖАИКА-гийн төв оффис, ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газар, төслийн баг)
- Коронагийн үеийн арга хэмжээний талаарх алсын зайн семинар зохион байгуулсан
- Онлайнар эмнэлэгтэй танилцаж, мониторинг хийж (вэб камер зэргийг ашиглан эмнэлгийн доторх нөхцөл байдалтай бодит цагаар японтой холбож, дэлгэцээр дамжуулан мониторинг хийж, заавар зөвлөгөө өгсөн)

Талбар дээрх бодит заавар, зөвлөгөө болон ажлын байран дээрх сургалтын хэлбэрээр

дамжуулан технологи шилжүүлэх зэрэг үйл ажиллагаатай харьцуулбал хязгаарлагдмал хэдий ч хурал уулзалт зэргийг хийхийн өмнө хэлэлцэх асуудал, материал зэргийг урьдчилан бэлдэхийн зэрэгцээ тулгамдаж буй асуудлыг урьдчилан тодорхойлуулах замаар монгол талыг урьдчилан суралцахуй, урьдчилан бэлтгэлийг хангахад чиглүүлж, тулгамдаж буй асуудлын талаар тайлан бичүүлж, түүний дагуу зохих comment өгч зөвлөх гэсэн хэлбэрээр зохион байгуулж байсан нь онлайн хэлбэрийн саад, хязгаарын арилгахад ач холбогдолтой байсан. Хилээр зорчих хязгаар, хориг зөөлөрсний дараа ч монгол дах технологи шилжүүлэх үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй болгох үүднээс онлайн хэлбэрийн идэвхтэй ашигласан.

(6) Холбогдох яам, төрийн захиргааны байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах, татан оролцуулах

ЯМЭ-ийг харъяалдаг төрийн захиргааны байгууллагын хувьд, 2019 оны 1-р сарын Засгийн газрын хуралдааны тогтоолоор БШУЯ-наас ЭМЯ-нд шилжсэн боловч 2020 оны 3-р сард дахин БШУЯ-ны харъяанд шилжсэн. Улмаар 2022 оны 2-р сард БШУЯ-наас АШУҮИС-ийн харъяанд шилжсэн. Нөгөөтэйгүүр, 2019 оны 5-р сард хамгийн эхний эмнэлгийн захирал томилогдсоноос хойш 3 орчим жилийн хугацаанд олон дахин солигдож, өнөөгийн захирал нь 4 дэх захирал юм. Эмнэлгийн захирал солигдохоор түүнээс доошх хүний нөөцийн халаа, сэлгээ хийгдэх зэргээр ЯМЭ-ийн өөрийн удирдлага, зохион байгуулалт болон эмнэлэгт чиглэсэн дэмжлэгийн тогтолцоог тухай бүр авч үзэх шаардлагатай болж байсан. АШУҮИС-ийн хүний нөөцийн хувьд ч 2020 оны 6-р сарын сонгуулийн нөлөөгөөр захирал, дэд захирал нар бүрэлдхүүнээрээ солигдож байсан.

Үүний улмаас тухай бүр төрийн өмчит их сургуулийн эмнэлэг, япон маягийн эмнэлгийн менежмент гэх мэт үндсэн концепцийн тухай нийтлэг ойлголтыг хангах шаардлага урган гарч байсан тул төслийн зүгээс холбогдох талуудад таницуулга, тайлбар хийх, уулзалт хийх зэргээр шинээр томилогдсон эмнэлгийн захирал төвтэй эмнэлгийн менежментийг бүрдүүлэхээр ажиллаж ирсэн.

ЯМЭ нь 2019 оны 1-р сард БШУЯ-наас ЭМЯ-нд шилжсэн боловч сургалтын эмнэлгийнхээ хувьд төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалт, төрийн стратегийн хүрээнд хийх эрдэм шинжилгээ, судалгаа, чанарын баталгаатай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд ЭМЯ-ны дэмжлэг зайлшгүй юм. Мөн, ЯМЭ-ийн үйл ажиллагааг тогтворжтол төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг ч зайлшгүй юм. Иймд, 4 дэх удаагийн ХЗХ-ны хуралд эдгээр холбогдох төрийн захиргааны байгууллагуудын төлөөллийг урьж оролцуулан, уялдаа холбоотой хамтран ажиллах болон дэмжлэг зайлшгүй болох тухай танилцуулсан. Хурлын үеэр, төрийн захиргааны байгууллагуудын төлөөллүүд монголын эрүүл мэндийн салбарын инновацийг бодитоор хэрэгжүүлэх, ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалан сайжруулахын төлөө харилцан хамтран ажиллаж, ЯМЭ-ийг дэмжих тухай, мөн, үүний тулд холбогдох байгууллагууд нягт харилцахын ач холбогдлын талаар санал бодлоо хэлцгээж, үүн дээр хуралд оролцогчид санал нэгдсэн. Мөн, шаардлагатай бол БШУЯ, ЭМЯ-ны сайд нар, төрийн

нарийн бичгийн дарга, газрын даргын түвшний талуудад уялдаа холбоотой хамтын ажиллагаа, дэмжлэгийн хэрэгцээ шаардлага, их сургуулийн эмнэлэгтэй холбоотой хууль эр зүйн орчныг бүрдүүлэх тухай танилцуулж, ойлгуулахаар ажилласан. Үр дүнд нь, төрөөс тотаци олгохоор болж, дээд боловсролын тухай хуулинд оруулах өөрчлөлтөл их сургуулийн эмнэлгийн талаар тусгахаар болсон. ЯМЭ нь монголд анхы сургалтын эмнэлгийн үүргийг гүйцэтгэн ажиллахын тулд бүх төрийн захиргааны байгууллагуудын татан оролцуулж ажиллах зайлшгүй шаардлагатай.

(7) Хамтарсан удирдлага, зохион байгуулалт бүхий төслийн үйл ажиллагааны менежмент

Тус төслийн хэрэгжүүлэхэд Токүшимагийн ИС, Эхимэгийн ИС, KRC гэсэн 3 талын хамтарсан удирдлага, зохион байгуулалтыг байгуулсан юм. Энэ нь, 1/ ТИС нь, АШУУИС болон монголын эрүүл мэнд, халамжийн салбарын хүний нөөцийг бэлдэхэд урт хугацааны туршид дэмжлэг үзүүлж ирсэн, мөн, японы ИС дотор монголоос хамгийн их оюутан хүлээн авч сургадаг сургууль тул (өнөөгийн байдлаар нийт 60 гаруй оюутан) монголын эмнэлгийн тусламж үйлчилгээ, халамжийн салбартай холбоотой туршлага, мэдлэг арвин, мөн салбарт чухал үүрэг гүйцэтгэдэг хүний нөөцтэй сайн харилцаатай, 2/ ЭИС нь, Зүрх хамгаалах төсөл¹⁵ болон клиник сургалт, дадлагын тогтолцоонд түшиглэсэн сургалтыг хэрэгжүүлж монгол болон АШУУИС-тай харилцаа тогтоож ирсэн, дээр нь 3/ KRC нь монгол болон өөр олон оронд техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлж байсан, менежментийн өндөр ур чадвартай, ийм гурван тал өөрсдийн давуу талыг ашигласнаар харилцан үр нөлөө дээшилж, тус төслийн үр өгөөжийг хамгийн их хэмжээгээр бодит болгох боломжтой гэж үзсэнийх юм.

Хамтарсан удирдлага, зохион байгуулалтын бүрэлдэхүүн нь Токүшима, Эхимэ, Токиод төвлөрч ажилладаг тул 3 талын харилцаа холбоог чухалчлах үүднээс онлаинаар хурал, уулзалтыг тогтмол зохион байгуулж, төслийн явц, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ложистик дэмжлэгийн агуулгыг магадлах зэрэг асуудлаар ярилцаж хэлэлцэн, төслийн үйл ажиллагааг саадгүй зохион байгуулж хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Коронагийн нөлөөнд орохоос өмнө шаардлагатай бол 3 тал Токио, Токүшима-д цугларан уулзаж, хурал уулзалт зохион байгуулж ирсэн. Цуглуулсан мэдээлэл, материал, тайлан зэргийг төслийн дундын мэдээллийн бааз болох Dropbox-т цуглуулж, 3 тал хэзээ ч үзэж болох зохион байгуулалтыг хийсэн. Мөн, коронагаас хойш 3 тал онлаинаар хуралдаж, төслийн явцыг магадлаж, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох зэргээр ажилласан.

(8) Үр дүнтэй технологи шилжүүлэлт ба оролцоо

Дээр дурдсанчлан, төсөл эхэлснээс хойш монгол талын бэлтгэл ажил (төсөв, хүний нөөц, бараа материалын хангамж) хангалтгүй, хүний нөөцийн халаа сэлгээнээс үүдэлтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтад гарсан өөрчлөлт гэх мэт нөхцөл байдал олон

¹⁵ ТББ-ийн үйл ажиллагаа бөгөөд 2001 оноос эхлэсэн, хүүхдийн зүрх, судасны эмчилгээний төсөл, өнөөг хүртэл 2000 гаруй хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн, 350 гаруй хүүхдэд катетерийн эмчилгээ хийсэн

үүсч байв. Үүний улмаас төслийн багийн технологи шилжүүлэлтийн агуулга, оролцоог ч монгол талын гүйцэтгэлд нийцүүлэн уян хатан бөгөөд үр өгөөжтэй хэрэгжүүлэх шаардлагатай байсан.

Жишээлбэл, буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн дүрс оношилгооны төхөөрөмжийн ашиглалттай холбоотойгоор өвчтний шинж тэмдгээс шалтгаалан олон янзаар дүрс авах аргын талаар технологи шилжүүлэх шаардлагатай нь тодорхой болсон. Үүний тулд, дүрс оношилгооны мэргэжилтнийг нэмж ажиллуулахын зэрэгцээ үйлдвэрлэгчийн сургалтыг монголд зохион байгуулсан.

Мөн, эмнэлгийн санхүүгийн нөхцөл байдлын тухайд, өнөөг хүртэл япон дах сургалтад хамруулан зааж, зөвлөж ирсэн ажилтнууд нь эмнэлгийн захирал солигдохоор ажлаасаа гарах, санхүү хариуцан ажиллаж байгаа ажилтан нь өмнө нь эмнэлэгт ажиллаж байсан туршлагагүй байх зэрэг шалтгааны улмаас БШУЯ, ЭМЯ, СЯ-нд хандаж төсвийн тооцоо, өргөдлөө мэдүүлж чаддаггүй, яамны санхүүгийн хариуцлагатанд оновчтой, зөв тайлбарлаж чаддаггүй гэх мэт байдал ил болсон. Иймд, эмнэлгийн санхүүгийн удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхийн тулд мэргэжилтнийг нэмэлтээр оруулсан. Нөгөө талаар, орон нутгийн ажилтнуудын хувьд ч HIS хөгжүүлэх, санхүүгийн тал дээр дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлагын үүднээс HIS-г сайн мэддэг эмч, санхүүгийн аудитор бөгөөд монголын санхүү, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог сайн мэдэх, туршлагатай хүмүүсийг монголд авч ажиллуулсан. Мөн, их сургуулийн эмнэлгийн эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс хуульчтай гэрээ байгуулж ажилласан. Энэ мэтчилэн нөхцөл байдалтай уялдуулан, шаардлагатай шилжүүлэх технологийг тодорхойлж, түүнд дэмжлэг үзүүлэх мэргэжилтэн, орон нутгийн ажилтныг оролцуулж ажиллуулах зэргээр уян хатан арга хэмжээ авч ажиллах нь дараа дараагийн оролцоо, үр өгөөжийг бий болгох үүднээс маш үр ашиг, үр нөлөөтэй арга барил байв.

5.5 Гүйцэтгэл

Тус төслийн хүрээнд Япон Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ болон ЖАИКА-гий холбогдох хүмүүс төслийн зорилгыг биелүүлэхэд дор дурдсан үүрэг, оролцоотой байж хувь нэмэр оруулж байв.

1) Япон Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ

ЯМЭ-тэй хийдэг тогтмол хуралд оролцож, япон талыг төлөөлөн санал, хүсэлтээ илэрхийлж ирсэн. Мөн, ЯМЭ-ийн төсвийн хангамжийн асуудал дээр Монголын Сангийн яам зэрэгт хандаж улсын төсвийг нэмэгдүүлэх талаар санал тавьж, түүний дүнд хөрөнгө оруулалтын төсөв олгож байлаа. Мөн, Эрүүл мэндийн сайд зэрэг талуудад хандаж ЯМЭ-ийг дэмжиж, хамтран ажиллах тухай саналаа илэрхийлж байв.

2) ЖАИКА

“5.3”-т дурдсанчлан ЖАИКА-гийн Монгол дах төлөөлөгчийн газар нь Монголын Засгийн газарт хандаж төсвийн тодотголтой холбоотой саналаа илэрхийлэх зэргээр хамтран ажиллагч байгууллага болон бусад төрийн байгууллагуудын холбогдох хүмүүстэй уулзахдаа монголд төслийн хэрэгжилтийг удирдлага, хяналтаар хангаж ажиллаж ирсэн. Мөн, ЖАИКА-гийн төв оффис нь японоос төслийн хэрэгжилтийг удирдлага, хяналтаар хангаж, чиглэл өгч байсан ба төслийн үр өгөөжийг дээшлүүлэх, дээд түвшинд төслийн зорилтыг биелүүлэх үүднээс зохистой хугацаанд оролцоо (хүн/сар, төсөв гэх мэт)-г өргөжүүлэх болон төсөл хэрэгцүүлэх хугацааны талаар авч үзэж, анхаарсны дүнд төслийн зорилгыг хангаж чадсан.

6. Тэргүүлэх зорилтыг биелүүлэхийн тулд

6.1 Тэргүүлэх зорилтыг биелүүлэх боломж

Тус төслийн тэргүүлэх зорилт нь “ЯМЭ нь нэгдсэн эмнэлэг, сургалтын эмнэлгийнхээ хувьд өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах” юм. Үүний тулд 2017 оноос эхлэн “ЯМЭ нь технологийн түвшин, чанарын хувьд өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхүйц удирдлага, зохион байгуулалтыг бий болгох”-ыг төслийн зорилт болгон үйл ажиллагаа хэрэгжүүлж ирсэн ба төсөл өндөрлөхөд доорх зурган дээр илэрхийлсэн төслийн зорилтод хүрнэ гэж үзэж байна.



Эх сурвалж: Төслийн баг боловсруулав

Зураг 4 Тэргүүлэх зорилтод хүрэх төсөөллийн зураглал

Дээд зурагт үзүүлсэнчлэн ЯМЭ нь их сургуулийн эмнэлэг (нэгдсэн эмнэлэг, сургалтын эмнэлэг) болохынхоо хувьд “эмнэлзүй (клиник)”, “сургалт, “эрдэм шинжилгээ, судалгаа” гэсэн 3 гол баганыг төгөлдөржүүлэх шаардлагатай боловч нэг эрчээр энэ бүгдийг төлөвшүүлж, төгөлдөржүүлэх нь тун бэрхшээлтэй юм. Уг төслийн хүрээнд цэнхэр өнгийн тасархай зураасаар тэмдэглэсэн хэсэгтэй холбоотой үр дүнд хүрсэн боловч тэргүүлэх зорилтод хүрэхийн тулд шараар болон тасархай шугамаар хүрээлсэн хэсэгтэй холбоотой ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай.

Тухайлбал доорх арга хэмжээнүүдийг дурдаж болно.

- 1) Тогтвортой эмнэлгийн үйл ажиллагааг хангах санхүүгийн эх үүсвэр
 - Өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, хагалгаа хийх (ашиг орлогыг бүрдүүлэх)

- Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийг сайжруулахад хувь нэмэр оруулахуйц чанартай эмнэл зүйн сургалт, судалгааг төрөөс дэмжих шаардлагатай.
(Япон улсад их сургуулийн эмнэлгийн үйл ажиллагааны зардлын 20 орчим хувийг төр хариуцдаг. Мөн тусгай үйл ажиллагаат эмнэлгийн статустай болгон бусад ЭМБ-аас эмчилгээ оношилгооны үнэ тарифыг өндөр тогтоосон)
- Эмнэлгийн зохистой хүчин чадалд үндэслэн асуудлыг авч үзэх
(үйл ажиллагаанаас гадна сургалтын эмнэлгийн чиг үүргийг бэхжүүлэх)

2) Өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавх, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх

- Монгол улсад эмчлэх боломжгүй 26-н өвчнийг эмчилдэг болоход чиглэсэн үйл ажиллагаа
- Зүрх, тархи мэдрэлийн өвчнийг эмчлэхэд чиглэсэн үйл ажиллагаа⇒ ялангуяа Монгол улсын зүүн бүсийн зүрх судасны оношилгооны төв болох байр суурийг бэхжүүлэх
- Цаашид бүс нутгийн яаралтай тусламжийн төвийн үүргийг гүйцэтгэх
- Хувийн эмнэлгүүдээс ялгарах (өндөр чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээг хямд тарифаар үзүүлэх).

3) Сургалтын эмнэлгийнхээ хувьд төлөвшиж бэхжих (монголд анхы сургалтын эмнэлгийн хувьд өндөр итгэл, найдвар хүлээж байгаа)

- Хууль эрх зүйн, статус (дээд боловсролын тухай хуульд яаралтай нэмэлт өөрчлөлт оруулах)
- АШУҮИС-ийн хэрэгжүүлж буй сайн чанарын эмнэл зүйн сургалт (сургалтын хөтөлбөрийг сайжруулан шинэчлэх гэх мэтийг мөн багтаах)
- ЯМЭ-ийг цөм болгон төгсөлтийн өмнөх ба төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бэхжүүлэх

4) Эмнэлзүйн/клиник судалгааг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх

- Глобал түвшинд эмнэл зүйн судалгаа хийх боломжтой системийг бий болгохыг зорих
- Дэлхийн банкны эрүүл мэндийн технологийн шилдэг шагнал авах болон БШУЯ-ны шинжлэх ухааныг дэмжих сангаас дэмжлэг авахыг зорих
- Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн эрдмийн ажил хийх, танилцуулахыг зорих

Дээрх зорилгод хүрэхийн тулд доорх арга зам байж болно.

- ЖАИКА-гийн техникийн хамтын ажиллагааны төсөл, мэргэжилтэн томилж ажиллуулах, урт хугацааны судлаач хүлээн авах, Хилийн чанад дах залуу сайн дурын гишүүн томилж ажиллуулах
- Эмнэлзүй болон эрдэм шинжилгээ, судалгааны чадавхыг дээшлүүлэхийн тулд их сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээ зэрэг арга замыг ашиглах

6.2 Тэргүүлэх зорилтод хүрэхийн тулд монгол талын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Тэргүүлэх зорилтод хүрэхийг зорьж сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны үйл үүргийг бэхжүүлэхийн тулд АШУҮИС-тай уялдаатай хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай. ЯМЭ болон АШУҮИС-ийн хооронд байнга санал солилцож, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай. Жишээлбэл, яаралтай тусламж үйлчилгээний тухайд ЯМЭ-ийн ажилтан нь АУС-ийн тэнхимийн багш болж томилогдон, хамтарч ажиллаж байна. Энэ мэтчилэнгийн хамтарч ажиллах тогтолцоог бусад эмнэлзүйн салбар, чиглэлд ч бий болгох нь зүйтэй.

Өнөөгийн хүний нөөцийн төлөвлөлт, орон тоо нь эхний шатны зорилгыг хангахад шаардлагатай тоонд үндэслэсэн. Иймд, цаашид сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлэхэд чиглэн шинээр хүний нөөц бүрдүүлэх шаардлагатай болж болзошгүй (сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд менежмент хийхэд хүн хүч шаардлагатай) Иймд, тэргүүлэх зорилтод хүрэхийн тулд зохих хүний нөөцөөр хангах шаардлагатай. Нөгөө талаар, эмнэлгийн үүрэг, үйл ажиллагааг тэлснээр түүнд зохихуйц мэдээллийн технологийн албаны хүний нөөцийн хангамж зайлшгүй юм. Гэвч мэдээллийн технологийн салбарынхан өндөр дүнгээр цалинждаг тул бэрхшээл тулгарч болзошгүй тул хэсэгтээ дотооддоо хүний нөөц бүрдүүлснээс туслан гүйцэтгэгч хувийн хэвшил, мэргэжилтэнтэй гэрээлж, тогтмол хугацаанд ЯМЭ-ийн ажлыг гүйцэтгүүлэх зэрэг арга зам эрэлхийлэх нь зүйтэй (ялангуяа сүлжээний мэргэжилтэн).

ЯМЭ нь өнөөг хүртэл төслийн хүрээнд технологи шилжүүлж авсан ажилтнуудын тогтвор суурьшил үнэхээр муу, энэ бүрт технологи шилжүүлэх үйл ажиллагааг тэгээс эхлэх шаардлага гарч байсан. Иймд, ажлын байрны орчныг сайжруулах зэргээр ажилтнуудын тогтвор суурьшлыг хангаж ажиллах зайлшгүй шаардлагатай. Мөн, эмнэлэгт гүйцэтгэж буй ажил үүрэгтэй холбоотой мэдлэг, мэдээллийг хувь хүнд төвлөрүүлэхгүй байхад анхаарч нийт эмнэлгийн хэмжээнд болон алба, тасаг, нэгжүүд дүрэм журмын дагуу системтэйгээр ажил үүргээ гүйцэтгэхүйц удирдлага, зохион байгуулалты бий болгож, эмнэлгийн дотоодын сургалтын тогтолцоог бүрдүүлж, мэдээллийг бусдадаа хуваалцаж, түгээхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

6.3 Монгол талд хүргэх зөвлөмж

Тэргүүлэх зорилтод хүрэхийн тулд монгол талд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахыг санал болгож байна.

- ЯМЭ-ийн зорих зүйл бол нэгдүгээр шатлалын эмнэлэг болон лавлагаа шатлалын эмнэлгийн дээр байх түвшний эмнэлэг болох явдал бөгөөд үүний тулд их сургуулийн эмнэлэг (нэгдсэн эмнэлэг, сургалтын эмнэлэг) болохынхоо хувьд өндөр түвшний үүрэг, үйл ажиллагааг төгөлдөржүүлэхийг зорьж, “эмнэлзүй (клиник)”, “сургалт, “эрдэм шинжилгээ, судалгаа” гэсэн 3 гол баганыг төлөвшүүлэн, төгөлдөржүүлэх шаардлагатай

хэдий ч үүнийг нэр эрчээр хэрэгжүүлэх нь ихээхэн бэрхшээлтэй тул шат дараатайгаар хэрэгжүүлэх нь маш чухал.

Тэргүүлэх зорилтод хүрэхийн тулд дэвшүүлэх тодорхой саналуудыг дор дурдав.

- Тогтвортой эмнэлгийн үйл ажиллагааг хангах санхүүгийн эх үүсвэр
 - Ашиг, орлогтой ажиллахын тулд Их орлого олохын тулд өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, хагалгаа хийхдээ эрүүл мэндийн даатгалын ашиглах
 - Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийг сайжруулахад хувь нэмэр оруулахуйц чанартай эмнэл зүйн сургалт, судалгааг төрөөс дэмжих шаардлагатай
- Хүний нөөц, бараа материалын хангамж
 - Өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх, сургалт, судалгаа хийх үүрэг, үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж, бараа материалаар хангах (төсвийн хангамж мөн багтана)
 - Байгууламж, тоног төхөөрөмж, хэрэгслийн хэвийн ажиллагааг хангахын тулд хангалттай төсвөөр хангах, зохистойгоор менежмент хийх
- Сургалтын эмнэлэг болохынхоо хувьд менежментийг төлөвшүүлэх
 - Монголд анхны сургалтын эмнэлэг болохынхоо хувьд хууль, эрх зүйн статустай болох (дээд боловсролын тухай хуулинд өөрчлөлт оруулах)
 - АШУҮИС-тай уялдаатай хамтран ажиллаж, эмнэлзүйн сургалт зохион байгуулах удирдлага, зохион байгуулалтыг бий болгох (ЯМЭ-ийг цөм болгон төгсөлтийн өмнөх ба төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог бэхжүүлэх)
 - АШУҮИС-ийн хэрэгжүүлж буй сайн чанарын эмнэл зүйн сургалт (сургалтын хөтөлбөрийг сайжруулан шинэчлэх гэх мэтийг мөн багтаах)
 - Сайн чанартай эмнэлзүйн сургалтыг зохион байгуулахын тулд сургалтын хөтөлбөрийг өөрчлөн шинэчлэх
- Клиник судалгааны удирдлага, зохион байгуулалтыг бий болгох
 - Глобал түвшинд эмнэл зүйн судалгаа хийх боломжтой судалгааны нэгж байгуулах
 - Их сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээг ашиглан эрдэм шинжилгээ, судалгааны чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа
- Өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа
 - Их сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээг ашиглан эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа
 - Гадаадад суралцахыг дэмжсэнээр эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх
- Их сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хийгдэх инвазив ажилбар үйлдэхтэй холбоотой арга хэмжээ
 - Гадаадын иргэн эмч эмнэлзүйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой зөвшөөрөл
 - Эмнэлгийн тусламж үйлчилгээний осол гарсан тохиолдолд хариуцлага хүлээх тогтолцооны талаар тодохой болгох

6.4 Төсөл өндөрлөхөөс хэрэгжилтийн дараах үнэлгээ хүртэлх мониторингийн төлөвлөлт

Тэргүүлэх зорилтод хүрэх, нөлөөлөл болон тогтвортой байдлыг хангахын тулд төслийн зүгээс ЖАИКА-д төсөл хэрэгжиж өндөрлөсний дараа доорх асуудлаар мониторинг болон хэрэгжилтийн мөрөөр анхаарал тавьж ажиллахыг санал болгож байна.

1) Хэрэгжилтийн мөрөөр тавих анхаарал

Тэргүүлэх зорилтод дурдсанчлан их сургуулийн эмнэлэг болж төлөвшихийн тулд ЯМЭ нь “эмнэлзүй (клиник)”, “сургалт, “эрдэм шинжилгээ, судалгаа” гэсэн 3 гол үүргийг гүйцэтгэх шаардлагатай. Тухайлбал, монголд өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, эрүүл мэндийн байгууллагын ажилтныг сурган бэлдэж, улмаар монголын эрүүл мэндийн салбарт оруулах хувь нэмэр болгож эрдэм шинжилгээ, судалгаа хийх шаардлагатай. Гэвч, энэ салбарт туршлага нимгэн монгол талын хувьд зөвхөн өөрсдөөс шалтгаалах хүчин чармайлт гаргасан ч биелүүлэхэд бэрхшээлтэй юм. Иймд, япон талаас доорх техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэхийг санал болгож байна.

Тэргүүлэх зорилт:

ЯМЭ нь өөрсдийн боловсруулсан урт ба богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн эмнэлгийн менежментийг хэрэгжүүлдэг, сургалтын эмнэлгийн хувьд үүргээ гүйцэтгэдэг байх

Төслийн зорилт:

ЯМЭ нь тогтвортой үйл ажиллагаа явуулж, сургалтын эмнэлэг болохынхоо хувьд гүйцэтгэх үүрэг, ажиллагаа нь төлөвшсөн байх

Үр дүн:

Үр дүн 1: Сургалтын эмнэлгийнхээ хувьд үүрэг, ажиллагаа гүйцэтгэх чадавхийг бэхжүүлэх

Үр дүн 2: Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааг хамарсан ЯМЭ-ийн урт ба богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай менежментийн чадавхыг бэхжүүлэх

Үр дүн 3: ЯМЭ-ийн урт ба богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд эмнэлгийн тусламж үйлчилгээний нэгжүүдийн үүрэг, ажиллагааг бэхжүүлэх

2) Мониторинг

Тэргүүлэх зорилтод хүрэх үйл явцыг магадлахын тулд доор дурдах мониторингийг хэрэгжүүлэхийг ЖАИКА-д санал болгож байна. Сургалтыг хичээлийн 1 жилээр тооцож явуулдаг, АШУҮИС болон ЯМЭ-ийн үйл ажиллагаа ч мөн адил 1 жилээр төлөвлөгддөг тул зарчмын хувьд мониторингийг 1 жилд 1 удаа хийх. Мөн, сургалтын эмнэлэг, монголын хамгийн дээд түвшний эрүүл мэндийн байгууллага болохынхоо хувьд, мөн Монгол Улсын

эрүүл мэндийг хамгаалан сайжруулах үүргийг хүлээсэн тул доорх шалгуур үзүүлэлтийг магадлах. Хэрэгжүүлэхдээ ЯМЭ-т мониторингийн хүснэгтийг илгээж, буцааж хурааж авах аргаар хэрэгжүүлнэ. Мөн, шаардлагатай бол холбогдох талуудаас ярилцлага судалгаа авна.

- ЯМЭ дээр зохион байгуулсан төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан резидент эмчийн тоо (мэргэшсэн салбар, хугацаа гэх мэтийг мөн хамруулна)
- ЯМЭ дээрх өндөр түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээний тоо (зүрх, тархины өвчин, хорт хавдрын эмчилгээ гэх мэт, өвчнөөр ангилах)
- ЯМЭ дээрх клиник судалгаа, эрдэм шинжилгээний/эрдмийн ажлын тоо (монголд эмчлэгдэх боломжгүй 26 өвчнийг хамруулна)
- ЯМЭ-ийн зохион байгуулсан монголын холбогдох талуудад зориулсан воркшоп, семинар зэргийн тоо (сэдэв, оролцогчдын тоо гэх мэт)
- ЯМЭ-ийн холбогдох ажилтнуудаас доод шатлалын эмнэлгийнхэнл уншсан лекцийн тоо (сэдэв, хамруулсан эмнэлгийн нэр, оролцосон хүмүүсийн тоо гэх мэт)

Хавсралт материал

Хавсралт Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл

Хавсралт 1-1 Мэргэжилтэн томилон ажлуулсан
гүйцэтгэл

Хавсралт 1-2 Хамтрагч тал

Хавсралт 1-3 Японд зохион байгуулсан сургалтын
гүйцэтгэл

Хавсралт 1-4 Үйл ажиллагааны нарийвчилсан
төлөвлөгөө (өөрчилсөн хувилбар)

Хавсралт 1-5 Үйл ажиллагааны зураглал

Хавсралт 1-6 Эмнэлзүйн гүйцэтгэлийн харьцуулсан
хүснэгт (жишээ)

Хавсралт 1-7 Болзошгүй эгзэгтэй тохиолдол,
тохиолдлын формат

Хавсралт 2 Боловсруулсан материалын жагсаалт

Хавсралт 3 Төслийн төлөвлөлтийн матриц

Хавсралт 1-1 Мэргэжилтэн томилон ажиллуулсан гүйцэтгэл

1. Work in Mongolia

Name	Position	2019												2020												2021												2022										Days	Person-Month												
		May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov	Dec	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov	Dec	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov	Dec	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct																		
Minoru Irahara	Chief Advisor/Hospital Management (1)	5/20-24 (5days)	6/10-17 (8days)	7/21-25 (5days)	8/18-22 (5days)	9/29-30 (2days)	10/1-3 (3days)	12-26 (5days)																																			33	1.10																	
Masashi Akaike	Chief Advisor/Hospital Management (1)																																						9/12-16 (5days)	5	0.17																				
Hiroshi Aho	Deputy Chief Advisor/Hospital Management (2)/Training Management (1)	5/20-31 (12days)	6/10-16 (7days)	7/21-25 (5days)	8/18-22 (5days)	9/26-30 (5days)	10/1-13 (13days)	11/30 (1day)	12/7-14 (8days)	1/25-27 (3days)													3/15-31 (17days)	4/1-30 (30days)	5/1-18/26 (19days)		9/6-19/25/30 (26days)	10/1-20 (20days)		3/30-31 (2days)	4/1-30 (30days)	5/1-18 (18days)	6/15-30 (16days)	7/1-8 (8days)	9/12-16 (5days)	27-30 (4days)	279	9.30																							
Minoru Irahara	Hospital Management (Nursing /Patient Management, Emergency Medicine, Supply Processing & Distribution (SPD) (1)																																				5/1-18 (8days)	7/4-8 (5days)	9/12-16 (5days)	18	0.60																				
Takeshi Naito	Hospital Management (Nursing /Patient Management, Emergency Medicine, Supply Processing & Distribution (SPD) (2)																																								0	0.00																			
Takashi Higaki	Hospital Management (Hospital Infection Control, Medical Information system (IT) (1)	5/26-29 (4days)	7/21-24 (4days)	8/14-16 (3days)	9/30 (1day)	10/1-4 (4days)	12-26 (5days)																															9/12-16 (5days)	26	0.87																					
Hidemi Takada	Hospital Management (Hospital Infection Control, Medical Information system (IT) (2)																																							0	0.00																				
Yasumori Oka	Hospital Management (Hospital Infection Control, Medical Information system (IT) (3)	6/15-17 (3days)																																						3	0.10																				
Tomoko Takagai	Nursing/Patient Management (1)	6/15-18 (4days)			8/18-21 (4days)	9/29-30 (2days)	10/1-3 (3days)																																	13	0.43																				
Hiroko Kuno	Nursing/Patient Management (2)	5/20-24 (5days)																																					10	0.33																					
Rie Fujikawa	Emergency Medicine	8/10-30 (21days)	7/1-4 (4days)	7/28-28/3 (5days)	9/26-30 (5days)	10/1-20 (20days)	11/1-30 (30days)	12/1-20 (20days)		2/2-21 (20days)													6/8-30 (23days)	7/1-31 (31days)	8/1-30 (30days)	9/1-30 (30days)	10/1-8 (8days)						4/20-30 (11days)	5/1-20 (20days)	6/10-30 (21days)	7/1-25 (25days)	9/12-16 (5days)	320	10.67																						
Hisanichi Tsuchi	Hospital Infection Control (1)	5/26-29 (4days)	7/21-24 (4days)	8/14-16 (3days)	9/30 (1day)	10/1-4 (4days)	12-26 (5days)																															9/12-16 (5days)	21	0.70																					
Harutaka Aono	Hospital Infection Control (2)	5/26-29 (4days)	7/21-24 (4days)	8/14-16 (3days)	9/30 (1day)	10/1-4 (4days)	12-26 (5days)																															9/12-16 (5days)	13	0.43																					
Hiroshi Kimura	Hospital Infection Control (3)	5/26-29 (4days)	7/21-24 (4days)	8/14-16 (3days)	9/30 (1day)	10/1-4 (4days)	12-26 (5days)																															9/12-16 (5days)	13	0.43																					
Hiroshi Miyamoto	Hospital Infection Control (4)	5/26-29 (4days)	7/21-24 (4days)	8/14-16 (3days)	9/30 (1day)	10/1-4 (4days)	12-26 (5days)																															9/12-16 (5days)	13	0.43																					
Eizen Kimura	Medical Information system (IT) (1)	5/29-31 (3days)																																			6/13-17 (5days)	9	0.30																						
Teruhito Kido	Medical Information system (IT) (2)	5/26-29 (4days)	7/21-24 (4days)	8/14-16 (3days)	9/30 (1day)	10/1-4 (4days)	12-26 (5days)																																9	0.30																					
Satomi Sakita	Medical Information system (IT) (3)	5/26-29 (4days)	7/21-24 (4days)	8/14-16 (3days)	9/30 (1day)	10/1-4 (4days)	12-26 (5days)																																15	0.50																					
Masato Tazai	Medical Information system (IT) (4)	5/29-31 (3days)	7/29-31 (3days)	8/1-2 (2days)	9/26-30 (5days)	10/1-3 (3days)	11/7-28 (21days)	1/20-30 (11days)																															17	0.57																					
Daigo Sano	Medical Information system (IT) (5)	5/20-31 (12days)																																					64	2.13																					
Yasuo Akiyama	Supply Processing & Distribution (SPD)																																				9/15-30 (16days)	10/1-8/20-29 (18days)	5/18-31 (14days)	6/1-3 (3days)																				51	1.70
Takayuki Nakao	Clinical Examination	5/20-24 (5days)	6/12-19 (8days)	7/21-25 (5days)	8/18-24 (7days)	9/26-30 (5days)	10/1-3 (3days)	12-25 (4days)																														9/12-16 (5days)	42	1.40																					
Takayuki Nakao	Clinical Examination	5/20-24 (5days)	6/12-19 (8days)	7/21-25 (5days)	8/18-24 (7days)	9/26-30 (5days)	10/1-3 (3days)	12-25 (4days)																														7/4-8 (5days)	24	0.80																					
Yoshiaki Onishi	Medical Engineering	5/20-24 (5days)	6/12-19 (8days)	7/21-25 (5days)	8/18-24 (7days)	9/26-30 (5days)	10/1-3 (3days)	12-26 (5days)																														7/4-8 (5days)	29	0.97																					
Naonobu Kamata	Radiological Examination																																				7/4-8 (5days)	5	0.17																						
Akira Kitora	Hospital Finance	5/20-24 (5days)	6/12-19 (8days)	7/29-31 (3days)	8/1-2 (2days)	9/10-13 (4days)	12-26 (5days)																																22	0.73																					
Nobuyuki Hashimoto	Financial Management																																				8/20-31 (12days)	9/1-30 (30days)	10/1-31 (31days)	11/1-30 (30days)	12/1-15 (15days)	2/9-28 (20days)		6/3-30 (28days)	7/1-22 (22days)	187	6.23														
Akane Suzuki	Hospital Administration	5/20-24 (5days)	6/15-18 (4days)	7/21-25 (5days)	8/18-22 (5days)	9/29-30 (2days)	10/1-3 (3days)	12-25 (4days)																															17	0.57																					
Fumie Murasawa	Training Management (4) / Communication Skills	5/20-24 (5days)	6/10-17 (8days)	7/21-25 (5days)	8/18-22 (5days)	9/29-30 (2days)	10/1-3 (3days)	12-25 (4days)																														5/1-18 (18days)	7/4-8 (5days)	9/12-16 (5days)	50	1.67																			
Shino Nishimugi	Project Coordination (1)/Training Management (2)	6/9-29 (21days)	7/13-31 (19days)	8/1-3 (3days)																																	9/6-19/28/31 (17days)	10/1-20 (20days)	4/13-30 (18days)	5/1-20 (20days)	9/11-30 (20days)	152	5.07																		
Byohei Sakurai	Project Coordination (2)/Training Management (3)																																				1/25-31 (7days)	2/1-2/21 (21days)																				60	2.00		
Kaito Onishi	Project Coordination (2)/Training Management (3)																																				9/29-30 (2days)	10/1-31 (31days)	11/1-3 (3days)																				128	4.27	
Results																																						Results										1,648	54.94												

Хавсралт 1-2

Хамтрагч тал

Но.	Нэр	Албан тушаал
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль		
1	Н.Хүрэлбаатар	АШУУИС-ийн захирал
2	Б.Дамдиндорж	Эрдэм шинжилгээ, Гадаад харилцаа хариуцсан дэд захирал
3	Г.Батбаатар	Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дарга
4	Э.Содномжамц	Санхүү, эдийн засгийн газрын дарга
5	Я.Энхтөр	Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга
6	Б.Амартүвшин	Гадаад харилцааны газрын дарга
7	Х.Амартүвшин	Их сургуулийн эмнэлгийн хөгжлийн газрын, Эм зүйн албаны дарга
Монгол Японы Эмнэлэг		
8	М.Адилсайхан	Монгол-Японы Эмнэлгийн(МЯЭ) захирал
9	М.Наранпүрэв	МЯЭ-ийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
10	Б.Халиун	МЯЭ-ийн захиргаа санхүү эрхэлсэн дэд захирал
11	Б.Болортуяа	МЯЭ-ийн чанар аюулгүй байдал эрхэлсэн дэд захирал
12	Ж.Базарсүрэн	Захиргаа, хүний нөөцийн хөгжил, сургалтын албаны дарга
13	Т.Энхзаяа	Сувилахуйн албаны менежер
14	О.Гэрэлт-Од	Стратеги төлөвлөлт, мониторингийн албаны дарга
15	О.Мөнхзул	Мэдээлэл технологийн албаны дарга
16	Д.Эрдэнэчимэг	Бүртгэл, даатгал, статистикийн албаны дарга
17	М.Пүрэвдорж	Хангамж, түгээлтийн албаны дарга
18	Э.Энх-Үрэл	Тоног, төхөөрөмжийн албаны дарга
19	Ц.Дамдин	Ариутгал, угаалгын албаны дарга
20	Ц.Алтанзул	Санхүүгийн албаны дарга
21	С.Амарбаяр	Байгууламжийн менежмент, үйлчилгээний албаны дарга
22	У.Должин	Хоол, шим тэжээлийн албаны дарга
23	Д.Золзаяа	Халдварын сэргийлэлт, хяналтын албаны дарга
24	С.Элбэгзаяа	Эрсдэлийн удирдлагын албаны дарга
25	Ц.Оюунчимэг	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага, эмнэлгийн мэргэжилтний баталгаажуулалтын албаны дарга
26	Ц.Маналжав	Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч
27	Ц.Одгэрэл	Амбулаторийн эрхлэгч
28	Н.Батчимэг	Эмнэлзүйн төв лабораторийн эрхлэгч
29	Э.Баярмаа	Эмгэг судлалын тасгийн эрхлэгч
30	Д.Түвшинжаргал	Радиологийн тасгийн эрхлэгч
31	Д.Даваадорж	Дурангийн тасгийн эрхлэгч
32	Н.Нарангарав	Эм зүйн албаны дарга
33	Д.Мягмарцэрэн	Үйлчлүүлэгчийг дэмжих албаны дарга
34	А.Балжинням	Сэргээн засах анагаах ухааны төвийн дарга
35	З.Ануударь	Эрүүл мэндийг дэмжих төвийн дарга
36	Г.Ариунцэцэг	Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч

37	С.Бурмаа	Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч
38	В.Баатарсүрэн	Мэс заслын тасгийн эрхлэгч
39	С.Алтанчимэг	Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч
40	А.Товуудорж	Мэдрэлийн тасгийн эрхлэгч
41	П.Ганчимэг	Чих, хамар, хоолойн тасгийн эрхлэгч
42	Д.Уранчимэг	Нүдний тасгийн эрхлэгч
43	Т.Амартүвшин	Эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч
44	Ө.Цолмон	Зүрх судасны тасгийн эрхлэгч
45	Э.Эрдэнэтуяа	Хүүхдийн тасгийн эрхлэгч
46	Л.Билэгсайхан	Маркетингийн албаны дарга

Боловсруулсан: Төслийн баг

Хавсралт 1-3 Японд зохион байгуулсан сургалтын гүйцэтгэл

No.	Theme	Place	Date	Participants
1 st	Overview of the Japanese Hospital System	Tokushima University Ehime University	14 days June 25 to July 8, 2017	16 members MNUMS
2 nd	Hospital Management	Tokushima University	12 days October 22 to November 2, 2017	9 members MNUMS
3 rd	Nursing Management	Tokushima University	14 days November 12 to November 25, 2017	6 members MNUMS
4 th	Nosocomial Infection Control	Ehime University, Japanese Society of Environmental Infection	10 days from February 21 (Wed.) to March 2 (Fri.), 2018	4 members MNUMS
5 th	Hospital Information System	PSP Corporation	17 days February 21 to March 9, 2018	IT team: 4 members MNUMS
		PSP Corporation, Ehime University	10 days February 21 to March 2, 2018	Physician team: 3 members MNUMS
6 th	Hospital Management (Clinical Laboratory Technology and Clinical Engineering Technology)	Tokushima University	7 days February 25 to March 3, 2018	6 members MNUMS
7 th	Hospital Management (Simulation Planning)	Tokushima University	8 days July 22 to July 29, 2018	9 members MNUMS
8 th	Nosocomial Infection Control	Ehime University	7 days September 2 to September 8, 2018	6 members MNUMS
9 th	Observation training	ICA Headquarters Tokushima University	7 days September 2 to September 8, 2018	3 officials MNUMS
10 th	Team Medicine (Surgical Section)	Tokushima University	5 days November 18 to November 22, 2019	8 members MJH
11 th	Team Medicine (Patient Support Center/ICU)	Tokushima University	5 days November 18 to November 22, 2019	5 members MJH
12 th	Hospital management (financial management, logistics management, nursing/patient management, risk management, hospital information system and nosocomial infection control)	Tokushima University Ehime University	7 days from August 17 to 24, 2022	9 members MJH

Source: Project Team


Хавсралт 1-4 Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө (ажлын шат дараалал)

Work Schedule

Items	Phase Year Month No. (Phase-based) No. (for all)	Second Year																																															
		2019												2020												2021												2022											
		5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12				
<Second Year: May 2019 - January 2022>																																																	
(1) Preparation and discussion of work plan (2nd year)																																																	
(2) Activities for Output 1: Appropriate management is implemented in MJTH (Mongolia-Japan Teaching Hospital)																																																	
[1-1: Construction of functional organization of MJTH]																																																	
1-1-4: To develop post-graduate training systems for medical professionals																																																	
[1-2: Sound management of MJTH]																																																	
1-2-4: To provide technical support in bylaws-based practical operation newly established																																																	
1-2-5: To support the medical informatics division to promote practical (continue from the 1st																																																	
1-2-6: To develop a physical distribution management system (PDMS) for medicines, medical																																																	
(3) Activities for Output 2 (Patients-centered medical services are provided)																																																	
[2-1: Introduction of team-approached patient management system]																																																	
2-1-1: To conduct Trainings in Japan for patient management geared to eligible medical																																																	
2-1-3: To conduct in-hospital trainings for MJTH staff on the team-approached patient																																																	
2-1-5: To phase the team-approached patient management to all clinical departments after the opening of MJTH on the basis of the results of the trial introducer																																																	
[2-2: Standardization of medical services]																																																	
2-2-3: To phase the standardization of medical services using clinical pathways to all medical departments after the opening of MJTH, on the basis of the results of the trial introducer																																																	
[2-3: Risk Management of medical care]																																																	
2-3-3: To perform regular monitoring activities at the initiative of the risk management committee																																																	
[2-4: Prevention and control of nosocomial infections]																																																	
2-4-4: To perform regular monitoring on the compliance with the guidelines and/or regulations at																																																	
(4) Activities for Output 3 (Advanced medical services are provided in MJTH)																																																	
3-2: To conduct Training in Japan for eligible medical staff in accordance with the plan																																																	
3-3: To conduct training debriefings, intra-/inter-department study meetings, etc. for promoting technology sharing (continue from the 1st Year)																																																	
(5) Activities for Output 4 (Advanced emergency medical services (EMS))																																																	
4-1: To conduct trainings of operational management, which include staffing and financial																																																	
4-3: To incorporate findings and experiences of the EMS in MJTH on the lectures in MNUMS																																																	
4-4: To widely share the findings and experiences of EMS in MJTH with medical professionals																																																	
(6) Preparation of the Project Progress Report																																																	
<Activities for all periods>																																																	
(1) Holding meetings for information sharing (including Joint Coordinating Committee)																																																	

Remarks: Work in Mongolia Work in Japan Preparation and Discussion of Reports Continuing Work

Хавсралт 1-5 Үйл ажиллагааны зураглал



2022 оны эмнэлзүйн гүйцэтгэлийн харьцуулсан хүснэгт (сарын гүйцэтгэл)

8 -р

	Хуудас
■ Орлого	. . . 2
■ Үйл ажиллагааны дүн	. . . 3
■ [ХЭТ] •Үйл ажиллагааны дүн•Эмнэлзүйн нэгж дүн•Нийт үйлчлүүлэгчийн тоо•Ор а шиглалтын хувь (АУ)	. . . 4
■ [Амбулатори] •Үйл ажиллагааны дүн•Эмнэлзүйн нэгж дүн•Нийт үйлчлүүлэгчийн тоо•Нэг өдөрт үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо (АУ)	. . . 5
■ Шинэ үйлчлүүлэгчийн тоо (АУ)	. . . 6
■ Хагалгааны тоо	. . . 7
■ Хагалгааны тоо (Тасаг нэгж тус бүрээр)	. . . 8
■ Тасаг нэгж тус бүрээр үйл ажиллагааны дүнг харьцуулсан хүснэгт (АУ) өс сөн дүн	. . . 9
■ Тасаг нэгж тус бүрээр үйл ажиллагааны дүнг харьцуулсан хүснэгт (АУ) өс сөн дүн	. . . 10

◆ Орлогын дүн (Бэлэн мөнгөний дүн)



нэгж: 1000 Төгрөг

Ангилал	1сар	2сар	3сар	4сар	5сар	6сар	7сар	8сар	9сар	10сар	11сар	12сар	Гүйцэтгэлийн дүн	Жилийн нийт дүн	
2021 он	Гүйцэтгэл	673,735	318,533	690,847	2,117,008	632,251	1,233,836	907,902	1,031,553	1,560,252	994,367	1,494,146	1,832,892	7,605,665	13,487,322
2022 он	Төлөвлөсөн зорилтын дүн	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	15,145,956	22,718,934
	Гүйцэтгэл	1,627,139	130,714	2,527,640	976,905	2,435,741	1,710,008	939,596	1,474,377	0	0	0	0	11,822,121	11,822,121
	Өмнөх оны харьцуулалт	953,404	▲ 187,819	1,836,793	▲ 1,140,102	1,803,491	476,172	31,694	442,824	▲ 1,560,252	▲ 994,367	#####	#####	4,216,456	
	Төлөвлөсөн зорилтын харьцуулалт	▲ 266,106	▲ 1,762,530	634,396	▲ 916,339	542,497	▲ 183,237	▲ 953,648	▲ 418,868	▲ 1,893,244	#####	#####	#####	▲ 3,323,835	
	Төлөвлөсөн зорилтын харьцуулалт	86%	7%	134%	52%	129%	90%	50%	78%	0%	0%	0%	0%	78%	52%

Задаргаа

Ангилал	1сар	2сар	3сар	4сар	5сар	6сар	7сар	8сар	9сар	10сар	11сар	12сар	Гүйцэтгэл	Жилийн нийт дүн	
2021 он	Эрүүл мэндийн даатгал	263,620	188,300	536,973	609,158	298,066	918,772	541,639	667,361	1,076,896	346,945	1,066,102	887,388	7,401,220	7,401,220
	ЭМДСангаас бусад улсын төсөв	291,666	0	0	624,517	261,600	212,800	288,000	240,000	350,000	448,720	170,240	612,457	3,500,000	3,500,000
	Үндсэн үйл ажиллагаа	104,344	108,761	132,617	45,932	64,020	91,683	70,980	118,382	127,546	192,065	251,993	326,637	1,634,960	1,634,960
	Бусад орлогын дүн	13,766	20,734	21,258	837,400	482,750	7,810	7,283	5,810	5,810	6,638	5,810	6,410	1,421,479	1,421,479
	Нийт	673,396	317,795	690,848	2,117,007	1,106,436	1,231,065	907,902	1,031,553	1,560,252	994,368	1,494,145	1,832,892	13,957,659	13,957,659
2022 он	Эрүүл мэндийн даатгал	1,204,351	0	2,347,702	640,241	1,188,134	1,521,079	575,361	766,688	0	0	0	0	8,243,556	8,243,556
	ЭМДСангаас бусад улсын төсөв	256,740	0	0	0	976,740	0	240,000	480,000	0	0	0	0	1,953,480	1,953,480
	Үндсэн үйл ажиллагаа	160,238	124,904	173,978	327,045	263,721	183,234	116,615	219,595	0	0	0	0	1,569,330	1,569,330
	Бусад орлогын дүн	5,810	5,810	5,960	9,620	7,147	5,695	7,620	8,094	0	0	0	0	55,756	55,756
	Нийт	1,627,139	130,714	2,527,640	976,906	2,435,742	1,710,008	939,596	1,474,377	0	0	0	0	11,822,122	11,822,122
Өсөлт бууралт	Эрүүл мэндийн даатгал	940,731	-188,300	1,810,729	31,083	890,068	602,307	33,722	99,327	-1,076,896	-346,945	-1,066,102	-887,388	842,336	842,336
	Гатаас	-34,926	0	0	-624,517	715,140	-212,800	-48,000	240,000	-350,000	-448,720	-170,240	-612,457	-1,546,520	-1,546,520
	Үйлчлүүлэгч төлөх дүн	55,894	-14,924	-15,298	-827,780	-475,603	-2,115	337	2,284	-5,810	-6,638	-5,810	-6,410	-1,365,723	-1,301,873
	Бусад орлогын дүн	-7,956	-14,924	-15,298	-827,780	-475,603	-2,115	337	2,284	-5,810	-6,638	-5,810	-6,410	-2,135,537	-1,365,723
	Нийт	953,743	-218,148	1,780,133	-2,248,994	654,002	385,277	-13,604	343,895	-1,438,516	-808,941	-1,247,962	-1,512,665	-7,401,220	-3,371,780

9 - АН



◆ Үйл ажиллагааны дүн (Олсон мөнгөний дүн)



нэгж: 1000 Төгрөг

Ангилал		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Гүйцэтгэл	Жилийн нийт дүн
2021 он	Гүйцэтгэл	536,640	428,031	783,075	1,261,367	1,242,439	932,589	945,586	1,036,479	1,495,072	1,412,168	1,211,412	1,011,749	7,166,207	12,296,607
2022 он	Төлвлөсөн зорилтын харьцуулалт	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	1,893,244	15,145,956	22,718,934
	Гүйцэтгэл	1,842,812	1,080,518	1,089,000	1,421,404	1,374,744	545,857	1,575,519	1,403,199	0	0	0	0	10,333,053	10,333,053
Өмнөх оны харьцуулалт		1,306,172	652,487	305,925	160,036	132,305	▲ 386,732	629,933	366,720	▲ 1,495,072	▲ 1,412,168	▲ 1,211,412	▲ 1,011,749	3,166,846	
